

НЭГ. БОДЛОГЫН УДИРДАМЖААР ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН:

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхэлсэн асуудлын хүрээнд тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд анхаарч, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2008 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл”-д нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгохоор тусгагдсан хуулийн төслүүдийг эцэслэн боловсруулж, шийдвэрлүүлэхэд ихээхэн хүчин чармайлт гарган ажиллалаа.

1.1. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын үр дүн:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгайлсан үйлчилгээ, арга хэмжээ бий болгох зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орууллаа. Уг хуулиар хөдөлмөрийн зах зээлд бие даан оролцох боломжгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор байгуулагдсан хөдөлмөр сургалтын төв, аж ахуйн нэгж байгууллагын дэргэдэх үйлдвэрлэлийн тусгай цех, тасгийн үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөрт бэлтгэх, мэргэжлийн сургалтад хамруулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажилд авсан ажил олгогчдыг урамшуулёйа Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэхээр болов.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд 2001 онд батлагдсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн байдалд заалт бүрээр үнэлгээ хийж үзэхэд хангалттай сайн биелэсэн 55,6 хувь, дунд биелэлтэй 19,9 хувь, хангалтгүй биелэлтэй 11,2 хувь, үнэлэх боломжгүй 13,3 хувь байна. Хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал, хуулийн хэрэгжилтийн үнэлгээнд үндэслэн “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэлбэрүүдийг оновчтой болгох”, “Сургуулиас ажилд шилжиж байгаа 16-25 насны залуучууд, 45-аас дээш насны иргэд, малчид, албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зорилтот бүлэг болгон тодорхойлж тэдгээрт тохирсон хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээг боловсронгуй болгох”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд Ажилгүйдлийн даатгалын сангийн хөрөнгийн тодорхой хэсгийг зарцуулах”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлоготой нягт уялдуулж, хөрөнгө оруулалт, тэтгэвэр тэтгэмж, зээл тусламжийн талаарх хууль тогтоомжийг хянаж нийцүүлэх” зэрэг чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулж, хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулаад байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн төслийг УИХ-ын хаврын чуулганаар батлуулав. Хууль батлагдснаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зохицуулалт нь бүх шатны байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд хүрч, хөдөлмөрийн харилцаанд оролцогчдын эрх үүрэг тодорхой болж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлыг удирдан зохион байгуулах, хянах, осол өвчлөлөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн тогтолцоо бий болгох боломж бүрдлээ.

Худалдаан дахь аж үйлдвэрийн хяналтын тухай 161, Эрүүл ахуйн хяналтын тухай 81 дүгээр Конвенцүүдийг соёрхон батлуулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-ын

Аюулгүй байдлын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэв. Конвенциудыг Монгол Улс соёрхон баталснаар одоогийн хэрэгжүүлж буй хөдөлмөрийн хяналтын болон эрүүл ахуйн үйл ажиллагааны үр дүн сайжирч, дотоодын болон Олон улсын нээлттэй, сайн засаглалын нэг болзлыг хангаж буйн үзүүлэлт болохын зэрэгцээ ОУХБ-аас үзүүлдэг техникийн болоод бодлогын зөвлөмж, дэмжлэг, хамтын ажиллагааны цар хүрээ өргөжих ач холбогдолтой юм.

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн барьсан боловч шинээр байгуулагдсан УИХ-аар хэлэлцүүлэхээр хуулийн төслийг татан авч, НХХ-ийн сайдын тушаалаар дахин ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Гадаад хөдөлмөр эрхлэлтийн бодлого, практик амьдрал учирч буй зарим бэрхшээл, түүнийг шийдвэрлэхдүе холбогдуулан уг хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулахдд сдд нэмэлт оруулж, НҮБХХ-тэй хамтран зохион байгуулсан “Гадаад хөдөлмөр эрхлэлтийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох асуудлаарх” зөвлөлдөх уулзалтын үеэр хэлэлцүүлэн гарсан санал, зөвлөмжүүдийг хуулийн төсөлд тусган Засгийн газарт оруулахаар бэлтгээд байна.

Монгол Улсын Засгийн газар, БНАСАУ-ын Засгийн газар хооронд байгуулсан “Ажиллах хүч харилцан солилцох тухай” хэлэлцээрийг батлах тухай Монгол Улсын хуулийн төслийг Засгийн газрын болон УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж, батлуулав. “Ажиллах хүч харилцан солилцох тухай” Монгол Улсын Засгийн газар, БНАСАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр соёрхон батлагдсанаар 2002 оны 8 дугаар сарын 8-ны өдөр байгуулсан “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс хоорондын хэлэлцээр”-ийн агуулга, зарчимд тулгуурлан хоёр улсын эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжих, иргэд харилцан хөдөлмөр эрхлэх таатай нөхцөл бүрдлээ. Мөн зарим салбарт дотоодын хөдөлмөрийн зах зээлээс хангах боломжгүй байгаа өндөр мэргэшлийн, зохион байгуулалт сайтай, хямд ажиллах хүч, мэргэжилтнийг БНАСАУ-аас авах, тэднийг монгол иргэд дагалдан сурах, түүнчлэн газар тариалан, барилга, замын салбарын технологийг монголд нэвтрүүлэх зэрэг практик ач холбогдолтой гэж үзэж байна.

“Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай” хуулийн 4.1.4-т заасны дагуу эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байгууллагын нийт ажиллагчдын тоо, гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамааруулан нийт ажиллагчдын тоонд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг жил бүр тогтоож байхыг үндэслэн “2008 онд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай” Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, холбогдох яамдын саналыг авч тусган Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 75 дугаар тогтоолоор батлуулав. 2008 онд зарим салбарт ажиллах гадаадын иргэдийн тоог нэмэгдүүлэх /10 хувиар/; мэргэжлийн ур чадвар шаардагдах эдийн засгийн үйл ажиллагааны зарим салбарыг нэмж оруулах; бүлэг, дэд бүлэг тус бүрт гадаадаас авах ажиллах хүч мэргэжилтний хувийг ялгаатай тогтоох; дотооддоо мэргэжлийн ур чадвартай ажилтан бэлтгэгдсэн гэж үзээд зарим салбаруудад гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг бууруулж тогтоох /5-15 хувиар/-оор нэмэлт, өөрчлөлтийг тусган хэрэгжүүлэв.

“2008 онд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай” Засгийн газрын 2008 оны 75 дугаар тогтоолоор “Гадаадын зээл, тусламж болон

дотоодын хөрөнгө оруулалт, санхүүжилтээр улсын хэмжээний томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, зам, барилга байгууламж барихад энэ тогтоолд заасан хувийг баримтлах боломжгүй бол Засгийн газарт танилцуулан шийдвэрлүүлж байхаар заасны дагуу тухай бүр Засгийн газарт асуудлыг танилцуулж, Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгосон ажилтнуудаас шаардлагатай тооны ажилтны ажлын байрны төлбөрийг чөлөөлүүлэх асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 2008 оны 76, 125, 135, 158, 283 дугаар тогтоолуудаар шийдвэрлүүлсэн байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг БСШУЯ-тай хамтран боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барьсан боловч шинээр байгуулагдсан УИХ-аар хэлэлцүүлэхээр хуулийн төслийг татан авч, ажлын хэсгийг шинээр байгуулан ажиллав. Мэргэжлийн сургалт, боловсролын тогтолцоог боловсронгуй болгох, төрийн болон хувийн хэвшлийн оролцоотой Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөлийг байгуулан нэгдсэн удирдлагаар хангах, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийг шинэ тоног төхөөрөмжөөр хангах, сургагч багш нарын үр чадварыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн сургалтын стандарт, чанарыг сайжруулах зэрэг асуудлыг шинэчилсэн найруулгын төсөлд тусгав.

1.2. Төрийн албан хаагчдын цалин хөлс, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэх бодлогын үр дүн:

Төрийн албан хаагч болон төсөвт байгууллагад ажиллагчдын үндсэн цалинг эдийн засгийн өсөлт, инфляцийн түвшин, төсөвт байгууллагын зардлын хэмнэлттэй уялдуулж, 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 28.5 хувиар нэмэгдүүлж, төрийн албан хаагчдын дундаж цалинг 300.0 мянган төгрөгт хүргэх арга хэмжээ авлаа.



Ингэхдээ Төрийн албаны тухай хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй уялдуулан төрийн тусгай албан тушаалаас бусад албан тушаалын ажилтнуудын нийгмийн даатгалын бүх төрлийн шимтгэлийн болон эрүүл мэндийн даатгалын хураамжийн төрийн байгууллагын төсвөөс нөхөн төлж байсан 80-аас доошгүй хувийг үндсэн цалинд нь шингээн тооцож оруулсан болно.

Цалин нэмэгдүүлэх арга хэмжээнд 129773 төрийн албан хаагч болон 18712 гэрээт ажилчин хамрагдсан бөгөөд 2008 оны суурь цалингийн сан 109.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 556.9 тэрбум төгрөг болсон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 350 дугаар тогтоолоор Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2008 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэг цагт 642 төгрөг 85 мөнгө буюу сард 108000 /нэг зуун найман мянган/ төгрөг байхаар шинэчлэн тогтоолоо.

Төрийн албан хаагчийн цалин хөлсний асуудлыг иж бүрнээр шийдвэрлэх зорилгоор төрийн албан хаагчийн ангилал, зэрэглэл, цалин хөлсний бүтэц, нийгмийн баталгааны цэгцтэй бодлогыг тодорхойлж, Төрийн албаны тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжийг судалж, шийдвэрийн төсөл боловсруулах ажлын хэсгийг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан тушаалаар байгуулан ажиллалаа. Ажлын хэсгийн хүрээнд төрийн зарим албан хаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг хянах, норм, нормативыг боловсруулах, цалин хөлсний тогтолцоог боловсронгуй болгох, салбар салбарын хуулинд тусгагдсан нийгмийн баталгаатай холбоотой асуудлуудыг судалж, тооцоо судалгаа хийв. Түүнчлэн улс төрийн болон төрийн тусгай албан тушаалын ангилал зэрэглэлийг шинэчилсэн төсөл, төрийн албан хаагчид олгох нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшууллын журам болон ажилласан жил тооцох журмын төсөл боловсруулж, Засгийн газарт оруулахаар бэлтгэв.

1.3. Нийгмийн хамгааллын талаарх бодлого, үр дүн:

Төрөөс иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулах бодлогын зайлшгүй бүрэлдэхүүн хэсэг нь нийгмийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох, ялангуяа Монгол орны онцлогт нийцсэн тэтгэврийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх асуудал байдаг бөгөөд 2008 онд эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр ажиллав.

“Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай”, “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай”, “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслүүдийг УИХ-ын 2008 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж, батлуулав.

Эдгээр хуулиудад орсон өөрчлөлтийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн бие даасан байдлыг дээшлүүлэх, хуримтлал бий болгох, Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг эргэлтэд оруулах, санхүүгийн удирдлагыг боловсронгуй болгох чиглэлээр зарчмын томоохон өөрчлөлт гарсан. Одоогийн мөрдөж байгаа хуулиар Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг зөвхөн арилжааны банкинд хадгалуулж, хүүгээр нь арвижуулдаг байсан бол Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулснаар хуримтлалын сан бүрдүүлэх эрх зүйн орчин бүрдсэн юм. Ингэснээр хуримтлалын санг эргэлтэд оруулах Засгийн газрын бонд худалдан авах эрхтэй болов. Мөн Монгол банкнаас гаргадаг үнэт цаасыг худалдан авдаг эрх зүйн үндсүүдийг бий болгож, ингэснээр нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл эргэлтэд орох, нийгмийн даатгалын сан өөрөө өөрийгөө

арвижуулж, өсч, хуримтлал бий болж байх, цаашдаа эдийн засгийн хувьд бие даасан байдлыг нь хангах эх үүсвэр тавигдлаа.

Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг бууруулсантай холбогдуулан даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлэх, шимтгэл ногдуулах цалин хөлсний бүрэлдэхүүнийг хуульчлан тогтоох, Сангийн төсөв төлөвлөлтийн тогтолцоог сайжруулах зэрэг асуудлыг зохицуулан хуульчилж өглөө. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн хүрээнд 1995 оноос өмнө тэтгэврээ тогтоолгосон боловч үргэлжлүүлэн ажилласан ахмадуудын ажилласан жилийг нэмэгдүүлэх замаар тэтгэврээ шинэчлэн тогтоолгох эрхийг нээсэн. Өөрөөр хэлбэл 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэд хэрвээ үүнээс хойшхи жилүүдэд ажил алба эрхлээд шимтгэл төлж байсан бол тэтгэврээ шинэчлэн тогтоолгох эрх зvйн орчин бүрдэж байна. Мөн сонгодог болоод мэргэжлийн урлагийн байгууллагад ажиллаж буй уран бүтээлчид хөнгөлөлттэй нөхцөлд тэтгэвэр тогтоолгох эрх зvйн үндсийг шинээр бүрдүүлэв. Үүнд балетийн бүжигчин, циркийн акробатчин, амьтан сургагч зэрэг нарийн мэргэжлийн сонгодог болоод мэргэжлийн урлагийн байгууллагад ажиллаж байгаа хvмүүс улсад нийт 25-аас доошгvй жил ажилласан, үүнээс тухайн мэргэжлээрээ 15-аас доошгvй жил ажилласан бол нас харгалзахгvй хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэврээ тогтоолгож болох юм.

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулиар Нийгмийн даатгалын санд шимтгэл төлж байгаа, тэндээс тэтгэвэр тэтгэмж авах эрх нь үүссэн цэргийн байгууллагад ажиллаж байгаа эхчүүд Нийгмийн даатгалын сангаас тэтгэмж авах эрхтэй боллоо. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тэтгэмж авах эрх нь үүссэн эхчүүд одоогийн мөрдөж байгаа хуулиар жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг дөрвөн сарын хугацаатай цалингийнхаа 70 хувиар авдаг байсан бол хуульд орсон өөрчлөлтөөр нийгмийн даатгалын санд шимтгэлийг 12 сараас доошгvй хугацаанд төлж эрх үүссэн нийт эхчүүд жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг дөрвөн сарын хугацаатай цалингийнхаа 70 биш 100 хувиар авдаг байхаар боллоо. Мөн тэтгэмжийн даатгалын сангаас олгох хөдөлмөрийн чадвар алдалтын тэтгэмжийн хэмжээг 45 байсныг 50 хувиар шинэчлэн тогтоосон болно.


Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг уг сангаас гаргахаар тусган аж ахуйн нэгж, байгууллага урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг 0.3-1.0 хувиар гаргахаар боллоо.

Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ буурсантай холбогдуулан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг 2 ба 3 хувиар төлөх ажил олгогчийн жагсаалт батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 142 дугаар тогтоолоор батлуулав. Шимтгэлийн хувь хэмжээг тогтоохдоо үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийн байдал болон хөдөлмөрийн нөхцлийг харгалзан үзсэн болно. Энэхүү тогтоол батлагдсанаар нийт 2907 байгууллага үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын шимтгэлийг 2-3 хүртэлх хувь хэмжээгээр төлөх бөгөөд нийт 4.3 тэрбум шимтгэлийн орлого санд орох урьдчилсан тооцоог гаргав.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2008 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл, 2008 оны Төсвийн тухай хуулийн дагуу 2008 оны 1 дүгээр сарын 1-нээс Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг 20 хувиар нэмэгдүүлэх асуудлыг судлан тооцоо судалгаа хийсний үндсэн дээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэв. Тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээнд 293.7 мянган хүн хамрагдаж нийт 55.0 тэрбум төгрөгийн нэмэлт эх үүсвэрийг 2008 оны төсөвт тусгуулав. Энэхүү арга хэмжээний дүнд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээ 20 хувь нэмэгдэж, бүрэн тэтгэврийн доод хэмжээ 81000 төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 54000 төгрөг тус тус боллоо. Уг тогтоолын хэрэгжилтийг хангуулах зорилгоор тэтгэврийн нэмэгдлийг 2008 оны 1 дүгээр сарын 1-нээс тэтгэвэр авагч нарын тэтгэвэр дээр нэмж олгох арга хэмжээ авах талаар УНДЕГ-газарт үүрэг даалгавар өгч ажиллав. Дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлснээр 2008 онд нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн дундаж хэмжээ 96.7 мянган төгрөгт хүрч 2007 оныхоос 20 хувиар нэмэгдлээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийг амьжиргааны түвшин, инфляцийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлж, нэг жилд олгох санхүүжилтийн хэмжээг 6 дахин өсгөж 2008 онд 337.4 тэрбум төгрөгт хүргэлээ. Өндөр насны тэтгэвэр авч байгаа иргэдийн тэтгэвэр нь тэдний хамгийн чухал орлогын эх үүсвэр тул төрөөс тэтгэврийн үр ашигтай бодлого, шинэчлэлийг хэрэгжүүлэх тал дээр анхаарч тэтгэврийн хэмжээг тухай бүр нэмэгдүүлж ирсэн бөгөөд 2000-2008 оны хооронд 4.42 дахин өссөн байна.

Тэтгэврийн дундаж хэмжээ / тэтгэврийн төрлөөр/




Эх үүсвэр: НХХЯ, УНДЕГ-ын санхүүгийн тайлан, 2000-2008 он

Нийгмийн даатгалын сангаас дээрх графикт үзүүлсэн төрлөөр тэтгэвэр, тэтгэмжийг олгодог. Үүнд тэтгэврийн даатгалын сангаас буюу өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, цэргийн алба хаасны тэтгэвэр, цэргийн тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас олгох тэтгэврийн төрлүүд тус тус багтдаг болно. 2000-2008 оны хооронд өндөр насны тэтгэврийн хэмжээ 4.3 дахин, цэргийн тэтгэвэр 3.7 дахин, ҮОМШӨ-ний даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээ 5.3 дахин тус тус өссөн байна. Нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэврийн хэмжээг инфляци, хэрэглээний үнийн индекс, төрийн албан хаагчдын

дундаж цалин хөлс, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, амьжиргааны баталгаажих доод түвшин, амьжиргааны өртөг зэрэг үзүүлэлттэй уялдуулан нэмэгдүүллээ.


Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэрт зарцуулсан хөрөнгийн хэмжээ



Эх үүсвэр: НХХЯ, УНДЕГ-ын санхүүгийн тайлан, 2000-2008 он

Тэтгэврийн хэмжээ

/ дундаж тэтгэвэр, бүрэн, хувь тэнцүүлсэн тэтгэвэр /



Эх үүсвэр: НХХЯ, УНДЕГ-ын санхүүгийн тайлан, 2000-2008 он

Тэтгэврийн зөрүүг үе шаттайгаар арилгах арга хэмжээг 2005 оноос хойш авч ирлээ. Засгийн газрын 2007 оны 109 дугаар тогтоолын нэг онцлог нь урьд Засгийн газраас тэтгэврийн зөрүүг арилгах арга хэмжээний үргэлжлэл болсон бөгөөд үүнд 1995 оноос өмнөх цалин хөлсөөрөө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэвэр тооцох цалингийн итгэлцүүрийг нэг ангилалд оруулан, өнөөгийн үнэ ханштай харьцангуй ойртуулсан юм. Тэтгэврийн зөрүүг ойртуулах ойлголт нь зах зээлийн харилцааны нөхцөлд ихээхэн хамааралтай байсан бөгөөд иргэд хэд хэдэн ажлыг хавсран

гүйцэтгэж тэтгэвэр тогтоолгож цалингаа нэмэгдүүлэх боломж 1990 оноос нээгдсэн учраас нэг мэргэжлийн, адил хугацаанд ажилласан иргэд цалингийн ялгаатай байдлаас хамааран адил хэмжээтэй тэтгэвэр тогтоолгох үндэслэлгүйтэй холбоотой байсан юм.

Тухайлбал багш, эмч гэх мэт хүмүүс өөр ажлыг хавсран гүйцэтгэж орлогоо нэмэгдүүлснээр их цалингаас өндөр тэтгэвэр тогтоолгох боломжтой юм. Харин нэг төрлийн ажил, албан тушаалыг адил хугацаанд хашиж байсан хүмүүс өөр ажлыг хавсран гүйцэтгээгүй зөвхөн тэр албан тушаалын цалингаараа тэтгэвэрээ тогтоолгосон бол ойролцоо хэмжээтэй тэтгэвэр тогтоогдох боломжтой болсон юм. Тэтгэврийн зөрүүг арилгах арга хэмжээнд нийт тэтгэвэр авагчдын 46.7 хувь буюу 134.6 мянган хүн хамрагдаж тэдний тэтгэвэр дунджаар 15.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

УИХ-ын НББСШУ-ны байнгын хороо болон Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу Засгийн газрын тэтгэврийн санд дутуу санхүүжүүлж ирсэн хөрөнгийн тооцоог нэгтгэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Сангийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан тушаалаар байгуулж ажилласны дүнд “Нийгмийн даатгалын сангийн бие даасан байдлыг хангах, сангийн хөрөнгийн менежментийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2008 оны 139 дүгээр тогтоолыг батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулж байна.

Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8.1.12 дахь заалтын дагуу Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг жил бүр Засгийн газар баталдаг. 2009 оны шимтгэлийн хэмжээг өмнөх оны түвшинтэй адил байлгах аар Засгийн газрын тогтоолын төслийг ЭМЯ-тай хамтран боловсруулж, яамдын санал авч тусган Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэв. Тогтоолд аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны сар тутам төлөх эрүүл мэндийн даатгалын хувь хэмжээг түүний хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4 хувь, төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хариуцдаг даатгуулагч болон их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн өдрийн ангийн суралцагч, малчин, ял эдэлж байгаа хоригдол, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.11 -д заасан иргэний эрүүл мэндийн даатгалын сарын хураамжийг 500 төгрөгөөр, гадаадын иргэн, харьяалалгүй хүний сарын хураамжийг 4000 төгрөг байхаар зааж өглөө.

“Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-ийг шинэчлэн боловсруулж, Засгийн газрын 2008 оны 304 дүгээр тогтоолоор батлуулав. Дүрэмд эмнэлэг магадлах комиссын үйл ажиллагааг хөгжлийн бэрхшээлтэй иргэний сэтгэл зүй болон нийгэм хамт олонд түшиглэсэн нөхөн сэргээлт, эрүүл хүний нэгэн адил нийгмийн харилцаанд оролцох боломжийг дэмжиж ажиллуулахаар зааж өгөв. Эмнэлэг хөдөлмөр магадлах төв комиссын бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон даатгуулагчдын эрх ашиг хамгаалах байгууллагын төлөөллийг оролцуулан 9-11 болгон нэмэгдүүлсэн ба орон тооны магадлагч эмчтэй байхаар тусгасан байна.

Нийгмийн халамжийн тухай багц хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын хаврын чуулганаар хэлэлцүүлж батлуулав. Нийгмийн халамжийн багц хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулснаар хөдөлмөрийн чадвараа 50-70 хүртэл хувиар алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэжээгч нь нас барсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд, бүтэн өнчин хүүхэд, ихэр хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээнд

хамруулах болсон нь эдгээр иргэдийн амьжиргаанд нөлөөлөх нааштай үзүүлэлт болов.

Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь төрөөс зайлшгүй анхааран туслах шаардлагатай нийгмийн эмзэг хэсэг мөн боловч тодорхой тусламж, дэмжлэгт хамрагдахад байнга ядуу, нэн ядуу гэсэн хатуу шалгуур тавьж тусламж дэмжлэгт хамруулахгүй байгаа байдлыг судлан ядуу, нэн ядуу гэсэн шалгуурыг хасаж ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дэмжлэг туслалцааг үзүүлэх боломжийг нэмэгдүүлэв. Өөрөөр хэлбэл, нийгмийн халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмжид хамрагдах нөхцөл, болзлыг зөөлрүүлэх, нийгмийн халамжид хамрагдах иргэнийг амьжиргааны түвшингээр бус нийгмийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардагдах тусгай хэрэгцээгээр нь тодорхойлохоор болсон байна.

Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдэд ажлын идэвх оролцоог нь харгалзан улиралд нэг удаа урамшуулал олгох, үйл ажиллагааны зардлыг нь халамжийн сангаас санхүүжүүлэх заалт нэмсэн нь орон нутгийн захиргааны болон хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоог хангасан, Амьжиргааг дэмжих зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулж идэвхижүүлэх, хуульд заасан үүргээ биелүүлэх, хариуцлага тооцох боломжийг бүрдүүлж өгсөн байна.

Нийгмийн халамжийн багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг хэрэгжүүлэх зорилгоор холбогдох журам, дүрмүүдийг шинэчлэн боловсруулж, “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”, “Тусламж, хөнгөлөлтийн хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын тогтоолын төслүүдийг боловсруулж, яамдын санал авч тусган Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэв. Тухайлбал,

Халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох журамд хуульд заасан тэтгэвэр тэтгэмжийг иргэдэд хүргэхдээ хүнд сурталгүй үйлчлэх, үйлчилгээг хүртэх ёстой эзэнд нь хүргэх, иргэдийг ямар нэг шалтгаанаар хууль бусаар хохироохгүй байлгах асуудлыг анхаарсан болно. Тухайлбал, тэтгэвэр, тэтгэмж нь эзэндээ хүрч байгаа эсэхэд тавих олон нийтийн хяналтыг сайжруулах үүднээс тусламж, үйлчилгээнд хамрагдах иргэдийг сум, томоохон баг, хороодын дэргэдэх нутгийн захиргааны болон иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн Амьжиргааг дэмжих зөвлөл тодорхойлох, энэхүү зөвлөлийн шийдвэр болон нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалт олон нийтэд нээлттэй ил тод байх асуудлыг тусгаж өгөв. Иргэдийн хүсэлтийг шийдвэр гарсан өдрөөс эхлэн олгож байгааг өөрчлөн тухайн иргэний өргөдөл гаргасан өдрөөс эхлэн тооцож тусламж, үйлчилгээнд хамруулахаар заасан. Иргэд шилжих хөдөлгөөн хийлгэсэн үед хувийн хэрэгт хавсаргах баримт бичгийг дахин бүрдүүлж байгаа байдлыг өөрчлөн иргэн шилжин очсон газраа тухайн хувийн хэргээрээ үргэлжлүүлэн тэтгэвэр, тэтгэмжээ авч болохоор өөрчилсөн байна.

Нийгмийн дэмжлэг туслалцаа шаардлагатай өрх, иргэнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журмаар гурав хүртэлх насны ихэр хүүхдэд жилд нэг удаа, байнгын асаргаа шаардлагатай иргэнд улиралд нэг удаа, гурав ба түүнээс дээш тооны бага насны /14 хүртэлх насны/ хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/-т жилд нэг удаа, 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэнд болон гэнэтийн аюул, ослын улмаас гэр оронгүй болсон өрхөд гэр авахад нь дэмжлэг үзүүлж нэг удаа Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж олгох болон хүнд

нөхцөлд байгаа хүүхдэд халамжийн цэцэрлэгийн үнийн хөнгөлөлт олгох асуудлыг зохицуулахаар тусгав. Энэхүү журамтай холбогдох тусламжууд нь Нийгмийн халамжийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу шинээр олгогдож байгаа тул бүрдүүлэх бичиг баримтын бүрдүүлэлт, олгох асуудлыг шийдвэрлэх харилцааг зохицуулахад анхаарч, улиралд нэг удаа олгохоор, жилд нэг удаа олгож байгаа тусламжийг хуанлийн өдрөөр тооцолгүйгээр бүтнээр нь олгох асуудлыг тусгасан байна.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх журмаар Нийгмийн халамжийн тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай өрх, иргэнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна. Журамд аймаг, дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага нь олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг холбогдох иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх асуудлыг тусгав. Халамжийн үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хийх гэрээний загвар болон үйлчилгээнд хамрагдах өрх, иргэдийн тоо, шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхойлох аргачлал, зааврыг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батлахаар зааж өглөө.

Ахмад настанд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам, Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тусламж, хөнгөлөлт, үзүүлэх журамд Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулиудад заасан тусламж, хөнгөлөлтийг олгох асуудлыг тусгалаа. Ахмад настан, хөгжлийн брхшээлтэй иргэдэд тусламж, хөнгөлөлт үзүүлэхдээ асуудлыг шийдвэрлэх явцын шат дамжлагыг багасгах, хүсэлт, өргөдлийг шийдвэрлэлгүй цаг алддаг байдлыг анхааран шийдвэрлэх хугацааг журамд тодотгон оруулав. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын дүгнэлттэй бол Амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцүүлэлгүйгээр шууд сумын нийгмийн ажилтан, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст хандан тусламж, хөнгөлөлтөд хамрагдах асуудлыг тусгаж өглөө.

Тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтанд нэмэгдэл хөлс олгох журамд Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд орсон өөрчлөлтийн дагуу тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтанд үндсэн цалингийн 10-30 хувь хүртэл нэмэгдэл хөлс олгохоор тусгасан байна.


Ахмадын сан байгуулан ажиллуулах журамд Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуульд заасны дагуу аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан болон ажиллаж байгаа ахмад настанд нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, түлээ, нүүрс олгох, хөдөлмөр, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, орон сууцтай болоход нь дэмжлэг үзүүлэх санг байгуулах хэмжээ, сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт болон тайлагнах асуудлыг бүрэн тусгалаа.

Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх журамд тэтгэмж, тусламж олгох, шийдвэрлэх асуудлыг дэлгэрэнгүй тусгасан ба бүрдүүлэх бичиг баримт, тэтгэмж тусламжийг зогсоох асуудлыг зааж өгөв. Бичиг

баримт тус бүрийг нотариатаар баталгаажуулдаг байсныг энэ журмаар өөрчилж, иргэний хүсэлтийг шийдвэрлэх явцын шат дамжлагыг багасгаж, иргэд шилжих хөдөлгөөн хийлгэсэн үед хувийн хэрэгт хавсаргах баримт бичгийг дахин бүрдүүлэх асуудлыг болиулсан байна.

Нийгмийн халамжийн Амьжиргаанд туслах нөхцөлт мөнгөн тусламжууд болон хөнгөлөлт тусламжийн хэмжээг шинээр тогтоон нэмэгдүүллээ. УИХ-аас 2008 оны 1 сарын 15-нд батлагдсан Нийгмийн халамжийн тухай хуулиар байнгын асаргаа шаардлагатай иргэн, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэг ихэр хүүхэд, бүтэн өнчин өссөн 18-24 насны иргэн болон гэнэтийн аюул ослын улмаас орон гэргүй болсон иргэд зэрэг нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай өрх иргэдэд амьжиргаанд туслах нөхцөлт мөнгөн тусламж олгох асуудлыг тусгаад мөнгөн тусламжийн хэмжээг Засгийн газар тогтоохоор заасны дагуу “Тусламж, хөнгөлөлтийн хэмжээг тогтоох” асуудлыг судлан боловсруулж, Засгийн газрын 2008 оны 161 дүгээр тогтоолоор шийдвэрлүүлэв. Нийгмийн халамжийн зарим тусламжийн хэмжээ нэмэгдсэнтэй холбогдох 1.8 тэрбум төгрөгийг 2008 оны Монгол Улсын Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэмж тусган хэрэгжүүлж байна.

“Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг өөрчлөн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулж, Засгийн газар, УИХ-ын чуулганаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэв. Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 34500 төгрөг байсныг 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 41400 төгрөгөөр тогтоолоо.



2008 онд нийгмийн халамжийн тэтгэвэрт нийт 57589 иргэнд 28.6 тэрбум төгрөг олгохоор 2008 оны төсвийн төсөлд тусгагдсан боловч 8800 иргэнд шаардагдах 4.4 тэрбум төгрөгийг УИХ-ын Төсвийн байнгын хорооны саналын дагуу хасч 24.2 тэрбум төгрөгийг баталсан юм. Нийгмийн халамжийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт 2008 оны 2 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 8800 иргэд олгогдох халамжийн тэтгэвэр олгоход шаардагдах 3.7 тэрбум төгрөгийг 2008 оны Монгол Улсын Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгуулан хэрэгжүүлж байна.

“Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмжийн хэмжээг өөрчлөн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулж, яамдын санал авч тусган Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-аар шийдвэрлүүлэв. Нөхцөлт мөнгөн тэтгэмжийн хэмжээ 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 24 000 төгрөг болсон

бөгөөд энэхүү арга хэмжээнд 2008 онд 42.9 мянган хүн хамрагдаж 12.4 тэрбум төгрөг зарцуулахаар төсөвт тусгуулав

Дайнд оролцсон ахмад дайчдад сар бүр мөнгөн тусламж үзүүлэх, орон сууц олгоход шаардагдах хөрөнгийг шийдвэрлэх зорилгоор холбогдох тооцоо, судалгаа хийсний үндсэн дээр “Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төсөл боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэв. Хуралдаанаас ахмад дайчин, түүнчлэн дайнд оролцож яваад амь үрэгдсэн иргэний эхнэр /нөхөр/-т сард нэг удаа мөнгөн тусламж үзүүлэх асуудлыг шийдвэрлэхээр тогтож, хуулийн төслийг УИХ-д өргөн барихаар дэмжив. Хууль батлагдсанаар 2008 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн ахмад дайчдад сар бүр 200000 төгрөгийн мөнгөн тусламж олгох бөгөөд энэ арга хэмжээнд шаардагдах 1089.0 сая төгрөгийг 2008 оны төсвийн тодотголд тусгаад байна. Мөн уг хуулийн өөрчлөлттэй холбогдон 2009 онд шаардагдах 4,3 тэрбум төгрөгийг улсын төсөвт тусгуулав.

“Дайнд оролцсон ахмад настнуудын талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2008 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 170 дугаар зарлигт “Ахмад дайчдад орон сууц олгох, эсвэл түүнтэй адилтгах мөнгөн тэтгэмжийг нэг удаа олгох”-оор заасны дагуу Ахмад дайчдын судалгааг Монголын ахмадын холбоо, Дайнд оролцогсодын Монголын холбоо, Батлан хамгаалах яамтай хамтран хийж, 2008 оны 6 сарын байдлаар 1815 ахмад дайчид байгааг нэрсийн жагсаалтаар гаргалаа. Уг арга хэмжээнд шаардагдах хөрөнгө санхүүгийн тооцоог хийж, 2008 оны төсвийн тодотголд 350.0 сая төгрөг, 2009 оны төсөвт 3.0 тэрбум төгрөг батлуулав. Иймд эдгээр ахмад дайчдад орон сууцны асуудалд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Ахмад дайчдад орон сууцны дэмжлэг үзүүлэх нэг удаагийн буцалтгүй тусламжийн хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, “Ахмад дайчдад орон сууцны дэмжлэг үзүүлэх нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгох журам”-ын төсөл боловсруулаад байна. Энэхүү арга хэмжээнд цаашид 60.2 тэрбум төгрөг нэмж шаардагдах тооцоо гарч байгаа болно.

1.4. Хүн ам, нийгмийн бүлгүүдийн хөгжлийн бодлого, үр дүн:

НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 61 дүгээр чуулганаар батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц”, түүнийг дагалдан гарсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн нэмэлт протокол”-ыг УИХ-аар соёрхон батлах тухай хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж дэмжүүлэн УИХ-д өргөн бариад байна. Хуулийн төсөл батлагдсанаар хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний асран хамгаалагчид нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, баялаг бүтээх үйл явцад хувь нэмрээ оруулах боломж нөхцөл бүрдэх бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн амьдралд оролцсоноор тэдний амьжиргааны түвшин дээшилнэ. Энэ нь улс орны нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлтөд таатай нөлөө үзүүлэх боломжтой юм.

Швейцар Улсын Женев хотноо болсон НҮБ-ын Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хорооны ээлжит хуралдаанаар Монгол Улсын Засгийн газрын 5, 6, 7 дугаар тайлан илтгэлийг нэгтгэн хэлэлцүүлэв. Тус хуралдаанд Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцийн хэрэгжилтийн талаар ээлжит илтгэлийг хэлэлцүүлэхийн зэрэгцээ өмнө хүргүүлсэн 5 дугаар тайлантай холбогдуулан 28 нэмэлт асуултыг Монголын Засгийн газарт

ирүүлснийг хариу бэлтгэн хүргүүлэв. Тайлан, илтгэлийг конвенцийн хорооны хуралдаанаар хэлэлцүүлсэн дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулав.

Бразил Улсын Рио де Жанеэро хотноо болсон “Хүүхэд, өсвөр үеийнхнийг бэлгийн зорилгоор ашиглахын эсрэг Дэлхийн гуравдугаар чуулган”-ы бэлтгэлийг хангаж, Монгол Улсад хүүхдийг бэлгийн зорилгоор ашиглаж буй нөхцөл байдлын талаарх улс орны илтгэлийг хүргүүлж, оролцов. Дэлхийн 3 дугаар чуулга уулзалтад бүсээс өргөн барих зорилтуудыг тодорхойлоход оролцож, санал бодлоо тусгуулав. Чуулганы мөрөөр хэвлэлийн бага хурал зохион байгуулах, чуулганаас гарсан Тунхаглал, баримт бичгийг Засгийн газарт өргөн барих, Тунхаглалын үзэл санаанд нийцүүлсэн үйл ажиллагааг 2009 оны төлөвлөгөөт ажилд тусган хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Засгийн газраас өгсөн үүргийн дагуу “Өрх, хүн амын амьжиргааны түвшинг тогтоох аргачлал”-ыг шинэчлэн боловсруулж буй ажлын явцын талаар мэдээлэл бэлтгэж, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын зөвлөлийн гишүүдийн саналыг тусган Засгийн газарт танилцуулав. Энэхүү ажлын хүрээнд уг аргачлалын үзүүлэлтийн нөлөөллийг судлан, хэрэглэхэд хялбар болгох, гарч байсан гажуудал, сургамжид үндэслэн зарим үзүүлэлтийг аргачлалаас хасах, зарим үзүүлэлтийн задаргааг нарийвчлах зэргээр боловсронгуй болгох санал боловсруулав.

“Монгол Улсын хүн амын шилжих хөдөлгөөний өнөөгийн байдал, хандлага, үр дагавар” сэдэвт Үндэсний хэмжээний түүвэр судалгааг явуулж байна. Энэхүү судалгааны ажлын зорилго нь Хүн амын шилжих хөдөлгөөний өнөөгийн байдал, шинж төлөв, шилжих хөдөлгөөнд оролцсон шалтгаан, шилжих хөдөлгөөнөөс үүдэн гарах эерэг, сөрөг үр дагавар, ирээдүйн хандлагыг судлах, зорилтын шалгуур үзүүлэлтийг бий болгох, Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар бодлогын зөвлөмж гаргах явдал юм. Судалгааг гүйцэтгэгчээр шалгарсан МУИС-ын Хүн амын сургалт, судалгааны төвийн багт дэмжлэг үзүүлэх, бодлогын зөвлөмжөөр хангах хүрээнд холбогдох яамд, байгууллагын төлөөллийг оролцуулсан Удирдах зөвлөлийг байгуулан ажиллуулж байна. Судалгааны үр дүнгийн тайлангийн эхний хувилбарыг бэлэн болгов.

ХОЕР.БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН:

2.1. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилт, үр дүн:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн сургалтын тогтолцоог сайжруулах, ажлын байраар хангах талаар:

“Их бүтээн байгуулалт, шинэ ажлын байр нэмэгдүүлэх жил”-ийн хүрээнд 2007 онд хийсэн ажлыг нэгтгэн, 81.5 мянган ажлын байр шинээр бий болж, ажилгүйдлийн түвшин 0.2 пунктээр буурсан дүнг Засгийн газарт танилцуулав.

“Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний төлөвлөгөөний төслийг боловсруулав. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд сургуулиас ажилд шилжиж байгаа залуучуудад үзүүлэх хөдөлмөр эрхлэлтийг

дэмжих шинэ үйлчилгээ, арга хэмжээ бий болгохоор тусгасан бөгөөд уг төлөвлөгөөг хуулийн шинэчилсэн найруулга батлагдсаны дараа дахин авч үзэх юм. Энэ ажлын хүрээнд “Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд хөтөлбөр”-ийн төслийг боловсруулж Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын 2008 оны 136/130 дугаар хамтарсан тушаалаар батлууллаа. Уг хөтөлбөрийн зорилго нь оюутнуудыг сургуулиас ажилд шилжихэд бэлтгэх, сурч байгаа мэргэжлийн чиглэлээр нь аж ахуй эрхлэх, жижиг бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, бизнес инкубацийн орчинд хөгжүүлэхэд чиглэгдэж байгаа юм.

Түүнчлэн оюутны жижиг зээлийн хөтөлбөрийг ХАС банкттай хамтран хэрэгжүүлж байна. Их дээд сургуулиудад төгсөх жилдээ суралцаж буй эсхүл зээл авах хүсэлт гаргахаас 1-ээс дээшгүй жилийн өмнө их дээд сургууль төгссөн оюутнуудад бие дааж бизнес эрхэлж ажлын байр нэмэгдүүлэхэд зориулан 5.0 сая хүртэл төгрөгийн зээлийг 24 сар хүртэл хугацаатай 1.0 хувийн хүүтэйгээр олгож байгаа юм. Зээлийг бэлэн хувцас, зайрмагны худалдаа, компьютерийн үйлчилгээ, тоног төхөөрөмж худалдан авах, эргэлтийн хөрөнгө нэмэгдүүлэхэд зориулан авсан бөгөөд нийслэл болон хөдөө орон нутгийн 55 оюутан залуучуудад 161.8 сая төгрөгийн зээлийг олгосноор 114 хүн ажлын байраар хангагдсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажиллах хүч гадаадаас авах бодлогыг бусад салбарын бодлоготой уялдуулахад анхаарч ажиллалаа. Тухайлбал, Зам, барилга, уул уурхайн салбарт гадаадаас авах ажиллах хүчний тоо, хэмжээг бууруулах, тухайн салбарт үйлдвэрлэл дээр үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд чиглэсэн “Зам, барилга, уул уурхайн салбарын үйлдвэрлэл дээр сургалтын хөтөлбөр”-ийн төслийг боловсруулаад байна. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд үйлдвэрлэл дээрх сургалтын хэрэгцээг тодорхойлох, үйлдвэрлэл дээр сургалт зохион байгуулах, сургалтанд хамрагдсан ажилтнуудыг ажлын байраар хангах үйл ажиллагаа явуулах юм.

Ногоон ажлын байр хөтөлбөрийн төслийг боловсруулж, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай хамтран батлуулахаар бэлтгэв. Уг хөтөлбөрийн төсөлд нийтийг хамарсан ажлын хүрээнд ойжуулах, нөхөн сэргээх, цөлжилттэй тэмцэх, хог хаягдлыг дахин боловсруулах, байгаль орчинд халгүй технологи нэвтрүүлж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллах чиглэлээр тодорхой арга хэмжээ авахаар заасан болно.

Зам, барилга, уул уурхайн салбарт үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулах асуудлаар 2008 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас гадаадаас ажиллах хүч авч байгаа томоохон аж ахуйн нэгж, байгууллага, салбарын яамд, мэргэжлийн холбоод хамтран уулзалт, ярилцлага зохион байгуулав. Барилга, зам, хөдөө аж ахуй, хөнгөн хүнсний үйлдвэр, эрдэс баялгийн салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай томоохон компаниудтай гэрээ байгуулж ажилгүй иргэдийг ажлын байран дээр нь сургалтанд хамруулж, тогтвортой ажлын байраар хангасан ажил олгогчдод Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас сургалтын зардлыг нь санхүүжүүлэх ажлыг зохион байгуулахаар хэлэлцэж тохирсон бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлаар яамдын төлөөлөл бүхий ажлын хэсэг ажиллаж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 9.4 дэх заалтыг үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэх мэргэжлийн болон давтан сургалтын нэг суралцагчид ногдох зардлын дээд хэмжээг мэргэжлийн ялгавартайгаар

шинэчлэн тогтоож, НХХ-ийн сайдын 2008 оны 87 дугаар тушаалаар баталж, мөрдүүлэв. Уг тушаалаар хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй барилга болон техникийн үйлчилгээ 80-150 мянга, эрчим хүч, уул уурхай 140-170 мянга болгон инфляци үнийн өсөлттэй уялдуулан сургалтын зардлын хэмжээг нэмэгдүүлэн тогтоож нэг суралцагчид хоол 1000 төг, унаа 500 төгрөгийн зардлыг ХЭДС-аас олгохоор журамлан хэрэгжүүлж байна. Сургалтын зардлын дээд хэмжээг нэмэгдүүлсэн нь ялангуяа үйлдвэрлэл дээр сургалт эрхлүүлж буй ажил олгогчдийг дэмжих, улмаар ажлын байр бий болгох, иргэдийн орлогыг нэмэгдүүлэхэд зохих хувь нэмэр оруулж байна.

Засгийн газрын 2006 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн “Журам батлах тухай” тухай 166 дугаар тогтоолыг үндэслэн Бизнесийн ур чадвар эзэмшүүлэх, аж ахуйн эрхлэлтийн сургалт зохион байгуулах, төсөл хөтөлбөр боловсруулахад зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээний төрлүүдэд үзүүлэх зардлын дээд хэмжээ болон бизнес инкубацийн үйлчилгээнд хамрагдсан иргэнд үзүүлэх дэмжлэгийн дээд хэмжээг тус тус шинэчлэн тогтоож, НХХ-ийн сайдын 2008 оны 88 дугаар тушаалаар баталж, мөрдүүлэв.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамнаас аж ахуйн нэгж, байгууллагуудын шинээр бий болгосон ажлын байрыг улсын хэмжээнд бүртгэх www.ejob.mn веб сайтыг ажиллуулж байна. Уг веб сайтыг 2008 онд шинэчилж, шинээр бий болсон ажлын байранд ажиллаж байгаа иргэдийн цалин хөлс, ажлын цаг зэрэг мэдээллийг нэмж оруулан тайланг аймаг, нийслэл, дүүрэг, сумын түвшинд ангилан гаргах боломжтой болгов. Шинээр бий болсон ажлын байрны мэдээг сар бүр авч албан ёсны захиргааны мэдээлэлд оруулж байгаа ejob.mn сайтаас гарах тайлангийн маягт, хүн бүрийг регистрээр бүртгэх зэрэг өөрчлөлтүүдийг оруулсаны дүнд мэдээллийн чанар, бодитой байдал сайжирсан болно. 2008 оны 12 дугаар сарын 15-ны байдлаар 56400 шинэ ажлын байр ejob.mn сайтад бүртгэгдээд байна.

Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны хуралдааныг 2008 оны 4, 9 сард зохион байгуулж Үндэсний хорооны төлөвлөгөөг батлуулж ажилласан бөгөөд Үндэсний хороогоор Улсын хэлэлцээний явцыг хэлэлцүүлж, эхний явцын биелэлтийг Өдрийн сонин болон Зууны мэдээ сонинд нийтлүүлэв.

Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны 2008 оны 4 дугаар сарын 8-ны өдрийн хуралдаанаар Хөдөлмөрийн маргааныг шүүхийн өмнөх шатанд зохицуулах чиг үүрэг бүхий “Хөдөлмөрийн маргааныг шуурхай зохицуулах дэд хороо”-г Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны дэргэд байгуулж дүрэм, бүрэлдэхүүнийг баталж, орон нутагт хэрэгжүүлэх зохион байгуулалтыг эхлүүллээ.

Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2007-2008 оны улсын хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалж, Монгол Улсын Засгийн газар, МҮЭХ, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны төлөөллийг орлцуулсан гурван талт хэлэлцээрийг 2008 оны 10 дугаар сард зохион байгуулав. Хэлэлцээрийн үеэр “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг ялгавартай тогтоох”; “Ажилчдыг үнэгүй хоолоор хангах, унааны хөлсийг нь тухайн үйлдвэр байгууллага бүрэн хариуцах хяналтын ба урамшууллын механизм бий болгох”; “Төсвийн ерөнхийлөн захирагч тус бүр төсвийн багц дотроо багтаан зохих эх үүсвэрийг бий болгосны үндсэн дээр боловсрол, эрүүл мэндийн салбарын болон төрийн бусад албан хаагчдын цалин хөлсийг үе шаттайгаар

салбарын ҮЭ-ийн холбоодтой хамтран хэлэлцэж нэмэгдүүлэх” чиглэлээр 2007-2008 оны улсын хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулав.

Улсын хэлэлцээрт тусгагдсан Хөдөлмөрийн маргааныг шуурхай зохицуулах, Компанийн засаглалыг хөгжүүлэх Үндэсний хөтөлбөр, 40000 айл хөтөлбөрийн хяналтын зөвлөл, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн асуудлуудаар гурван талт уулзалт зөвлөлгөөн, хурал мэдээллийн уулзалтуудыг түншлэгч талууд хийж харилцан мэдээлэл солилцож зохих зөвшилцөлд хүрч шийдвэр гаргаж ажиллав. Улсын хэлэлцээрийг шинэчилснээр төрийн байгууллага, ялангуяа боловсролын салбарын ажилтнууд төсвийн багцдаа багтаан цалин хөлсөө нэмэгдүүлэх боломжийг олголоо.

Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар:

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт явуулах, шалгалт авах журам”, “Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан Зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм”, “Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан орон тооны ажилтан ажиллуулахад баримтлах норматив”, “Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтны ажлын байрны тодорхойлолтын загвар”, “Хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ хийх журам”, ХАБЭА-н үндэсний хорооны гишүүдийн бүрэлдэхүүн, дүрэм” зэрэг журам, дүрмүүдийг боловсруулж, НХХ-ийн сайдын 2008 оны 126, 127, 138 дугаар тушаалаар батлуулав. Тухайлбал,

Хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ хийх журмын дагуу ажил олгогч нь ажлын байр шинээр бий болгох болон тухайн ажлын байрны үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, нөхцөл өөрчлөгдөх бүрт химийн хорт болон аюултай бодис агуулсан түүхий эд, материал ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа бол жилд нэгээс доошгүй удаа ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ хийлгэх юм.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын зорилго нь хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтан, ажил олгогчдод хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн талаарх мэдлэг олгож, осол эндэгдэлгүй, эрүүл ажиллах соёл, зан үйлийг төлөвшүүлэхэд орших бөгөөд ажил олгогч нь шинээр ажилд орж байгаа иргэн, өөр ажлын байранд шилжсэн ажилтан, нийт ажилтны сургалтыг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар сургалт явуулах эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан зохион байгуулж байхаар “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт явуулах, шалгалт авах журам”-д тусгав.

Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан Зөвлөлийн үлгэрчилсэн дүрмийн дагуу зөвлөл нь хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, ажлын зохистой орчныг бүрдүүлэх, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс сэргийлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах бөгөөд зөвлөлийн эрх, үүргийг уг дүрмээр зохицуулж өгсөн байна.

Ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн аттестатчилал явуулах журмыг НХХ-ийн сайдын тушаалаар батлуулж, аттестатчилах үзлэгийн

бэлтгэл ажил хангуулах, үзлэг шалгалт хийх, үзлэгийн дүнг хянан баталгаажуулах, дүнг нэгтгэх хэд хэдэн үе шатуудтайгаар 2008 оны 1 дүгээр сарын 25-наас 5 дугаар сарын 25-ны хооронд аттестатчилалыг явууллаа. Энэ удаагийн үзлэгт эдийн засгийн үйл ажиллагааны бүх салбарыг хариуцсан 16407 аж ахуйн нэгж, байгууллагын 70731 ажлын байр хамрагдсан ба тухайн орон нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн хаяг тодорхойгүй, татан буугдсан, өөр дүүрэгт шилжсэн, улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг, аттестатчилалын материал хүргүүлсэн боловч дүнг ирүүлээгүй шалтгаанаар хамрагдвал зохих аж ахуйн нэгж байгууллагын 65.8 хувь нь хамрагдаж, ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн хувьд үзлэгт хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагын 14.6 хувь нь хангалттай сайн, 69.6 хувь нь хангалттай, 15.7 хувь нь хангалтгүй гэж дүгнэгдсэн байна.

Аттестатчилах үзлэгийн явцад аймаг, нийслэл, дүүргийн Мэргэжлийн хяналтын газрын хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчдаас 6750 зөрчил илрүүлж, 3429 буюу 50.9 хувийг газар дээр нь арилгуулсан, 3321 заалт бүхий 684 албан шаардлага өгч, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны стандартын шаардлагыг ноцтой зөрчсөн 14 байгууллага, 39 цех нэгж тасгийн үйл ажиллагааг бүрмөсөн, 78 байгууллага, 193 цех нэгж тасгийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоож, 21 аж ахуйн нэгж, 12 цех тасгийн үйл ажиллагааг аттестатчилах үзлэгийн хугацаанд сэргээсэн байна. Түүнчлэн зөрчил гаргасан 85 байгууллагад 13150.0 мян, 91 албан тушаалтанд 3263.0, 21 иргэнд 555.0 мянган төгрөгийн шийтгэвэр ногдуулж барагдуулжээ. Үзлэг шалгалтаар эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан 1249 ажлын байранд улсын байцаагчийн дүгнэлт, 1027 тоног төхөөрмжид аюулгүй ажиллагааны гэрчилгээ тус тус олгосон байна. Аттестатчилалын дүнгийн талаар Засгийн газарт мэдээлэл хийв.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг аймаг, нийслэлийн холбогдох байгууллагуудаас гаргуулан нэгтгэж, дүнг Засгийн газарт танилцуулав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний нэгдүгээр шатны төлөвлөгөөнд тусгагдсан 38 асуудлаас 20 асуудал биелэгдэж, 18 асуудал биелэлтийн шатандаа байв. Хөтөлбөрийн II шатыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2008 оны 61 дүгээр тушаалаар батлуулж, хэрэгжилтийг хангуулахаар холбогдох байгууллагуудад хүргүүлэв.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хорооны хурлыг 3 удаа зохион байгуулж, 2008 оны ажлын төлөвлөгөө, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн төсөл, аттестатчилалын явц, ОУХБ-ын конвенцид нэгдэн орох асуудлыг хэлэлцэж, хорооны эхний хурлыг Бороо-гоулд ХХК дээр зохион байгуулж, Бороо-гоулд ХХК-ны туршлагыг аж ахуйн нэгж, байгууллагуудад нэвтрүүлэхийг Монголын ажил олгогч, эздийн нэгдсэн холбоо хариуцан гүйцэтгэх болов.

Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын байцаагчид /88/ оролцсон сургалтыг УМХГ-тай хамтран 2008 оны 12 дугаар сарын 17-19-ний өдрүүдэд зохион байгуулж, аттестатчилалын мөрөөр цаашид анхаарч ажиллах талаар зөвлөгөө өгөв. Аж ахуйн нэгж байгууллагын 14.4 хувь нь ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хувьд хангалттай сайн, 68.6 хувь нь хангалттай, 16.9 хувь нь хангалтгүй гэж дүгнэгдсэн байна.

Олон улсын стандартад нийцсэн ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл болон өндрөөс хамгаалах хэрэгслийн талаарх сургалтыг “ЭМЖЖ” ХХК, “СW Монгол” ХХК-тай хамтран Дархан-Уул аймгийн Мэргэжлийн хяналтын газар, зарим томоохон аж ахуйн нэгжийг оролцуулан зохион байгуулж, 30 гаруй инженер техникийн ажилтнууд хамрагдсан байна. Түүнчлэн “Бороогоулд” ХХК-ны хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн менежментийн систем нэвтрүүлж, хэрхэн үр дүнд хүч байгаа ажил байдалтай танилцлаа.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн талаар Дархан-Уул аймгийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран 30 гаруй аж ахуйн нэгж, байгууллага, Дорноговь аймгийн Ажил олгогч эздийн байгууллагатай хамтран 50 гаруй аж ахуйн нэгж, байгууллагын инженер техникийн ажилтнууд оролцсон сургалт зохион байгуулж, хуулийг телевиз, радиогоор сурталчлав.

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах талаар:

БНСУ-ын Хөдөлмөрийн яамны боловсруулсан “Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн системийн MOU”-ийн анхдагч төслийн талаар Монгол Улсын Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны баримталж байгаа байр суурийн талаар санал боловсруулан БНСУ-ын Хөдөлмөрийн яаманд хүргүүлж, сайд нар 2008 оны 10 дугаар сард уг баримт бичигт гарын үсэг зурж, хугацааг 2 жилээр сунгав.

Монгол Улсын Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Бүгд Найрамдах Солонгос Улсын Хөдөлмөрийн яамны хооронд байгуулсан “БНСУ-д ажиллах хүч илгээх тухай харилцан ойлголцлын санамж бичиг”-т тусгасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хүсэлтэй иргэдийг солонгос хэлний шалгалтанд бүртгэх ажлыг аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдийг түшиглэн улсын хэмжээнд зохион байгуулан нийт 9049 хүн бүртгэж, 12 дугаар сарын 13, 14-ний өдрүүдэд шалгалтад хамруулахаар бэлтгэл ажлыг хангав. Орон нутаг дахь хөдөлмөр, халамжийн хэлтсүүдийг түшиглэн бүртгэлийн ажлыг зохион байгуулсан нь орон нутгийн иргэд бүртгүүлэх боломжийг нэмэгдүүлж, иргэд нэг дор олноор цуглах, олон цагаар дугаарлан зогсох болон хөдөө орон нутгаас ирж, очих зардал чирэгдлийг арилгаж, банкны үйлчилгээг нэг цэгээс зохион байгуулах нөхцөл боломжийг бий болгов. Бүртгэлийн ажлыг иргэдэд ойр, ил, тод хөнгөн шуурхай зохион байгуулснаар бүртгэлтэй холбоотой ямар нэг санал, гомдол иргэдийн зүгээс гараагүй байна.

НХХ-ийн сайдын 2007 оны 120 дугаар тушаалаар баталсан “Гадаадад ажиллах хүч илгээх төв”-ийн Монгол Улсын иргэдийг БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулахаар зуучлах үйл ажиллагааны улирал тутмын тайлангийн маягтыг НХХ-ийн сайдын 2008 оны 131 дүгээр тушаалаар шинэчлэн батлуулав. Тайлангийн маягтыг шинэчлэн батлуулснаар солонгос улсад хөдөлмөрийн гэрээгээр явсан иргэд, тэдгээрийн хөдөлмөр, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлаар болон иргэдийн орголт, ажлаас чөлөөлөгдсөн, ажилгүй болсон зэрэг асуудлаар тодорхой мэдээллийг авах боломжтой болж байгаа нь гадаадад амьдарч ажиллаж буй иргэдийнхээ цаашдын хувь заяанд анхаарахад чухал ач холбогдолтой юм.

“Ажиллах хүч харилцан солилцох тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн дагуу “Монгол Улсад БНАСАУ-аас ажиллах хүч авах асуудлаар Монгол Улсын НХХЯ, БНАСАУ-ын Гадаад худалдааны яамны хамтран ажиллах санамж бичиг”-ийн төсөл боловсруулан солонгосын талд хүргүүлэв. Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд талууд тодорхой журам гаргаж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаанаас үзэхэд ялангуяа барилгын болон уул уурхай салбарт хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэхийн хэрээр ажиллах хүчний эрэлт өсч, цаашдаа нэмэгдэх төлөвтэй байна. Ажиллах хүчний энэхүү өсөлт, хэрэгцээг хангах мэргэшлийн ур чадвар бүхий ажиллах хүч, мэргэжилтэн дотоодын хөдөлмөрийн зах зээлд хязгаарлагдмал байгаа бөгөөд манай компаниуд БНАСАУ-аас ажиллах хүч олноор авах төлөвтэй байна. Одоогийн байдлаар БНАСАУ-ын 300 гаруй иргэн Монгол Улсад барилга, зам, эрүүл мэнд зэрэг салбарт хөдөлмөр эрхэлж байна.

Цаашид 40 мянган айлын орон сууц, Мянганы зам зэрэг томоохон бүтээн байгуулалтын ажилд буюу эдийн засгийн зарим тодорхой салбаруудад нарийн мэргэжлийн ажиллах хүч, мэргэжилтнийг БНАСАУ-аас авч ажиллуулах хэрэгцээ байна. БНАСАУ-аас 2009 онд манай компаниудын авах ажиллах хүчний хэрэгцээг судалж үзэхэд, гол төлөв барилга, хөнгөн үйлдвэрлэлийн салбарт урьдчилсан дүнгээр 2500 гаруй хүний хэрэгцээ гарч байгаа болно. Бүтээн байгуулалтын улсын хэмжээний томоохон хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх ажилд ажиллах хүчнийг дотоодоос хангах бололцоогүй нөхцөлд, өндөр ур чадвар шаардах ажил, мэргэжлээр зохих шалгуур, шаардлагыг хангасан, мэргэжилтэн, ажиллах хүчийг гадаадаас авах бодлого баримталж байна.

Энэхүү бодлого, чиглэлийг баримтлан хэлэлцээрийг хэрэгжүүлэх нэгдсэн журмыг талууд санал нэгдэж гарын үсэг зурах, 2009 онд авах ажиллах хүч, мэргэжилтний тоо хэмжээг тохирох асуудлаар хоёр яамдын уулзалтыг зохион байгуулахаар төлөвлөв.

“Монгол Улсын иргэд, Бүгд Найрамдах Чех Улсын иргэдийг харилцан хөдөлмөр эрхлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, БНЧУ-ын Засгийн газар хоорондын 1999 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн Хэлэлцээр”-ийг шинэчлэх асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Европын зарим орнуудаар айлчлах үеэр хэлэлцэж, шийдвэрлүүлэхээр саналыг ГХЯ-д хүргүүлэв. Засгийн газар хоорондын 1999 оны дээрх Хэлэлцээрийн зохицуулалт нь ерөнхий байгааг анхаарч, иргэдийг харилцан илгээхтэй холбогдсон үйл ажиллагаа, тэдний эрх ашгийг хамгаалах, цалин хөлс, нийгмийн хамгааллын зэрэг арга хэмжээг тодотгон шинэчлэх шаардлагатай байгаа юм. БНЧУ-д монгол иргэнийг хөдөлмөр эрхлүүлэх асуудлаар “Монгол Улсын НХХЯ, БНЧУ-аас Монголд суугаа Элчин сайдын яамтай хамтран ажиллах журам”-ын төсөл боловсруулан БНЧУ-ын Монгол дахь ЭСЯ-нд хүргүүлэв. Журмыг хоёр яам хамтран баталж, БНЧУ-д хөдөлмөр эрхлэх сонирхолтой монгол иргэнийг сонгох, бэлтгэх, илгээх, “ажлын виз” мэдүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулах болно.

Японы Үйлдвэрлэлийн дадлагын олон улсын хамтын ажиллагааны байгууллага ЖИТКО-той хамтран ажиллах хүрээнд Япон Улсад үйлдвэрлэлийн дадлагажигч илгээж байгаа байгууллагуудын удирдлагууд оролцсон ажил хэргийн уулзалтыг Токио хотноо 2008 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулав. Түүнчлэн ЖИТКО-гийн

дэд ерөнхийлөгч, бусад удирдах ажилтнуудыг Японд дадлагажигч зуучилдаг байгууллагуудад холбогдох мэдээлэл өгөх, тэдний үйл ажиллагаатай газар дээр нь танилцуулах зорилгоор Монгол Улсад 2008 оны 7 дугаар сарын 28-29-нд ажиллах бэлтгэл ажлыг хангуулж, зохион байгуулав

Монгол Улс, Тайваний хооронд ажиллах хүчний салбарт хамтран ажиллах тухай “Санамж бичиг”-ийг шинэчлэх санал боловсруулж Тайваний талд хүргүүлэв. Энэхүү санамж бичгийн төсөлд ажилтны цалин хөлс, хөдөлмөрийн нөхцөл, нийгмийн хамгааллын арга хэмжээний талаар хүлээн авах талын үүргийг тодорхой болгож, хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлсон болно.

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай“ хуулийн дагуу “Гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах тусгай зөвшөөрөл” авах, сунгуулах, нэмэлт оруулах талаар 34 аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийг судлан үзэж, “Аж ахуйн нэгж, байгууллагад гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах тусгай зөвшөөрөл олгох асуудлаар сайдад мэргэжлийн зөвлөгөө өгөх, санал боловсруулах ажлын хэсэг”-ийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэв. Үүнээс 18 зуучлагч байгууллагын зөвшөөрлийг сунгах, 2 байгууллагын тусгай зөвшөөрөлд нэмэлт оруулах талаар Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын тушаал гаргуулав.

Хүн амын бүлгүүд, албан бус салбарын хөдөлмөр эрхлэлтийн талаар:

“Насанд хүрээгүй хүн ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ыг боловсруулж, НХХ-ийн сайдын 2008 107 дугаар тушаалаар батлуулав. Жагсаалтаар 18 насанд хүрээгүй хүнийг эдийн засгийн 12 салбарын 53 ажлын байр, 40 ажил мэргэжлээр албан ба албан бус секторт ажиллуулахыг хориглохыг тусгасан байна. Жагсаалтад тусгагдсан ажлын төрлүүд нь эдийн засгийн үйл ажиллагаа, ажлын байр, ажил, мэргэжлээр ялгавартай тусгагдсаны зэрэгцээ хүүхдийн эрүүл мэнд, амь насанд учрах аюулын төрлийг нийтлэг, ажлын байрны орчин нөхцөл, үйлдвэрлэлийн процесс, салбарын онцлог байдалтай уялдуулан ялгаатай авч үзэж байгаа нь практикт хэрэглэхэд илүү хялбар, ойлгомжтой боллоо.

Жагсаалтыг одоогийн байдлаар англи, солонгос хэлнээ орчуулж, НХХЯ, МАОЭНХ, МҮЭХ, УМХГ-ын вэб сайтад байршуулсан ба хүүхдийн хөдөлмөрийн асуудлаарх сүлжээний уулзалт, АЙПЕК хөтөлбөрийн хүрээнд орон нутагт хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар туршлага солилцох уулзалтын үеэр оролцогчдод танилцуулах, Үндэсний радио, Телевиз, IST Mongolia, TV-5 , TV -9 , Eagle, SBN зэрэг 10 гаруй телевиз, радиогоор 15 удаа дэлгэрэнгүй ба Өдрийн сонин, Өнөөдөр, Ардын эрх, Ардчилал зэрэг өдөр тутмын хэвлэлээр бүрэн эхээр нь болон хэсэгчлэн мэдээлэх ажлыг зохион байгуулав.

“Төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-ыг 2006-2008 онуудад хэрэгжүүлсэн тайланг холбогдох яамд, агентлагуудаас хүлээн авч нэгтгээд байна. Эхний шатанд төлөвлөсөн 6 чиглэлийн 38 арга хэмжээнээс 26 нь буюу 68.4 % нь бүрэн буюу зохих хэмжээнд биелсэн, 3 нь буюу 7.9 % нь тодорхой шалтгаанаар хэрэгжээгүй дүнтэй байна. Дараагийн шатны үйл ажиллагааны төлөвлөлтийг “Зохистой хөдөлмөрийн үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн төслийн хүрээнд нэгтгэн боловсруулах ажил хийгдэж байна. Зохистой хөдөлмөрийн төлөөх үндэсний хөтөлбөрийг хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн хамгааллын асуудлаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг санхүү, зохион байгуулалтын

хувьд нэгдсэн нэг удирдлагаар хангах, Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай энэ чиглэлээр хамтын ажиллагаагаа хөгжүүлэхэд чухал хувь нэмэр болох юм.

Хөдөө аж ахуйн салбарт хүүхдийн хөдөлмөрийн талаар тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор 2008-2009 онуудад хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг НХХ, ХХАА, БСШУ-ны сайдын 2008 оны 3 сарын 5-ны өдрийн хамтарсан тушаалаар батлуулж, мэдээллийг боловсронгуй болгох, хамгааллыг сайжруулах, боловсролын үйлчилгээ үзүүлэх, оролцогч талуудын чадавхийг нэмэгдүүлэх гэсэн 4 үндсэн чиглэлээр 17 арга хэмжээг тусгав. Төлөвлөгөөнд тусгагдсан ХАА дахь хүүхдийн хөдөлмөр, ХААЭА-н суурь судалгаа, мониторинг, мэдээ мэдээллийг бий болгох, алслагдсан бүс нутагт хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийг боловсролын үйлчилгээ үзүүлэх стратегийг боловсруулах, хэрэгжүүлэх, ОУХБ-ын бизнесийн хөтөлбөр, чадавхи бэхжүүлэх сургалт, ХАА дахь хүүхдийн хөдөлмөрийн бодлогын асуудлаар ОУХБ-ын гарын авлага орчуулж бэлтгэх зэрэг 14 арга хэмжээг зохих хугацаанд нь холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлсэн байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 111.3 дахь заалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг авч ажиллуулаагүй ААНБ-аас төлөх төлбөрийн хэмжээг ажиллагчдын тоо, төлбөрийн нийт хэмжээ, бүсийн ялгавартай тогтоох зорилгоор “Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, яамдын саналыг тусган Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв. Тогтоолын төсөлд 51-ээс дээш ажиллагчтай ААНБ-ын хувьд төлбөрийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний сарын доод хэмжээний 50%, 50 хүртэлх ажиллагчидтай ААНБ-д 40%, аймаг, сумын ААНБ-д 30% байхаар тусгав.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлаарх салбар зөвлөлийн хуралдааныг 2 удаа зохион байгуулж, тусгай дансны 2007 оны тайлан, 2008 оны төсвийг хэлэлцүүлж батлуулсан ба ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар холбогдох байгууллагуудын мэдээлэл, олон улсын төсөл, хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн судалгааны дүн зэргийг хэлэлцүүлэв. 2008 онд тусгай дансанд 232.1 сая төгрөг төвлөрүүлж, 300.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, зарцуулалтад хяналт тавьж ажиллав.

“Албан бус уурхайчдын үзлэг”-ийг Швейцарийн хөгжлийн агентлаг, хамтын ажиллагааны нийгэмлэг, “Тогтвортой бичил уурхай”, НҮБ-ын Хүн амын сантай хамтран 12 аймаг, УБ хотын Налайх дүүрэгт зохион байгуулж, 10.3 мянган хүн, 107 хүүхдийг тусгай анкетын дагуу бүртгэж, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдийн нэгдсэн бүртгэлийн Вебсайтад байршуулах ажил хийгдэж байна. Үзлэгийн хүрээнд бичил уурхайн талаар төрөөс баримталж буй бодлого, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх, нийгмийн даатгал, хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хүүхдийн хөдөлмөрийн хор уршгийн талаар 392 удаагийн сургалт, сурталчилгаа зохион байгуулсны дүнд 11698 хүнд мэдээлэл өгч, 472 хүнийг тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэнд, ҮОМШӨ-ий даатгалд хамруулсан ба явуулын үйлчилгээгээр 1056 хүнийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, 148 хүнд шаардлагатай эмнэлгийн үйлчилгээ, 341 хүнд иргэний бүртгэл, мэдээлэл, нийгмийн халамж, нийгмийн даатгал, ажлын байрны аюулгүй байдал, жендерийн асуудлаар зөвлөгөө өгч, иргэний бичиг баримттай болгох ажлыг зохион байгуулав. Үзлэгийн дүнг хэвлэлийн бага хурал болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр

сурталчилсан ба тайланг холбогдох яамдын удирдлага, төслийн нэгжид хүргүүлж танилцуулав.

Албан бус хөдөлмөр эрхлэлтийг албан зохион байгуулалттай болгох чиглэлээр Сонгинохайрхан дүүргийн модны худалдаа, үйлчилгээний Хангай захад туршилтын төслийг 2008 оны 7 дугаар сараас 2009 оны 3 сарыг дуустал 8 сарын хугацаатай хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд тус захын худалдаа, үйлчилгээ эрхлэгч 150 гаруй хүнийг НХХ-ийн сайдын тушаалаар баталсан анкетын дагуу бүртгэх, нийгмийн үйлчилгээний хэрэгцээг тодорхойлох судалгаа хийх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, нийгмийн даатгал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, жижиг зээл, мэргэжлийн болон аж ахуй эрхлэлтийн сургалтын асуудлаар гарын авлага, тараах материал бэлтгэж хэвлүүлэх, тараах, дурьдсан чиглэлээр сурталчилгааны самбар бэлтгэж, байршуулах, ХААЭА-н сургалт зохион байгуулах, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн ажлын байрны зохион байгуулалтыг сайжруулах, хөрөө рамуудыг дугаарлах ажлуудыг хийж гүйцэтгэв. Төслийн хүрээнд тус захын худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийг хууль тогтоомж, мэдээллээр хангах зорилгоор мэдээллийн төв байгуулах ажил хийгдэж байна.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгай данс”-ны 2008 оны төсвийн хуваарь, төвлөрүүлэх хөрөнгийн даалгаврыг батлуулан аймаг, дүүргүүдэд хуваарилж, 5 ТББ-д 105.0 сая төгрөгийн үйл ажиллагааг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж байна. Үүний дотор Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбоонд 78.7 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж, БЕСТ массаж–3 төвийг шинээр байгуулан, үйл ажиллагааг нь эхлүүлэв.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хүрээнд Хөдөлмөрийн зах зээл дэх эмэгтэйчүүд болон 45-аас дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын онцлог хэрэгцээг судлах судалгааны ажлыг гүйцэтгүүлэхээр МАОЭНХ, Нийгмийн хөгжлийн төвтэй гэрээ байгуулан ажиллаж байна.

Засгийн газар Олон улсын хөдөлмөрийн байгууллагын өмнө хүлээсэн үүргийн хүрээнд “Албадан хөдөлмөрийн тухай” 29, “Албадлагын хөдөлмөрийг устгах тухай” 105, “Зохион байгуулагдах болон хамтын хэлэлцээр хийх тухай” 98, “Адил цалин хөлсний тухай” 100, “Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай” 122, “Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө ба зохион байгуулагдах эрхийг хамгаалах тухай” 87, “Гурван талт зөвлөлдөөний тухай” 144 дүгээр конвенцүүдийн хэрэгжилтийн тайланг Монгол хэлнээ боловсруулан бэлэн болгоод байна. Тайлангийн орчуулга хийгдсний дараа ОУХБ-д хүргүүлэх юм.

Хөдөө аж ахуйн салбарт Хүүхдийн хөдөлмөрийн талаар тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор 2008-2009 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, НХХ, ХХАА, БСШУ-ны сайдын хамтарсан тушаалаар батлуулан хэрэгжилтийг хангаж байна.

Хүүхдийн хөдөлмөрийн дэлхийн өдрийг тэмдэглэн, холбогдох байгууллагууд хамтран семинар зохион байгуулав. Уг семинарт хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах, үүсэж буй бэрхшээлтэй асуудлууд, яамд, хүүхдийн байгууллагууд болон төрийн бус байгууллагуудын төлөөлөгчид санал бодлоо солилцов. Түүнчлэн Эмэгтэйчүүд, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийн талаарх судалгааг хийж гүйцэтгүүлэхээр хоёр төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж байна.

Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, статистик мэдээллийн талаар:

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгааг гадаадаас ажиллах хүч авч ажиллуулж байгаа барилга, уул уурхай боловсруулах үйлдвэрлэл, цахилгаан дулаан үйлдвэрлэл, усан хангамж гэсэн салбаруудаар Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газартай хамтран хийж, нийт 500 аж ахуйн нэгжүүдийг түүвэрлэн судалгаанд хамруулав.

Хөдөлмөрийн статистикийн ойлголт тодорхойлолт, системийг шинэчлэн сайжруулах чиглэлээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Ядуурлын судалгаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг хөгжүүлэх” төслийн хүрээнд Олон Улсын болон Үндэсний зөвлөхүүдтэй хамтран ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд Хүн амын хөдөлмөр эрхлэлт болон ажиллах хүчний тухай үндсэн ойлголт, тодорхойлолтыг шинэчлэх, ажилгүй хүн ам, ажил эрхлээгүй хүн амыг хэрхэн тодорхойлох, ажилгүйдлийн түвшинг хэрхэн тооцох талаар зөвлөмж гарах юм. Уг санал зөвлөмжийг гарсны дараа холбогдох газруудтай ажлын хэсэг байгуулж одоо мөрдөж байгаа хөдөлмөрийн холбогдолтой захиргааны статистикийн үзүүлэлтүүдийг өөрчлөн шинэчилэх, ойлголт тодорхойлолттой шинэчлэх, ОУХБ-ын статистикийн мэдээ тайланг бүрэн гаргадаг болох юм.

2.2. Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилт, үр дүн:

“1995 оноос өмнө цэргийн албан хаагчийн тэтгэвэр тогтоолгосон иргэнд нэг удаагийн буцалтгүй тусламж олгох тухай” УИХ-ын 2007 оны 11 дүгээр сарын 30-ны 88 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор “Журам батлах тухай” Сангийн сайд, Нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 61/18 тоот тушаалыг 2008 оны 2 дугаар сарын 12-ны өдөр батлуулан хэрэгжүүлж байна. Энэхүү нэг удаагийн буцалтгүй тусламж олгох арга хэмжээнд 2008 оны 12 дугаар сарын 1-ний байдлаар 5400 гаруй хүнд 5 тэрбум 400 гаруй сая төгрөг зарцуулагдаад байна. Түүнчлэн Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны яам, Монголын Ахмад багш нарын холбоотой хамтран 1996 оноос өмнө өндөр насны тэтгэврээ тогтоолгосон ахмад багш нарт нэг удаагийн буцалтгүй тусламж олгох асуудлыг судлаж, 1996 оноос өмнө боловсролын байгууллагад ажиллаж байгаад нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тогтоолгон авч байгаа иргэдийн судалгааг аймаг, нийслэл, дүүрэг бүрээр гаргав.

БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалын сангаас шимтгэл буцаан авах эрх үүссэн иргэдийг Монгол Улсын тэтгэврийн даатгалд хамруулах тухай журам”-ыг боловсруулан, НХХ-ийн сайдын 2008 оны 16 дугаар тушаалаар батлуулав. Монгол Улсын Нийгмийн даатгалын ерөнхий газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний тэтгэврийн алба хоорондын “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албанд төлсөн тэтгэврийн даатгалын шимтгэлээ буцаан авах эрх үүссэн 12917 иргэний 10.69 тэрбум вонны шимтгэл буцаан олгох ажлыг зохион байгуулж байна. 2008 оны 12 дугаар сарын 1-ний байдлаар нийт шимтгэл буцаан авах эрх бүхий 3453 иргэний 3,4 тэрбум вонны шимтгэл нэхэмжилсэн нэхэмжлэх баримт бичгийг хүлээн авч, баталгаажуулан 1-27 ээлж болгон БНСУ-ын “Үндэсний тэтгэврийн алба”-нд хүргүүлснээс 2897 иргэнд 2,9 сая ам.долларыг буцаан олгоод байна. 2008 оны 12 дугаар сарын 1-ний байдлаар шимтгэлээ буцаан авахаар нэхэмжлэл гаргасан 672 иргэн 72,4 сая төгрөгийн шилжүүлэн даатгалд хамрагдахаар гэрээ байгуулснаас 407 даатгуулагчийн 44.9 сая төгрөгийн шимтгэлийг нийгмийн даатгалын санд төвлөрүүлэв.

Засгийн газрын 2008 оны “Нийгмийн даатгалын сангийн бие даасан байдлыг хангах, сангийн хөрөнгийн менежментийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 139 дүгээр тогтоолыг хэрэгжилтийг зохион байгуулав. Энэ нь тэтгэврийн нэрийн дансны тогтолцоонд шилжих ажлыг эрчимжүүлэх, шилжилтийн үеийн Засгийн газрын хүлээх санхүүгийн үүргийг тодорхой болгох зорилготой юм. Уг ажлын хүрээнд тэтгэврийг нь төр хариуцах иргэдэд 2007 оныг дуустал хугацаанд тэтгэврийн даатгалын сангаас зарцуулсан хөрөнгийн хэмжээ, уг санд Засгийн газраас олгосон санхүүжилтийг тооцон дутуу төлөгдсөн хөрөнгийн хэмжээгээр Засгийн газрын өрийн бичиг гарган, түүнийг 2015 он хүртэл барагдуулах хуваарь гаргаж, жил бүрийн төсөвт тусгах арга хэмжээ авах, Засгийн газрын өрийн бичгээс тодорхой хэсгийг 2008 онд мөнгөжүүлэн Нийгмийн даатгалын санд байршуулах хөрөнгийг төсвийн тодотголд тусган шийдвэрлүүлэх, Монголын Үйлдвэрчний Эвлэлүүдийн холбоо, Монголын Ажил олгогч эздийн *Íǰǰǰǰǰ* холбооны төлөөллийг оролцуулан даатгуулагчийн талаарх мэдээллийг нийгмийн даатгалын санд даатгуулагч нэг бүрээр оруулан нэгтгэж, нягтлах замаар тэтгэврийн нэрийн дансны үлдэгдэл, төр хариуцах санхүүжилтийн хэмжээг үндэслэлтэй тооцох, нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл болон нэрийн дансны нөөц хөрөнгийг өсгөх, хуримтлал бий болгох, өвлүүлэх, санхүүгийн менежментийг боловсронгуй болгох эрх зүйн зохицуулалтыг бий болгох чиглэлээр холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал боловсруулах ажлуудыг гүйцэтгэв.

Өнөөгийн тэтгэврийн тогтолцоог шинэчилж, тэтгэврийн даатгалын олон эх үүсвэр бүхий олон давхаргат тогтолцоог бий болгох, бодлогын үзэл баримтлал, чиглэлийг тодорхойлох зорилтын хүрээнд Нийгмийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Суурь тэтгэврийн даатгалын тухай хуулийн төслийг боловсруулан ажиллаж байна. Үндэсний суурь тэтгэврийн даатгалын болон хувийн нэмэлт тэтгэврийн даатгалын тогтолцооны тооцоо, судалгаа, үнэлгээ, зөвлөмж, Монгол Улсад нэвтрүүлэх боломж, өнөөгийн байдлын үнэлэмж, бусад орнуудын туршлага зэрэг үлэмж хэмжээний судалгааны тайланг боловсруулах ажлыг Лексенбургийн Засгийн газрын тусламжтайгаар АХБ-ны дэмжлэгтэйгээр 500.0 мянган USD-ийн төслийн хүрээнд авч хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд хийгдсэн судалгаа шинжилгээний нөөцөд тулгуурлаж Тэтгэврийн шинэчлэлийн үндсэн тогтолцоо, баримт материалыг боловсруулж байгаа бөгөөд үүгээр Бүх нийтийн тэтгэврийн даатгалын тогтолцоог бий болгох, сангийн нөөцийг хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд оролцуулах өргөн боломжийг эрэлхийлж байна. Бүх нийтийн тэтгэврийн тогтолцоог Монгол Улсад бий болгох, өнөөгийн тэтгэврийн даатгалын тогтолцооны өртгийг тодорхойлох ажлыг хийж байгаа бөгөөд тус яамны холбогдох мэргэжилтнүүд Дэлхийн банк, АХБ-ны удаа дараагийн сургалтанд хамрагдсан болно. Мөн Засгийн газрын энэ зорилтын хүрээнд хийгдсэн нэг чухал ажил нь Бүх нийтийн тэтгэврийн даатгалын олон давхаргат тогтолцоог нэвтрүүлэхэд санхүүгийн зохистой шинжилгээг хийх Дэлхийн банкны PROST програмчлалыг манай улсын холбогдох байгууллагууд ашиглах өргөн боломжтой болсон явдал юм.

Тэтгэврийн шинэчлэл, түүний сонголтын нөхцлийг тодорхойлогч PROST загварчлалын програмыг Монгол Улсын Засгийн газрын хэрэгцээнд нэвтрүүлж эхлэхтэй холбогдуулан тус програм дээр ажиллах чадварыг эзэмшүүлэх зорилгоор холбогдох сургалтыг 2008 оны 2 дугаар сарын 25-29-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгууллаа. PROST нь уян хатан, олон улс орны тэтгэврийн тогтолцооны нөхцөл байдалд хялбар нэвтрүүлэх боломжтой компьютер хэрэглээнд тулгуурласан загварчлал юм. Уг загварчлал нь шинэ тогтолцоонд хамрагдсан насны

үечилсэн бүлгүүд, шинэчлэлийн өмнө ажилласан жилээс хамааран хуримтлагдсан тэтгэврийн эрхийн асуудал зэрэг шинэ тогтолцоонд шилжих шилжилтийн үе шатуудыг шинжлэх боломжтой. Сургалтад Засгийн газрын төлөөлөл 15 хүн оролцож, 3 дугаар сараас эхлэн уг програм дээр ажиллуулах, тэтгэврийн холбогдолтой санхүүгийн үнэлгээ, шинэчлэлийн хувилбаруудыг танилцуулах боломжтой боллоо

Монгол Улсын Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу “Даатгуулагчид үзүүлэх тусламж үйлчилгээний зардлын хэмжээ”-г Эрүүл мэндийн сайд, Сангийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2008 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 84/131/34 тоот хамтарсан тушаалаар шинэчлэн батлуулав. Даатгуулагчийн хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний дундаж суурь тарифийг 160000 төгрөг, амбулаторийн үзлэг 6000 төгрөг болгон нэмэгдүүлсэн байна. Иргэний эрүүл мэндийн даатгалын хуульд нэмэлт өөрчлөлт орж өртөг ойролцоо оношийн 22 бүлгээр эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээг ялгавартай тарифаар санхүүжүүлж байгаа боловч эрүүл мэндийн байгууллага хэвийн үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй хэвээр байсан. Зардлын хэмжээг дунджаар 80 орчим хувиар нэмэгдүүлсэнээр санхүүжилтын хэмжээ тусламж үйлчилгээний бодит өртөгтэй ойролцоо түвшинд хүрч, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдах, даатгуулагч чанартай тусламж үйлчилгээ хүртэх, тусламж үйлчилгээний чанарт хяналт тавих боломжийг бүрдүүлж өглөө.

УИХ-аас 2008 оны 5 дугаар сарын 8-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр тэтгэмж, төлбөрийн тухай хуулиудын нэмэлт, өөрчлөлтөөр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг тогтоох жагсаалтыг шинэчлэн батлах эрх Эрүүл мэндийн болон Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн сайд нарт олгогдсоны дагуу “Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоох жагсаалт”-ыг шинэчлэн боловсруулж, Эрүүл мэндийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2008 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 174/137 дугаар хамтарсан тушаалаар батлуулав. Өвчний жагсаалтыг олон улсын ангиллын дагуу өөрчилж, эмийн болон мэс заслын эмчилгээгээр эмчлэгдэх боломжтой зарим архаг өвчнийг хасаж, Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын тухай хуулийн дагуу буурч буй зарим мэргэжлийн өвчний хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг бууруулах, зарим өвчний хөдөлмөрийн чадвар алдалтын хугацааг нарийвчлан тогтоох зэрэг өөрчлөлт оруулав.

Гурван жилийн хугацаанд эрүүл мэндийн даатгалын сангаас зардал гаргаагүй даатгуулагчийг нэг удаа үзлэгт хамруулах тухай журмын төслийг УНДЕГ-тай хамтран боловсруулж Эрүүл мэндийн яам, Сангийн яам, Эрүүл мэндийн тусламжийн газрын саналыг тусган Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлөөр 2 удаа, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хурлаар 1 удаа хэлэлцүүлэн дэмжигдсэн ба зөвлөлүүдийн саналуулыг тусган албажуулахаар дахин НДҮЗ-д хүргүүлээд байна. Энэ журмыг хэрэгжүүлснээр аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчлөлийг илрүүлэн эрт оношилж, эмчилгээний үр дүнг дээшлүүлэх боломж олгоно. Нөгөө талаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, үр ашиг, хүртээмжийн тэгш байдлыг сайжруулахад чиглэсэн урамшууллын тогтолцоог нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалыг бүх нийтийг хамарсан нийгмийн эрүүл мэндийн даатгалын хэлбэрээр хөгжүүлэхэд тодорхой алхам болно. Түүнчлэн даатгуулагчийг нэг удаагийн бүрэн үзлэгт үнэ төлбөргүй хамруулах нь тэдэнд урамшууллын хөшүүрэг болоод зогсохгүй

даатгалын ашиг тусыг хүлээн зөвшөөрч даатгалд хамрагдах сонирхолыг нэмэгдүүлэх болно.


Ерөнхийлөгчийн захирамжаар Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, хуульд эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэн хөгжлийн бэрхшээлтэй даатгуулагчийн протези, ортопедийн зардлыг санхүүжүүлэх, эмийн үнийн хөнгөлөлтийг өрхийн эмчийн жороос гадна эрүүл мэндийн нэгдсэн төвийн эмчийн жороор олгох, даатгалын сангаас үнийг чөлөөлөх, үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн жагсаалтад орсон эмийн хөнгөлөлтийн хэмжээ болон үнийн дээд хязгаарыг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн тогтоох зэрэг өөрчлөлтийг боловсруулан тусгав. Хууль батлагдсанаар эмнэлгийн шаардлагагүй хэвтэлтийн тоог бууруулах, иргэд эрүүл мэндийн даатгалын үр шимийг илүү хүртэх, даатгалын ач холбогдлыг ойлгож даатгалд хамрагдах сонирхол нь нэмэгдэх, эмийн зохистой хэрэглээ сайжрах боломжийг бүрдүүлэх юм.

Нийгмийн халамжийн багц хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хэрэгжилтийг зохион байгуулж, хуулийг дагалдан гарах журам, дүрмүүдийг батлуулав. Тухайлбал,

Нийгмийн халамжийн багц хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэдийг дэмжих арга хэмжээнд 2008 оны 12 дугаар сарын 1-ний байдлаар 261,4 мянган хүнд 35,5 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, үйлчилгээнд хамруулаад байна.



2007 оны мөн үеийнхтэй харьцуулахад хамрагдсан хүний тоо 30 орчим хувиар, хөрөнгийн хэмжээ 50 орчим хувиар нэмэгдсэн байна.



Нийгмийн халамжийн зарим тусламжийн хэмжээ нэмэгдсэнтэй холбогдох 1.8 тэрбум төгрөгийг 2008 оны Монгол Улсын Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэмж тусган хэрэгжүүлж байна. 2008 оны 12 дугаар сарын 1-ний байдлаар:

- 3 хүртэлх насны ихэр хүүхдэд жилд нэг удаа олгож байгаа 60000 төгрөгийг 941 хүүхэд авч энэ арга хэмжээнд 54,8 сая төгрөг,
- Байнгын асаргаа шаардлагатай иргэнд улиралд нэг удаа олгож байгаа 30000 төгрөгийг 6101 ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн авч энэ арга хэмжээнд 357,6 сая,
- 3 ба түүнээс дээш тооны /14 хүртэлх насны/ хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт жилд нэг удаа олгож байгаа 60000 төгрөгийг 820 эх /эцэг/ авч 83,8 сая төгрөг,
- 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэнд нэг удаа олгож байгаа 500000 төгрөгийн мөнгөн тусламжийг 799 бүтэн өнчин залуус авч энэ арга хэмжээнд 385,6 сая төгрөг,
- Гэнэтийн аюул ослын улмаас орон гэргүй болсон өрхөд нэг удаа олгож байгаа 500000 төгрөгийг 1228 өрх авч энэ арга хэмжээнд 777,8 сая төгрөг тус тус зарцуулаад байна.

Мөн түлээ, нүүрсний хөнгөлөлтийг 140000 төгрөг болгон нэмэгдүүлж, хот суурийн газарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулиас гэрт, гэрээс сургуульд нь хүргэн өгч байгаа асран хамгаалагч, харгалзан дэмжигчид жилд нэг удаа 90000 төгрөгийн мөнгөн тусламж олгож эхэлсэн нь тусламжид хамрагдаж байгаа иргэдийн талархалыг хүлээж байна.

Хүүхдийн мөнгө, шинэ гэр бүл, шинэ төрсөн хүүхэд хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэв. “Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай” хуулийн дагуу 2008 оны 12 сарын 1-ний байдлаар:

- 948,9 мянган хүүхдэд 30,4 тэрбум төгрөгийн,
- 57,2 мянган шинэ төрсөн хүүхдэд 5,7 тэрбум төгрөгийн,
- 29,3 мянган шинэ гэр бүлд 14,6 тэрбум төгрөгийн,
- 79,4 мянган жирэмсэн болон нярай хүүхэдтэй эхэд 14,0 тэрбум төгрөгийн,
- 132,1 мянган алдарт эхийн одонтой эхэд 8,5 тэрбум төгрөгийн

нийт 1,25 сая иргэнд 73,3 тэрбум төгрөгийн тэтгэмж, тусламж олгоод байна.

Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавъяат цолтон ахмад настанд төрөөс олгох нэмэгдлийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд 1,089 тэрбум төгрөг 2008 оны төсвийн тодотголд тусгагдан Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын цолтон ахмад настанд сар бүр 200,0 мянган төгрөг, гавъяат цолтон ахмад настанд сар бүр 150,0 төгрөгийн нэмэгдлийг 2008 оны 7 сарын 1-ээс тооцон олгож эхлээд байна.

Нийгмийн халамжийн тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлийн ажиллах дүрмийг шинэчлэн боловсруулж, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2008 он 6 дугаар сарын 5-ны өдрийн 75 дугаар тушаалаар батлуулж, мөрдүүлэв. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, үйлчилгээнд хамрагдах иргэдийг сум, хорооны нутгийн захиргааны болон иргэний нийгмийн төлөөлөл бүхий Амьжиргааг дэмжих зөвлөл тодорхойлохоор хуульд тусгагдсаны дагуу зөвлөлийн ажиллах дүрмийг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын тушаалаар батлуулан хэрэгжүүлж байна. 2008 онд Нийгмийн халамжийн тухай хуулинд орсон нэмэлт, өөрчлөлтөөр 2000-аас дээш хүн амтай баг, тосгонд Амьжиргааг дэмжих зөвлөл ажиллуулах, тэдгээрт улиралд нэг удаа урамшуулал олгох асуудлууд тусгагдсаныг энэхүү дүрмээр зохицуулахаар зааж өгөв.

Нийгмийн халамжийн тухай хуулинд орсон нэмэлт, өөрчлөлтөөр халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, үйлчилгээний нэр төрөл нилээд өөрчлөгдсөнтэй холбогдуулан нийгмийн халамжийн сангийн сарын мэдээний маягт, улирлын тайлангийн маягтыг шинэчлэн боловсруулж, Сангийн сайд болон НХХ-ийн сайдын 2008 оны 80/256 дугаар хамтарсан тушаалаар батлуулж, мөрдүүлэв. Энэхүү мэдээ тайлангийн маягт нь хөрөнгийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт зэргийг нилээд дэлгэрэнгүй тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, үйлчилгээний зардлын зүйл ангиар нарийвчлан гаргасан тул хяналт тавихад хялбар болж төсвийн хөрөнгийг зориулалтын бус зүйлд зарцуулахаас урьдчилан сэргийлэх боломжтой болгож, хөрөнгийн зарцуулалтад нарийвчилсан судалгаа хийх, төсөв зохиоход гарах хүндрэлийг багасгасан зэрэгт ач холбогдолтой юм.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо нь нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтнаас бүрдэнэ” гэж заасан. Гэвч нийгмийн халамжийн үйлчилгээг хариуцсан орон тооны ажилтан нийт сумдын 80 хувьд, нийслэлийн хороодын 100 хувьд нь байхгүй байсан ба Сумдын ЗДТГ-ын нийгмийн бодлогын түшмэл нь боловсрол, соёл, эрүүл мэнд, иргэний бүртгэл, хөдөлмөр эрхлэлт, ядуурал, байгаль орчин зэрэг олон асуудлуудын хавсрага байдлаар нийгмийн халамжийн үйлчилгээг хүргэж байна. Нийгмийн халамжийн тусламж, үйлчилгээнд тухайн сумын нийт хүн амын бараг 80-90 хувь нь хамрагдаж байгаа бөгөөд жилд нэг суманд дунджаар 5-6 тэрбум орчим төгрөгийн тусламж үйлчилгээг орон тооны бус ажилтан дээрх олон ажлын хавсрага байдлаар захиран зарцуулж байгааг холбогдох байгууллагад дамжуулж, тооцоо судалгааг хийсний үндсэн дээр 2008 оны 4 сараас эхлэн нийслэлийн 89 хороо, 5 аймгийн 13 суманд нийгмийн халамжийн асуудал хариуцсан нийгмийн ажилтныг ажиллуулж эхлээд байна.

Цаашид Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу үлдсэн 270 сум, 43 хороонд орон тооны нийгмийн ажилтныг ажиллуулж төсвийн хөрөнгийн зарцуулалтыг сайжруулах, хариуцлага тооцох боломжийг бүрдүүлэх, хуулийн дагуу олгогдох тэтгэвэр, тэтгэмж, туслаж, хөнгөлөлт, үйлчилгээг анхан шатанд иргэдэд хүнд сурталгүй, хөнгөн шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх үүднээс цалингийн сан, төрийн албаны тухай хуулийн дагуу тухай ажилтныг ажиллах нөхцлийг хангах техник тоног төхөөрөмж, бусад үйл ажиллагааны зардлыг тусгасан тооцоог хийж, 2009 оны төсөвт энэ арга хэмжээнд тодорхой хэмжээний төсөв батлагдаад байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 6.9, Засгийн газрын 2008 оны 162 дугаар тогтоолд заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт нийгмийн халамж үйлчилгээний анхан, дунд шатны байгууллагын үйл ажиллагааны талаар мэргэжлийн зөвлөгөө өгөх, нөхцөлт мөнгөн тэтгэмж, мөнгөн тусламж болон нийгмийн халамжийн зориулалттай хөрөнгийн, зээлийн, хандивын зарцуулалтад хяналт тавих, хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага ногдуулах үүрэг бүхий хяналт, шинжилгээ, үнэлгээний нэгж, ажилтан ажилуулахаар заасны дагуу 5 орон тоо, 21 аймаг, 9 дүүргийн хэлтэс тус бүрд 30 орон тоо нийт 35 орон тоог нэмүүлэхээр холбогдох тооцоог хийж, 2009 оны төсөвт тусгуулав.

“Нийгмийн халамжийн тухай хууль”-ийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.3 дахь хэсэг, “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэний хоногт хэрэглэх хоолны норм, илчлэгийн хэмжээ, зардлын дундаж норматив”, “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэний хувцас, ариун цэвэр, хичээлийн хэрэглэлийн зардлын дундаж норматив, эдэлгээний хугацаа”, “Төрөлжсөн асрамжийн газарт зайлшгүй байх эмийн жагсаалт”, “Төрөлжсөн асрамжийн газарт нас барсан иргэнийг оршуулах зардлын дундаж хэмжээ”, “Төрөлжсөн асрамжийн газарт үйлчлүүлэгчийг хүлээн авах, шилжүүлэх, гаргах журам”, “Асрамжийн газрын төсвийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-уудыг боловсруулж, НХХ-ийн сайдын 2009 оны 139 дүгээр тушаалаар батлуулж, мөрдүүлэв.

Сангийн яам, Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичиг болон Засгийн газраас баталсан “Нийгмийн эмзэг бүлгийн хүн амд хоол, тэжээлийн дэмжлэг үзүүлэх дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зардлыг Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжийн хүрээнд санхүүжүүлэхээр Монгол Улсын Засгийн газар болон Азийн хөгжлийн банкны хооронд хэлэлцээрийг 2008 оны 11 дүгээр сард Сангийн яам, НХХЯ-ны төлөөлөлтэйгээр зохион байгуулав. Дээрх хэлэлцээрийн хүрээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор “Хүнсний хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих нэгж”, “Төсөл хэрэгжүүлэгч нэгж”-ийг байгуулж, ажилтнуудын сонгон шалгаруулалтыг явуулав.

Нийгмийн ажилтныг мэргэшүүлэн сургах 3 дугаар шатны сургалтын тооцоог аймаг тус бүрээр нь болон нэгтгэлээр, сургагч багш нарын шардал холбогдох зардлын тооцоог нарийвчлан гаргаж, сургалтын хуваарь, төсвийн тооцоо зэргийг боловсруулан НХХ-ийн сайдын 2008 оны 3 сарын 26-ны өдрийн 33 дугаар тушаалаар батлуулан зардлыг Нийгмийн халамжийн сангаас гарган хэрэгжүүлэв. Тушаалыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт хүргүүлж, сургалтыг 2008 оны 4-6 сард 21 аймаг, 9 дүүрэг тус бүрд зохион байгууллаа. Сургалтыг аймаг, дүүрэг тус бүрд зохион байгуулах үндсэн 5 баг бүрдүүлж, баг бүрт МУИС, БСИС, ШУТИС, УЗНАДС,

ЭМШУИС-ийн нийгмийн ажлын мэргэжлийн 2 багш, НХХЯ, ХХҮГ-ын холбогдох нэг мэргэжилтэн ажиллаж, нийт 1038 нийгмийн ажилтанг хамруулав.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээнд хамрагдах өрх толгойлсон эх /эцэг/, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, бүтэн өнчин хүүхэд, байнгын асаргаа шаардлагатай иргэд, хүүхдийн мөнгөн тэтгэмж авч байгаа өрх, алдарт эхийн одонтой эхчүүд, шинэ төрсөн хүүхэд, шинэ гэр бүл зэргийг байршил, хүйс, нас зэрэг үзүүлэлтээр нарийвчлан гаргах “Халамжийн үйлчилгээний менежер” программыг бий болгохоор тендер шалгаруулан “ЕСМ” ХХК-тай ХХҮГ гэрээ байгуулан ажиллаж эхлээд байна. Энэ программыг 21 аймаг, 9 дүүрэг, болон сум, хороодын асуудал хариуцсан ажилтнуудын компьютерт суурилуулж, нэгдсэн мэдээллийн сан бий болгох ажлыг 2009 оноос эхлэн хийнэ. 2009 оны 4 дүгээр улирлаас эхлэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн бүртгэлийг хүн ам зүйн судалгаанд оруулан өсөлт, бууралтыг он оноор нь харьцуулсан дүн шинжилгээ хийх боломжтой болох юм.

2.3. Хүн ам, нийгмийн бүлгүүдийн бодлогын хэрэгжилт, үр дүн:

НҮБ-ын Хүн амын сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх “Хүн ам, жендэр, нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудлыг ядууралтай уялдуулах нь” MNG4P202 төслийн 2008 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулав. Энэхүү төслийн хүрээнд 2008 онд Гэр бүлийн тухай хууль, Насжилтын стратеги, Өрхийн амьжиргааг дэмжих Үндэсний хөтөлбөрийг боловсруулах, Хүн амын шилжих хөдөлгөөний судалгаа, Ажиллах хүчний хэтийн тооцоо хийх, хүн ам, хөгжлийн асуудлаар ухуулга, сурталчилгааны материал боловсруулан хэвлүүлэх, асуудал хариуцсан ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх сургалт семинар зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх зэрэг чиглэлээр ажиллаж, нийт 47.0 мянга гаруй ам.долларыг зарцуулахаар төсөвлөв.

НҮБ-ын Хүн амын сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Удирдлагын академийн Боловсрол, Нийгмийн удирдлагын сургуультай хамтран яамдын газрын дарга нарт “Хүн ам, хөгжил”-ийн асуудлаар сургалт зохион байгуулав. Сургалтын хөтөлбөрт хүн амын хөгжлийн асуудлыг бодлого төлөвлөлт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлэх, хүн ам, хөгжлийн асуудлаар хэрэгжиж бодлого хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах, хяналт-шинжилгээ үнэлгээг тогтмолжуулах, түүний үр дүнг ашиглах явдлыг сайжруулах зэрэг асуудлыг тусган зохион байгуулав.

Амьжиргааны түвшнээс доогуур орлоготой иргэдийн тоог бууруулах, орон гэргүй иргэдийг гэржүүлэх ажлыг зохион байгуулж ажиллав. Гэржүүлэх арга хэмжээний хүрээнд нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын багцад 750 сая төгрөг тусгагдаж, үүнтэй холбогдуулан гэр нийлүүлэх тендерийг зарлаж, зохион байгуулсанаар Хараагүйчүүдийн үйлдвэр, “Богд-Өргөө” ХХК тус тус шалгаран Хараагүйчүүдийн үйлдвэр 500, Богд-Өргөө ХХК-аас 610 нийт 1110 гэр нийлүүлэв. Гэржүүлэх ажлыг харьяа аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын тамгын газраар дамжуулан орон гэргүй, амьдралын бололцоо муутай өрх, иргэдэд олгоод байна.

НҮБХХ-ийн Ядуурлын судалгаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг хөгжүүлэх төслийн газраас амьжиргааны түвшин тогтоох олон хэлбэрийг боловсруулах, Ядуурлын зураглалыг тооцож гаргах зорилгоор Олон улсын зөвлөхүүд ирж ажилласан бөгөөд үр дүнг эхний байдлаар гаргаад байна. Ядуурлын зураглалыг

гаргаснаар бодлого үйл ажиллагааг хаана илүү чиглүүлэх, сум, дүүрэг зэргээр микро түвшинд ядуурлын хамралт, бусад үзүүлэлт ямар байгааг харах боломжтой болох юм. Ядуурлын зураглалд үндэслэн амьжиргааны түвшин тогтоох олон хэлбэрийг тодорхойлохоор төлөвлөж байна.

“Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих Үндэсний хөтөлбөр-2”-ийн төслийг хүний хөгжлийн зарчимд тулгуурлан, ядуу нэн ядуу иргэдийн өөрсдийнх нь санал санаачилгад дэмжлэг үзүүлэх чиглэлээр боловсруулж, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгчдийг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулж, гарсан саналыг төсөлд тусгаад байна. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод ядуурлын түвшинг 1990 оныхоос 2 дахин бууруулах зорилтыг дэвшүүлсэн билээ. Үүнийг бүрэн хэрэгжүүлэхийн тулд 2015 он гэхэд нийт ядуу өрхийн тоо 100,0 орчим мянгад хүрсэн байх ёстой бөгөөд 2008-2012 оны хооронд ядуу өрхийн тоог 50,0 мянгаас доошгүйгээр бууруулах зорилт Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан. Иймд өмнө нь боловсруулаад байгаа Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөр, Гэр бүлийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн төслүүдийн үзэл санааг нэгтгэн тусгасан салбар дундын оролцоог хангасан, өрхийн хэрэгцээ, чадавхи, санаачилгыг дэмжих “Өрхийн хөгжлийн Үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулахаар ажиллаж байна. Энэхүү хөтөлбөрийг батлуулж, хэрэгжүүлснээр

- 50,000-аас доошгүй өрхийн амьжиргаа дээшлэх,
- Өрхийн амьжиргааны түвшний байдлаар ангилсан үндэсний хэмжээний мэдээллийн сантай болох,
- Ядуурлыг бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг үнэлэх, мониторинг хийх тогтолцоо бүрдэх бололцоотой болно.

Хүн амын хөгжил, ядуурлыг бууруулах чиглэлээр орон нутагтай хамтран ажиллав. Тухайлбал, Дорноговь, Төв, Дархан-Уул, Орхон аймагт тэнэмэл, орон гэргүй, гэмт хэрэгт өртөмтгий зэрэг хүнд нөхцөлд байгаа хүүхдийг нийгэмшүүлэх замаар тэдний тоог бууруулах, Булган, Өвөрхангай, Увс, Ховд, Хөвсгөл аймагт ядуу, нэн ядуу өрхүүдтэй өрхийн хөгжлийн төлөвлөгөө хамтран боловсруулж, холбогдох төсөл хөтөлбөрт хамруулах замаар амьжиргааг нь дээшлүүлэх, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Завхан, Өмнөговь аймагт ядууралтай тэмцэх компанит ажил зохион байгуулах, Архангай, Баян-Өлгий, Дорнод, Дундговь, Өвөрхангай, аймагт иргэдийг хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх эрүүл зан үйл, дадал хэвшлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, ухуулга сурталчилгааны ажил зохион байгуулах, Сүхбаатар, Хөвсгөл, Говьсүмбэр аймагт орон нутгийн хэмжээнд хүйсээр ангилсан хүн амын мэдээллийн сан байгуулах зэрэг ажилд санхүүжилт олгож, дэмжлэг үзүүлж ажиллав.

Ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, өрхийн амьжиргааг дэмжих хүрээнд хэрэгжүүлж буй олон улсын төсөл, хөтөлбөрүүдийг үр өгөөжтэй, үр дүнтэй болгох, тэдгээрийн уялдааг хангах зорилгоор төсөл, хөтөлбөрүүдийн удирдах ажилтнуудын уулзалтыг 2008 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулав. Эдгээр төслийн хүрээнд хийгдэж буй шинжилгээ, судалгаа, мэдээлэл нь ядуурал, ажилгүйдэл, өрхийн амьжиргааны өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, цаашдын зорилтоо тодорхойлох, улмаар бодлогын баримт бичгүүдийг боловсруулахад нэн шаардлагатай тул мэдээллийн нэгдсэн сан бий болгох; төслүүдийн нийгэм, хамт олон, иргэн хүнд авчирч буй үр өгөөж, ач холбогдол, түүнчлэн төр, засгаас авч хэрэгжүүлж буй бодлогыг хэрэгжүүлэхэд оруулж буй хувь нэмрийг үнэлэх, үүний тулд нэг зорилго чиглэлтэй, өөр өөр салбарын яамдад

хэрэгждэг төслүүдийг бодлогын болоод үйл ажиллагааных нь хувьд зангидаж, үр дүнг нэгтгэн тооцож, нэгдсэн мэдээлэл гаргаж байх хэрэгцээ байгааг тэмдэглэн цаашид хэрхэн хамтарч ажиллах талаар санал бодлоо солилцлоо.

Мөн “Ядуурлыг бууруулах зорилт-төрийн бус байгууллагын оролцоо” уулзалт, ярилцлагыг Ерөнхийлөгчийн Тамгын газартай хамтран зохион байгуулав. Уулзалтад Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газрын холбогдох төлөөлөгчдөөс гадна 80 гаруй төрийн бус байгууллагын төлөөлөгч оролцсон бөгөөд хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын зорилтыг хэрэгжүүлэхэд хэрхэн үр дүнтэй хамтран ажиллах асуудлаар хэлэлцэж тодорхой зөвшилцөлд хүрлээ. Үүний үр дүнд төрийн бус байгууллагаас Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамтай хамтран ажиллах ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулаглаа.

Дэлхийн хүн амын байдал 2008 илтгэлийг “Соёл уламжлал, жөндөр ба хүний эрхийн асуудлаар нэгдмэл ойлголтонд хүрэх нь” сэдвээр хэвлүүлж, түгээв. Мөн Монгол Улсын хүн амын үндсэн үзүүлэлт 2007 мэдээллийн хуудас, 2007 онд зохион байгуулсан Монгол Улсын хүн амын насжилт ба хөгжлийн асуудлууд Үндэсний форумын илтгэлийн эмхэтгэлийг хэвлүүлэн түгээв.

Монгол Улсын хэмжээнд хүүхдэд үзүүлж буй асрамж, халамжийн үйлчилгээ нь санхүүжилт, үзүүлж буй үйлчилгээний зорилго, төрөл, чанар, байршил, орон байрны нөхцөл, боловсон хүчин, үйлчлүүлэгч хүүхдийн тоо, нас хүйс зэрэг үзүүлэлтийн хувьд хоорондоо ялгаатай, харилцан адилгүй түвшинд байдаг. Тиймээс асрамж, халамжийн байгууллагад байгаа хүүхдийн эрхийг хамгаалах, тэдний эрүүл, аюулгүй орчинд аж төрөх, сурч боловсрох нөхцлийг бүрдүүлэх зорилгоор “Хүүхдийн халамж, асрамжийн үйлчилгээний стандарт”-ын төслийг боловсруулж, БСШУЯ, ХЗДХЯ, ЭМЯ, УМХГ, НҮБ-ын Хүүхдийн сан зэрэг байгууллагуудын санал авч тусган Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний стандартчиллын дэд хорооны хурал, Стандартчиллын Үндэсний зөвлөлийн хурлаар тус тус хэлэлцүүлж, батлуулав. Стандарт нь хүүхдийн асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагад зөвшөөрөл олгох, сунгах хэрэгсэл байх бөгөөд стандарттай болсноор цаашид төрөөс хүүхдийн асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээнд тавих хяналт сайжрах боломжтой болж байна.

Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын удирдлага, ажилтнуудад зориулсан “Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээний стандарт” сэдэвт семинарыг зохион байгуулж, хүүхдийн эрх хамгаалал, түүнтэй холбоотой эрх зүйн орчин, хүүхдэд үзүүлдэг үйлчилгээний төрлүүдийн талаар мэдээлэл хийж, стандартын талаарх ерөнхий ойлголт өглөө.

Хүүхдийг бэлгийн зорилгоор ашиглах, дамжуулан худалдаалахтай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөлийн анхдугаар хурлыг зохион байгууллаа. Зөвлөлийн бүрэлдэхүүнд энэ асуудлаар үйл ажиллагаа явуулдаг төрийн болон ТББ, олон улсын болон хандивлагч байгууллагын төлөөлж, нийт 24 хүн оролцсон бөгөөд хурлаар Үндэсний хөтөлбөрийн батлагдсанаар гарсан ахиц, түүний ач холбогдол болон хөтөлбөрийн дутагдалтай, сул талыг дүгнэн санал бодлоо солилцов. Үндэсний зөвлөлийн гишүүдээс хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр гаргасан саналыг хэрэгжүүлж байна.

Гадаадын иргэнд Монгол Улсын харъяат хүүхэд үрчлэхтэй холбоотой асуудлыг судалж, зөвлөлийн хуралдааныг зохион байгуулж ажиллав. 2008 онд Монгол Улсын харъяат нийт 31 хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлэх асуудлыг судлан шийдвэрлэв. Энэ хүрээнд гадаадын иргэдээс ирүүлсэн хүсэлт, материалтай танилцан, тус яамны дэргэдэх үрчлэлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, үрчлүүлэх боломжтой хүүхдийг сонгон, материалыг нь холбогдох байгууллагад хүргүүлэх, хууль журмын хүрээнд шаардлагатай материалыг бүрдүүлэх зэргээр шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Мөн ХБНГУ-ын Улс хоорондын үрчлэлийн асуудлаар итгэмжлэгдсэн байгууллага болох Элтерн Фюр Киндер байгууллагын урилгаар тус байгууллагын үйл ажиллагаа болон үрчлэгдсэн хүүхдийн нөхцөлд байдалтай танилцлаа. Тус байгууллагын шугамаар үрчлэгдсэн 6 хүүхдийн эцэг эх болон хүүхдүүдтэй уулзаж, түүнээс 4 хүүхдийн аж байдал, гэр орон, сургууль цэцэрлэгтэй нь газар дээр нь танилцав. Үрчлэгдсэн хүүхдийн нөхцөл байдал сайн, эцэг эх, гэр бүл, орчиндоо сайн дасан зохицсон байна. Олон улсын хүүхэд үрчлэлтийн асуудлаарх хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох хүрээнд Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, үрчлэлтийн үйл ажиллагааг улам боловсронгуй болгох, үрчлэгдсэн хүүхдийн аюулгүй байдлыг хангах, эрхийг нь хамгаалах явдлыг улам баталгаажуулахад чиглэсэн өөрчлөлтүүдийг хуулийн төсөлд тусгуулав. Мөн ХЗДХЯ-аас Гэр бүлийн тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт үнэлгээ хийж байгаатай холбогдуулан уг хуулийн хүүхдийн эрх хамгаалалттай холбоотой заалтуудын хэрэгжилтийн талаар мэдээлэл хүргүүлэв.

Улсын болон нийслэлийн хэмжээнд орон гэргүй, хараа хяналтгүй, тэнэмэл амьдралтай хүмүүс, ялангуяа хүүхдүүдийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх, хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудтай цаашид хэрхэн хамтарч ажиллах чиглэлийг тогтох зорилгоор Эрүүл мэндийн яам, Улсын иргэний бүртгэл мэдээллийн газар, Нийслэлийн иргэний бүртгэл мэдээллийн төв, Хүүхдийн төлөө үндэсний газар, ЦЕГ-ын хэв журам хамгаалах газар, Нийслэлийн цагдаагийн газрын Олон нийттэй харилцах хэлтсийн дарга нартай ажил хэргийн уулзалт зохион байгуулж, санал бодлоо солилцов. Нийслэлийн Цагдаагийн газар бүртгэлтэй байгаа тэнэмэл 53 хүүхдийн судалгааг авч, ЭМЯ-тай тохиролцооноор эрүүл мэндийн үзлэгт хамруулж, энэ өвөл халамжийн төвд байршуулахаар бэлтгэл ажлыг хангав. Цаашид салбар дундын уялдаа холбоотой, байнгын үйл ажиллагаатай ажлын хэсэг байгуулж, төлөвлөгөө гаргаж ажиллахаар тогтлоо.

НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран хэрэгжүүлдэг “Чадавхи бэхжүүлэх” төслийн 2008 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж байна. 2008 онд Ажлын хэсгийн ээлжит хурлыг 2 удаа зохион байгуулж, төслийн хэрэгжилтийн явц болон цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийг гаргалаа. Төслийн хүрээнд Бүсчилсэн хөгжлийн үндэсний хороотой хамтран хүүхэд хамгааллын асуудлаар сургагч багш бэлтгэх 4 өдрийн сургалтыг 3 дугаар сарын 17-20-ны өдрүүдэд Улаанбаатар хотод, 3 өдрийн сургалтыг 4 дүгээр сарын 18-20-ны өдрүүдэд Ховд аймагт тус тус зохион байгуулав. Сургалтад Нийгмийн цогц суурь үйлчилгээний хөтөлбөр хэрэгждэг Дорнод аймаг болон нийслэлийн Багануур, Баянгол, Баянзүрх дүүрэг, Увс, Ховд, Баян-Өлгий аймгийн нийгмийн ажилтан, сургуулийн нийгмийн ажилтан, хөтөлбөрийн зохицуулагч зэрэг хүмүүс оролцлоо.

Халамж, асрамжийн төвд байрлаж байгаа хүүхдийн тоог нэг удаагийн тооллого, хяналт үнэлгээгээр гаргадгаас бус мэдээллийн нэгдсэн тогтолцоо байхгүй, хүүхдийн

шилжих хөдөлгөөний мэдээлэл байхгүй, халамж асрамжийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын тоо, үйл ажиллагаа бусдад нээлттэй бус байна. Асрамж, халамжийн төвд байгаа хүүхдийн эрх, хамгаалал, аюулгүй байдлыг хангахад нэгдсэн бүртгэл мэдээллийн тогтолцоо зайлшгүй шаардлагатай байгааг харгалзан Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй халамж, асрамжийн байгууллагад бүртгэлтэй хүүхдийн мэдээллийг санг бий болгох, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг холбогдох мэдээллээр хангах тогтолцоо бүрдүүлэхээр төлөвлөөд байна.

Мэдээллийн сан нь хүүхдийн тоог төрөл бүрийн ангиллаар /нас, бүтэн өнчин, хагас өнчин, эцэг эхтэй, хөгжлийн бэрхшээлтэй, сургуульд хамрагдалт г.м/ гаргаж авах, хүүхдийн шилжих хөдөлгөөнийг хянаж байх, байгууллагын үйл ажиллагааг /гэрт нь буцаахад чиглэсэн, үрчлүүлэхэд чиглэсэн, нийгэмшүүлэх, хөгжүүлэхэд чиглэсэн/ сайжруулахад ашиглагдах бөгөөд энэ үйл ажиллагаанд НҮБ-ын Хүүхдийн сан, Амичи Дей Бамбини байгууллага, Ай Фиори Симпличи байгууллага хамтран ажиллаж, санхүүжүүлэх юм. Одоогийн байдлаар Кареер Март ХХК, Инфосистемс ХХК, АСУ Дисковери ХХК гэсэн 3 байгууллагаас программын санал хүлээн аваад байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, Хүүхдийн төлөө Үндэсний газар, Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбоотой хамтран “Хамтдаа хөгжицгөө” сэдэвт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн үндэсний чуулганыг зохион байгуулав. Чуулганд орон нутгаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, тэдний эцэг эхийн төлөөлөл, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагууд, тусгай сургуулийн багш, сурган хүмүүжүүлэгчдийн төлөөлөл оролцлоо. Чуулганд оролцогсодоос гаргасан санал, зөвлөмжүүдийг “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих дэд хөтөлбөр”-ийг 2009-2010 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөлд тусган хэрэгжүүлэх юм.

Хүүхэд хамгааллын чиглэлээр сургагч багш бэлтгэх, сургалтын модулийн төсөл боловсруулах ажил хийгдэж байна. Хүүхэд хамгаалал болон хүн худалдаалах асуудлаар нийгмийн ажилтнуудад зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах зорилгоор Монголын нийгмийн ажлын багш сурагчдын холбоо, Олон улсын Хүн амын шилжин суурьшлын байгууллага, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран ажиллах тухай Харилцан ойлголцлын санамж бичигт гарын зурж үйл ажиллагааг эхлүүлэв. Хамтын ажиллагааны хүрээнд хүүхэд хамгаалал, хүн худалдаалах гэмт хэргийн талаар нийгмийн ажилтнуудын мэдлэг, чадвар, хандлагад нөлөөлөх сургалтын модуль боловсруулах, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогсод болон хамгаалал шаардлагатай хүүхдүүдэд үзүүлэх үйлчилгээ бий болгож, төлөвшүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх бөгөөд 2008 оны аравдугаар сарын 1-нээс эхлэн 2009 оныг дуустал гурван үе шаттайгаар нийслэл, орон нутагт хэрэгжүүлнэ. 2008 оны 11 дүгээр сард улсын болон хувийн хэвшлийн сургуулийн нийгмийн ажлын багш нарыг оролцуулсан сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулж, сургалтын модулийн төслийг туршив. Цаашид сургалтын модулийг сургагч багш бэлтгэх сургалтанд оролцогчдын болон НҮБ-ын Хүүхдийн сан, яамны саналыг тусган сайжруулж, хэвлүүлэн сургагч багш нар нийслэл, орон нутгийн сургууль, халамжийн бүхий л нийгмийн ажилтнуудыг хамарсан сургалтыг зохион байгуулах юм.

Монгол Улс, БНСУ-ын Засгийн газар хоорондын хүүхэд залуучуудын солилцооны хөтөлбөрийн хүрээнд жил бүр хүүхэд залуучуудыг харилцан солилцож,

хоёр орны нийгэм эдийн засаг, түүх, соёлтой танилцдаг уламжлалтай. Энэ жилийн хоёр орны солилцооны хөтөлбөрийг амжилттай зохион байгууллаа. Монголын залуучуудын төлөөлөл Солонгос улсад 6 дугаар сарын 19-28-нд зочилсон бөгөөд Солонгосын талаас 7 дугаар сарын 1-11-ний хооронд зочиллоо. Энэ жилийн Солонгосын төлөөлөгчдийг хүлээн авах хөтөлбөрийн дагуу тус яамны бодлого, үйл ажиллагааг танилцуулах, хүүхэд залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагын үйл ажиллагаатай танилцах, Солонгос хэл суралцаж буй оюутан залуустай уулзаж санал бодлоо солилцох, Монголын түүх соёл, уламжлалыг хадгалсан дурсгалт газраар аялах, танилцах зэрэг олон арга хэмжээг авав. Энэхүү солилцооны хөтөлбөр нь хоёр орны найрсаг хамтын ажиллагааг улам бэхжүүлэх, хоёр орны түүх соёл, зан заншилтай танилцах боломж олгодгоороо ач холбогдолтой юм.

"Өнөөгийн Монголын гэр бүлийн байдал, хөгжлийн чиг хандлага" сэдэвт онол практикийн бага хурлыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Гал голомт үндэсний хөдөлгөөнтэй хамтран зохион байгуулав. Бага хуралд УИХ, Засгийн газрын зарим гишүүд, яамд, төрийн болон төрийн бус, олон улсын байгууллага, эрдэмтэн судлаачид, хэвлэл мэдээллийн байгууллагын нийт 100 гаруй төлөөлөгч оролцсон. Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, гэр бүлийн харилцааны эрх зүйн орчин, гэр бүл судлал, гэр бүлийн бэхжилт, хөгжилд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар 10 гаруй илтгэлийг хэлэлцэж, 2005 онд зохион байгуулсан 2 дахь удаагийн бага хурлаас хойш олсон ололт амжилтыг үнэлж, тулгамдаж буй асуудал, эн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг тодорхойлон зөвлөмж гаргасан болно. Зөвлөмжид тусгагдсан асуудлыг судлан зарим арга хэмжээг Өрхийн хөгжлийг дэмжих Үндэсний хөтөлбөрийн төсөлд тусгав.

Онол практикийн бага хуралд зориулан эрдэмтэн судлаачдын дунд илтгэлийн уралдаан зарлан шалгаруулах ажлыг зохион байгуулав. Шалгаруулалтад нийт 12 эрдэмтэн судлаач, багш нар илтгэлээ ирүүлснээс "Гэр бүлийн тогтвортой байдал алдагдаж буй шинж, түүнээс зайлсхийх нь", "Гадаад шилжих хөдөлгөөний хувь хүн, гэр бүлд үзүүлж буй үр нөлөө", "Монгол гэр бүлийн харилцааны сэтгэл зүйн өвөрмөц онцлог, цаашдын хөгжлийн төлөв хандлага" сэдэвт илтгэлүүд шалгарсан байна.

"Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх Үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх зорилгоор Гэр бүлийн хүчирхийллийн эрсдлийн нөхцөл байдлыг тодорхойлох үнэлгээний загвар, Нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулын түвшингийн зэргийг тодорхойлох заавар, Цагдаагийн ажилтнаас хохирогчийг төлөөлж эрх хязгаарлах арга хэмжээ авахуулах хүсэлт гаргах загвар, Цагдаагийн ажилтнаас хохирогчийг төлөөлж эрх хязгаарлах арга хэмжээ авахуулах хүсэлт гаргах заавар, Хүчирхийлэл үйлдэгчийн тухай мэдээний маягт, Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн бүртгэлийн маягтыг холбогдох сайдуудын хамтарсан тушаалаар батлуулахаар боловсруулаад байна. Түүнчлэн Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр боловсруулж, ХЗДХ-ийн сайд, НХХ-ийн сайдын тушаалаар батлуулахад бэлэн болгов. Цаашид гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой нэгдсэн мэдээллийн сан бий болгох юм.

НҮБ-аас жил бүр охид, эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй хүчирхийллийг эсэргүүцэх өдрийг тэмдэглэдэг уламжлалын дагуу 11 дүгээр сарын 25-аас 12 дугаар сарын 10-ны өдрүүдэд 16 хоногийн аян зохион байгуулав. Энэ онд "Хүний эрхийн түгээмэл тунхаглал"-ын 60 жилийн ойтой уг арга хэмжээ давхцаж байгаагаараа

онцлог байсан бөгөөд эмэгтэйчүүдийн эрх бүрэн хангагдаагүй нөхцөлд хүний эрх түгээмэл байж чадахгүй хэмээн үзэж, дэлхий нийтээрээ энэхүү аяныг “Хүний эрхийг эмэгтэйчүүдэд, хүний эрхийг бүгдэд” гэсэн уриан дор зохион байгууллаа. Тус аяны хүрээнд “Хүний эрх хүүхдийн эрхээс эхэлнэ” сэдвийн доор бэлгийн мөлжлөг, дамжуулан худалдаалах гэмт хэргийн эсрэг ойлголт нэмэгдүүлэх сургалтыг ЕСРАТ Үндэсний сүлжээтэй хамтран Улаанбаатар хотын 6 дүүргийн алслагдсан захын 18 сургуулийн 3600 гаруй өсвөр үеийнхэнд зохион байгуулсан байна.

Ахмад настны асрамжийн үйлчилгээний болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн халамж, асрамжийн үйлчилгээний стандартын төслийг боловсруулж, энэ оны 11 дүгээр сард Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний стандартчиллын дэд хорооны хурлаар хэлэлцэж дэмжсэний дагуу Стандартчиллын Үндэсний зөвлөлийн 12 дугаар сарын 18-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, батлуулав. Стандарт батлагдсанаар Ахмад настны асрамжийн үйлчилгээний болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамж, халамжийн үйлчилгээний стандарт нь тухайн иргэдэд ийм үйлчилгээ үзүүлэх байгууллагад зөвшөөрөл олгох, сунгах хэрэгсэл байх бөгөөд ийм стандарттай болсноор цаашид төрөөс ахмад настны асрамжийн үйлчилгээний болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээнд тавих хяналт сайжрах ач холбогдолтой юм.

“Ахмад настны жендэрийн мэдрэмжтэй эрүүл мэнд-нийгмийн хамгааллын бодлого” сэдэвт Үндэсний семинарыг тус яамнаас НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисстой хамтран БНСУ-ын Засгийн газрын санхүүгийн дэмжлэгтэйгээр Улаанбаатар хотноо 4 сарын 8-10-ны өдрүүдэд зохион байгуулав. Энэхүү семинараар монголын ахмад настны онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн жендэрийн мэдрэмжтэй эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлого хөтөлбөрийг боловсруулах чадавхийг бэхжүүлэх; Монгол Улсын Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгаалал Үндэсний хөтөлбөрийн хугацаа дуусч байгаатай холбогдуулан дараагийн шатны хөтөлбөрт тусгах гол асуудлыг төв, орон нутгийн түвшинд оролцогчдын дэмжлэгтэйгээр тодорхойлох; ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгааллын тулгамдсан асуудлыг шийдвэрлэж буй Ази, Номхон далайн бүсийн зарим орны болон аймаг, орон нутгийн туршлагыг харилцан сонсож, хэлэлцлээ.

Семинарт УИХ-ын ажлын алба, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Сангийн яам, Эрүүл мэндийн яам, Үндэсний статистикийн газар, Геронтологийн үндэсний төв, Монгол Улсын Их Сургууль, Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль, Хүн судлалын үндэсний төв, аймгуудын Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга нар, Монголын ахмадын холбоо, Монголын эмэгтэйчүүдийн холбоо зэрэг байгууллагын төлөөлөгч 50 гаруй хүн оролцлоо. Семинарын үеэр энэ онд боловсруулахаар төлөвлөж буй Насжилтын асуудлаарх Үндэсний стратеги, Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгааллын хөтөлбөрт тусгах асуудлыг тодорхойлон, үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар баталсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод тусгагдсан гэр бүл төвтэй хүн ам зүйн бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх замаар хүний хөгжлийг хангах, үүний дотор ахмад настанд зориулсан нийгмийн хамгааллыг сайжруулах асуудлыг хэрэгжүүлэх зорилгоор Насжилтын асуудлаарх Үндэсний стратегийн төслийг боловсруулж, холбогдох байгууллага, салбарын төлөөлөгчдийг оролцуулан цуврал хэлэлцүүлэг зохион байгуулав. “Ахмад

настан нь нийгмийн эрх тэгш, идэвхтэй гишүүний хувьд баталгаатай орлоготой байж, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээг тэгш хүртэж, хүндлэл хүлээж амьдрахуйц ээлтэй, эерэг хандлага бүхий нийгмийн тогтолцоог бүрдүүлэх замаар тэдний амьдралын чанарыг дээшлүүлэх явдал юм” хэмээн стратегийн зорилтыг тодорхойлоод байна. Насжилтын үндэсний стратегийг хэрэгжиж буй бүхий л бодлого, хөтөлбөртэй нягт уялдуулах бөгөөд тэдний нийгмийн амьдралд оролцох оролцоог нэмэгдүүлэх, ахмад настан, насжилттай холбоотой тоо мэдээлэл, судалгааг сайжруулах, хяналт үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх, тэдэнтэй ажиллах нийгмийн ажлыг хөгжүүлэх зэрэг асуудлыг төсөлд онцгойлон авч үзсэн болно.

Төрийн бус байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр:

Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар аýдýýíèé çíäñýí äýýð гүйцэтгүүлэх, ТББ-аас гаргасан санал, санаачилгыг дэмжин хамтран ажиллалаа. Тухайлбал,

Хүчирхийллийн эсрэг үндэсний төвтэй хүүхдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах, хүчирхийлэлд өртсөн хүүхдийн хамгаалал, тэдэнд үзүүлэх нийгмийн үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор гэрээ байгуулан, Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулан төсвөөс хувиарласан хөрөнгөнөөс 4,5 сая төгрөгийг олгов.

Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чөлөөт үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо, Монголын сонсголын согогтой иргэдийн “Шинэ элч” холбоо, “Ирээдүйн зөв зам”, “Итгэлт харгуй”, “Хатан дуулал” ТББ-уудтай гэрээ байгуулан хамтран ажиллахаар 108.9 сая төгрөгийн санхүүжилтыг хийгээд байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр үзэсгэлэн, яармаг, сурталчилгаа зохион байгуулахад зориулж 5.3 сая төгрөгийг зарцуулав.

НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран хэрэгжүүлдэг “Чадавх бэхжүүлэх” төслийн хүрээнд Монголын Хүүхдийн эрхийн Үндэсний төв болон Сургуулийн нийгмийн ажилтны нийгэмлэгтэй хамтран Сургуулийн орчин дахь хүүхдийн эрхийн зөрчил, хүчирхийллийг бууруулах зорилгоор гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээт ажлын хүрээнд “Сургуулийн орчин дахь хүүхэд хамгаалал” сэдэвт сургалтын хөтөлбөр боловсруулан гаргах, гаргасан сургалтын хөтөлбөр дээр тулгуурлан нийслэлийн 9 дүүргийн 106 сургуулийн сургуулийн удирдлага, нийгмийн ажилтан, багш нарт зориулсан сургалт семинар зохион байгуулах, сургалт семинарын үр дүнд гарсан санал хүсэлтийг авч дахин боловсруулалт хийсний үндсэн дээр “Сургуулийн орчин дахь хүүхэд хамгаалал”-ын асуудал сэдэвт гарын авлага материал хэвлүүлж бүх сургуульд тараах зэрэг үйл ажиллагаа явуулах юм.

Нийслэлийн хүүхэд залуучуудын газар, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Хүүхдийг хүчирхийллээс хамгаалах төвтэй хамтран Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх Үндэсний хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын 1.3 дахь үр дүнд хүрэх загвар үйл ажиллагааг нийслэл Улаанбаатарт туршин нэвтрүүлэх зорилгоор гэрээ байгуулан ажиллав. Энэ ажлын хүрээнд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон үндэсний хөтөлбөр, нийслэлийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор хамтарсан багийн үйл ажиллагааны жишиг загварыг зарим дүүрэг дээр бий

болгон, цааш түгээн дэлгэрүүлэх, гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн мэдээллийг утсаар авч, хамтарсан багуудад холбон зуучлах ажлыг зохион байгуулж хэвших, хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжих, албан ёсны болгох талаар ажлын байрны тодорхойлолт, бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд тусгаж, урамшууллын болон хариуцлагын тогтолцоог бий болгох зорилготой зарим үйл ажиллагааг жишиг болгон хэрэгжүүлэх зэрэг үйл ажиллагаануудыг явуулсан байна.

Монголын Залуучуудын холбоотой байгуулсан гэрээний дагуу “Эврика” багш, оюутны эрдэм шинжилгээний бага хурлын нийгмийн салбар хуралдааныг зохион байгуулав. Энэхүү эрдэм шинжилгээний бага хурал нь нийгмийн чиглэлээр суралцаж буй их, дээд сургууль, коллежийн багш, оюутнуудын хийж буй эрдэм шинжилгээ, судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх, тэдний бүтээлийг олон нийтэд сурталчилан таниулах, цаашид судалгааны ажлаа улам гүнзгийрүүлэн практикт туршин биеллээ олоход нь дэмжлэг үзүүлэх ач холбогдолтой болсон бөгөөд нийгмийн салбар хуралдаанаар багш, оюутны эрдэм шинжилгээний бүтээлийг шинжлэх ухааны үндэслэлтэй эсэх, нийгмийн тулгамдаж байгаа асуудалтай холбогдсон байдал, шинэлэг санаа дэвшүүлсэн, практик ач холбогдолтой, санаагаа товч тодорхой зөв дэвшүүлсэн зэрэг шалгуураар шүүн хэлэлцэж шалгаруулав.

Монголын Ахмадын холбоотой 2008 онд хамтрах ажиллах гэрээ байгуулав. Гэрээний дагуу МАХ нь ахмад настны онцлогт тохирсон үйлчилгээ, арга хэмжээ зохион байгуулах, холбогдох хууль эрх зүйн актын талаар мэдээлэх, сурталчлах, эрүүл аж төрөх болон бусад шаардлагатай мэдээллийн талаар гарын авлага ном материал боловсруулах, түгээх чиглэлээр үйл ажиллагаа явуулах бөгөөд энэхүү арга хэмжээнд зориулан 7 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэв.

ГУРАВ. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ МАНЛАЙЛАЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ БОЛОН ТЭДГЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ЗОХИЦУУЛАХ ТАЛААР АВСАН АРГА ХЭМЖЭЭ, ҮР ДҮН

3.1. Төрийн удирдлагын манлайллыг хангах, үр дүнг дээшлүүлэх талаар:

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр /2005-2008/, эдийн засаг, нийгмийг 2008 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх, хууль тогтоомж, УИХ, Засгийн газрын тогтоол, шийдвэрээр өгөгдсөн үүрэг, даалгавар, яамны төлөвлөгөөт ажлыг хугацаанд нь чанартай ханган биелүүлэхэд газар, хэлтсийн ажлыг нэгдсэн удирдамжаар хангах, ажилтны мэдлэг, боловсрол, мэргэжлийн ур чадвар, бүтээлч, санаачилга, хариуцлагыг дээшлүүлэхэд анхаарч, дэмжлэг, туслалцаа үзүүлж ажиллав.

Яамны аппаратын 2007 оны тайлангийн хурлыг зохион байгуулан Төрийн нарийн бичгийн даргын мэдээллийг сонсож, өнгөрсөн оны хийсэн ажлаа дүгнэн, шинэ оны зорилтоо тодорхойлон бусад газар, хэлтсийн ажилтнуудад 2008 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн гэрээг боловсруулах талаар заавар зөвлөмж өгч ажилласнаар Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтын тухай хуулийн дагуу 2008 онд Ерөнхий менежерийн Төсвийн ерөнхийлөн захирагчтай, нэгжийн менежерүүдийн Ерөнхий менежертэй, төрийн албан хаагчийн нэгжийн

менежерүүдтэй үр дүнгийн гэрээ байгуулах ажлыг 2008 оны эхний улиралд багтаан зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.

Яамнаас сар бүр хийсэн ажлын тайланг газар, хэлтсүүдээс авч нэгтгэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт албан бичгээр болон и-мэйлээр хүргүүлж ажиллав. Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг Сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн даргаас зохион байгуулсан газар, хэлтсийн дарга нарын шуурхай болон нийт ажилтнуудад мэдээллийн цагаар танилцуулж, үүрэг даалгавар өгч байв. Яамны 2008 оны үйл ажиллагааны хагас, бүтэн жилийн тайланг гаргах, яамны үйл ажиллагааны төлөвлөгөө, Ерөнхий менежерийн гэрээний биелэлтийг гаргаж, Мэдээлэл, судалгаа, үнэлгээний газар үнэлгээ хийв.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын өдрийг тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулав. Уг ажлын хүрээнд салбарын удирдах ажилтнуудын зөвлөгөөнийг 2008 оны 2 дугаар сарын 28-нд зохион байгуулж, 2007 онд хийж амжуулсан ажлаа тайлагнаж, алдаа оноондоо дүгнэлт хийж, 2008 онд тавьсан зорилтын талаар хэлэлцлээ. Түүнчлэн Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын орон нутгийн хэлтсүүдийн дарга нарын сургалт, семинарыг зохион байгуулж, “Нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн талаар төрөөс баримталж буй бодлого, чиг хандлага”, “Хөдөлмөр нийгмийн хамгааллын бодлого шийдвэрийн хэрэгжилт, тулгарч буй зарим асуудал” зэрэг сэдвээр товч мэдээлэл хийж, хэлэлцүүлсэн нь үр дүнтэй арга хэмжээ боллоо.

Салбарын өдрийг тэмдэглэх арга хэмжээний хүрээнд “Эрүүл агаар эм” сэдэвт спорт, өдөрлөгийг Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын ажилтнуудыг хамруулан зохион байгуулж, яамны хамт олон багийн дүнгээр 1 дүгээр байр эзэлж, шилжин явах цом өргөмжлөл авсан байна.

3.2. Сайдын зөвлөл, Засгийн газрын хуралдааны дэг баримтлах, танхимын үйл ажиллагааг дэмжих талаар явуулсан үйл ажиллагаа, түүний үр дүн:

Засгийн газрын хуралдаанаар 2008 онд нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын чиглэлээр боловсруулж, Засгийн газар, УИХ-аар шийдвэрлүүлэх асуудлын талаар санал боловсруулж, Ерөнхий сайдын баталсан ерөнхий төлөвлөгөөнд тусгуулав. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөнд сар бүр тодотгол хийж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласнаар тайлант хугацаанд нийт 37 асуудлыг хэлэлцүүлж, төлөвлөгөөний биелэлт 92,5 хувьтай байна.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын зөвлөлийн хуралдаанаар 33 асуудал хэлэлцэхээр төлөвлөснөөс, хуралдааныг 6 удаа зохион байгуулж төлөвлөгөөт 21 асуудлыг хэлэлцэн холбогдох шийдвэрийг гаргасан байна. Ажлын шугамаар 7 асуудлыг хэлэлцэн Засгийн газарт хүргүүлэв. Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих Үндэсний хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах ажил удаашралтайгаас тасарч, төлөвлөгөөний биелэлт 84,8 хувийн биелэлттэй байна.

3.3. Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, шийдвэр, Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт, үр дүн:

Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг

зохион байгуулах, үр дүн биелэлтийг дүгнэх, мэдээлэх журам”-ын дагуу Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд гарсан хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн талаарх мэдээг яамны газар, хэлтэс, харьяа агентлаг, байгууллагаас улирал бүр гаргуулан авч нэгтгэн Засгийн газрын 2006 оны 51 дугаар тогтоолд заасан журмын дагуу хяналт-шинжилгээ хийн дүгнэж, дүн мэдээг ЗГХЭГ-т хүргүүлж ажиллав. Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн захирамж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл зэрэг 82 шийдвэрийн 134 заалтыг хяналтад авснаас аюулийн эцсийн өссөн дүнгээр нийт заалтын 125 буюу 93,2 хувь нь бүрэн буюу 100 хувь биелсэн, 9 буюу 6,71 хувь нь хэрэгжих шатандаа, 97,0 хувийн хэрэгжилттэй байна. Үүнээс хууль тогтоомжийн биелэлт 100,0 хувь, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт 96,7 хувьтай байна.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдаас 142, Төрийн нарийн бичгийн даргаас 132 тушаал батлан гаргасныг тус бүрд нь бүртгэл хөтлөн дугаар өгч ажиллав. Хэвлэмэл хуудсыг тусгай дугаарлагчаар дугаарлан бүртгэлийн дагуу олгож, ашиглалтанд хяналт тавьж ажиллав. НХХ-ийн сайдын тушаалыг ангилж үзвэл: журам, дүрэм, аргачлал, тариф баталсан, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн зохицуулалттай холбоотой 23 хууль, гэрээ хэлэлцээрийн төсөл боловсруулах болон төсөл, хөтөлбөрийг зохицуулах ажлын хэсэг, зөвлөл, комисс, үнэлгээний хороо байгуулах тухай буюу багаар ажиллахыг зохицуулсан 25; гадаад сургалт, семинар, танилцах аялалд оролцох, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэхтэй холбоотой 15; шагнаж, урамшуулах, зэрэг дэв зэрэг олгох, ой тэмдэглэх зэрэг үйл ажиллагааны зохицуулалттай холбоотой 32; ажилд томилох, чөлөөлөхтэй холбоотой 17; тусгай зөвшөөрөл олгох, сунгах, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөхтэй холбоотой 23; хөрөнгө мөнгөний зохицуулалттай холбоотой 7 тушаал гарсан байна.

Төрийн нарийн бичгийн даргын тушаалыг ангилж үзвэл: дагаж мөрдөх журам 1, хууль, гэрээ хэлэлцээрийн төсөл боловсруулах болон төсөл, хөтөлбөрийг зохицуулах ажлын хэсэг, зөвлөл, комисс, үнэлгээний хороо байгуулах тухай буюу багаар ажиллахыг зохицуулсан 17; гадаад сургалт, семинар, танилцах аялалд оролцохтой холбоотой 33; цалин шинэчлэн тогтоох, мөнгөн урамшил олгох, түр чөлөө олгох, баяр тэмдэглэн өнгөрүүлэх зэрэг үйл ажиллагааны зохицуулалттай холбоотой 35; ажилд томилох, чөлөөлөхтэй холбоотой 18; буцалтгүй тусламж олгох, хөрөнгө мөнгөний зохицуулалттай холбоотой 28 тушаал гарсан байна.

Авлигын эсрэг хууль, УИХ-ын 2007 оны 9 дүгээр тогтоолоор баталсан “Албан тушаалтны хөрөнгө, оруулгын мэдүүлгийг бүртгэх, хадгалах журам”-ыг хэрэгжүүлэх зорилгоор Авилгалтай тэмцэх газрын хяналт шалгалт, дүн шинжилгээний ажилтнаар яамны төрийн албан хаагчдад зориулж мэдээлэл хийлгэж, шинээр батлагдсан хууль тогтоомжийг танилцуулж, Хөрөнгө орлогын мэдүүлгийг хэрхэн гаргах болон анхаарах асуудлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөв. Түүнчлэн АТГ-аас ирүүлсэн зөвлөмжийг ажилтнуудад танилцуулж, хууль тогтоомжийн дагуу яамны төрийн захиргааны байнга болон түр томилогдсон албан тушаалтнуудаас 2007 оны Хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулах ажлыг зохион байгуулав.

Авлигын эсрэг хуулийн 4.1.1, 10.4, 11.2 дахь заалтын дагуу Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны байнгын болон түр томилогдсон төрийн захиргааны болон улс төрийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг 2007 оны байдлаар гаргуулан авч, ХОМ-1, ХОМ-2, ХОМ-3, ХОМ-4 маягтын дагуу тайланг нэгтгэн хуульд

заасан хугацаанд Авлигатай тэмцэх газарт хүргүүлэв. 2007 оны ХОМ-ийг тус яаманд нийт 50 албан тушаалтан гаргаж өгөхөөс Сайд, дэд сайд нар АТГ-т, Төрийн нарийн бичгийн дарга ТАЗ-д, 47 албан хаагч эрх бүхий албан тушаалтанд гаргаж өгсөн байна. 47 албан хаагчийн албан тушаалын ангилал зэрэглэлийг авч үзвэл, ТЗ-12-той 4, ТЗ-11-тэй 4, ТЗ-10-тай 2, ТЗ-8-тай 8, ТЗ-7-той 24, ТЗ-6-тай 2, ТЗ-5-тай 1, УТ-2 байв. Түүнчлэн 2008 онд шинээр ажилд орсон болон түр томилогдсон 6 албан хаагчийн 2007 оны Хөрөнгө орлогын мэдүүлгийг нөхөн гаргуулж, улирлын тайланд тусган АТТ-т хүргүүлэв. “Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны улирлын мэдээ”-г ХОМ-5 маягтын дагуу улирал бүр гаргаж, Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх ажлын зохион байгуулав.

Монгол Улсын Авилгатай тэмцэх газраас томилогдсон ажлын хэсэг 2008 оны 4 дүгээр сард тус яамны албан албан тушаалтнуудын 2007, 2008 онд мэдүүлсэн хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргасан байдал, албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа нь Авлигын эсрэг хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд хяналт тавьж, шалгалт хийсэн билээ. Уг шалгалтаар яамны хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэж, хадгалах эрх бүхий албан тушаалтан нь мэдүүлэг гаргах албан тушаалтнуудыг бүрэн хамруулсан, тайлан мэдээ, судалгааг батлагдсан маягтын дагуу цаг хугацаанд нь, нууцлалын шаардлагыг бүрэн хангаж ажилласан гэж дүгнэсэн байна.

Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Ерөнхий сайдаас өгсөн үүргийн хэрэгжилтийг хангах зорилгоор Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө /2008-2009/ боловсруулах ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2008 оны 43 дугаар тушаалаар байгуулан ажиллаж, Авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулж, батлуулав. Ажлын хэсгийн хуралдааныг 3 удаа зохион байгуулж, яам, агентлагийн түвшинд авлига, хүнд суртал үүсэх эрсдлийг бууруулах чиглэлээр яамны албан хаагчид болон үйлчлүүлэгчдээс санал асуулга авч, дүгнэлт хийв. Төлөвлөгөө боловсруулах явц, санал асуулгын дүнгийн талаар АТГ-аас зохион байгуулсан семинарын үеэр мэдээлэл хийлээ.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын хэмжээнд авилга үүсэж болзошгүй дүрэм журам, нөхцөл байдлыг судлан тогтоох, хуульд нийцэхгүй байгаа, ач холбогдлоо алдсан тушаалыг хүчингүй болгох, нэмэлт өөрчлөлт оруулах, эсхүл шинэчлэн батлуулах, нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрүүдийг хянах, цэгцлэх ажлыг 2008 оны эхний хагас жилд багтаан зохион байгуулав. Салбарын хэмжээнд улсын нэгдсэн санд бүртгэлтэй бөгөөд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 18 тушаалыг Захиргааны шийдвэрийг стандартчилах төслийн газарт хүргүүлж, “legalinfo”-д байршуулав. ХЗДХЯ-наас хүчингүй болгох шаардлагатай жагсаалтаар ирүүлсэн шийдвэрүүдээс 1992 оноос 2005 он хүртэл тус яам дангаараа баталсан 5 тушаалыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2008 оны 13 дугаар тушаалаар хүчингүй болгох арга хэмжээ авав. Холбогдох яамдтай хамтран баталсан 8 тушаалыг хүчингүй болгох санал боловсруулж, хүргүүлснээс бүгдийг хүчингүй болгов.

Улсын Их Хурал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яам, бусад газруудаас боловсруулж ирүүлсэн хуулийн төсөл 133, УИХ-ын тогтоолын төсөл 21, Засгийн газрын тогтоолын төсөл 290, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл 27, Ерөнхий сайдын захирамжийн төсөл 1, ТӨХ-ны болон бусад сайдын тушаалын төсөл 19, нийтдээ 491 шийдвэрийн төсөлд санал боловсруулан холбогдох газруудад хүргүүлж ажилласны зэрэгцээ яамнаас боловсруулан УИХ, Засгийн газрын

хуралдаанд оруулах материал, тушаал, шийдвэрийн төсөлд санал дүгнэлт өгч, мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллав.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, тайлан мэдээг хагас жилээр гаргаж ГХУСЗөвлөлд хүргүүлсэн болно. Авлигатай тэмцэх болон Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, тайлан мэдээг хариуцсан мэргэжилтнүүдтэй хамтран гаргаж холбогдох газруудад хүргүүлэв.

3.2. Хүний нөөцийн хөгжил, чадавхийг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах талаар гарсан үр дүн:

Төрийн албаны салбар зөвлөлийн хуралдааныг улиралд 1-2 удаа зохион байгуулж, төрийн албан хаагчийг ажилд сонгон шалгаруулж авах, зэрэг дэв олгох, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах болон төрийн албан хаагчтай холбогдсон маргаан гомдол, санал хүсэлтийг хэлэлцэж, холбогдох шийдвэрүүдийг гаргаж ажиллав. Тухайлбал,

Төрийн албаны тухай хууль, “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”, Төрийн албан хаагчдын ажлын үр дүнг харгалзан 2 ажилтныг албан тушаал дэвшүүлэн ахлах мэргэжилтнээр томилж, 2 ажилтны зэрэг дэвийг ахиулж, 11 ажилтанд шинээр зэрэг дэв олгож, зэрэг дэвийн нэмэгдлийг нь тооцон олгуулахаар шийдвэрлэв.

Ажлын хэрэгцээ шаардлагыг үндэслэн ажлын сул байр, албан тушаалыг нөхөх захиалгыг боловсруулав. Тухайлбал, 2008 онд тус яамны Жендер, гэр бүлийн хөгжлийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн, хэвлэл мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтэн, веб хуудас, компьютер техник хэрэгсэл хариуцсан мэргэжилтэн, бүртгэл санхүүгийн асуудал хариуцсан туслах мэргэжилтний ажлын байранд тавигдах шаардлагыг олон нийтэд зарлахаар Төрийн албаны зөвлөлд захиалга хүргүүлсний зэрэгцээ тус яаманд өүр томилогдон ажиллаж байсан 5 хүнийг шалгалтад хамруулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав. Өинэ ажилтан авах, ажлын хэрэгцээ, дадлага туршлагыг үндэслэн хүний нөөцийг зохистой байршуулах талаар тухай бүр НХХ-ийн сайд, Төрийн нарийн бичгийн даргын 06080808 шийдвэрёүэ ажиллав. Төрийн албаны тухай хуулийн Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх, төрийн жинхэнэ албан тушаалд авах тухай 17 дугаар зүйл, Төрийн жинхэнэ албан хаагч төрийн албанаас чөлөөлөгдөх тухай 24 дүгээр зүйлийн холбогдох заалтуудыг үндэслэн 2008 онд ажилд томилох, чөлөөлөхтэй холбоотой 35 шийдвэр гаргасан байна.

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 6 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2008 оны 62 дугаар тогтоол, санал дүгнэлт, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2008 оны 18 тоот албан бичгээр ирүүлсэн санал зэргийг үндэслэн Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын даргаар Ч.Алтанхуягийг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2008 оны 99 дүгээр тушаалаар томилов. Түүнчлэн Нийгмийн даатгалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх заалт болон Засгийн газрын 1994 оны 171 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийгмийн даатгалын байгууллага, байцаагчийн дүрэм”-ийн 2.12 дахь заалтыг үндэслэн УНДЕГ-ын даргад нийгмийн даатгалын улсын ерөнхий байцаагчийн эрх олгов.

Салбарын хэмжээнд төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний 2007 оны тайланг зохих маягт, заавар, журмын дагуу гаргаж, Төрийн албаны зөвлөлийн сүлжээнд оруулав. Яамны төрийн албан хаагчдын 2007 оны бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг гаргаж, 10 хүнийг шинээр сүлжээнд оруулж, 39 хүний хуучин мэдээллийг шинэчлэв. 2008 онд тус яам 55, УНДЕГ 69, ХХҮГ 54, СЗҮТ 57 орон тоотой ажилласан байна. МӨСҮТөв яамны дэргэдэх төв болон зохион байгуулагдаж, 105 орон тоотой үйл ажиллагаа явуулж байна.

Удирдлагын академийн Төрийн удирлагын сургуулийн 2008-2009 оны богино болон урт хугацааны сургалтад яамны 3 албан хаагчийг хамруулах захиалга, саналыг материалын хамт хүргүүлэв.

Дайчилгааны улсын нэгдсэн төлөвлөгөө тодотгоход шаардлагатай нийгмийн халамжийн хуулийн дагуу олгогддог бүх төрлийн тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн даатгалын сангийн шимтгэл, хураамжийн орлого, зарлагын гүйцэтгэлийг 2007 оны эцсийн байдлаар гаргаж, Батлан хамаалах яаманд хүргүүлэв. Яамны дэргэд онцгой байдлын болон гамшгаас хамгаалах орон тооны бус штабыг Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулав.

Салбарын шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах дүрмийн төслийг боловсруулж, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2008 оны 53 дугаар тушаалаар батлав.

Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах талаар:

Яамны аппаратын 2007 оны тайлангийн хурлаас гарсан саналыг хэрэгжүүлэх зорилгоор ажилтнуудыг Хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлийн өвчин судлалын үндэсний төвтэй гэрээ байгуулсаны үндсэн дээр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, оношлогоо, шинжилгээг хийлгүүлэв. Түүнчлэн албан ажлын өрөөний утасны лимитыг 5,0-10,0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх арга хэмжээ авч авч.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны албан ажлын өрөө, тасалгааны багтаамж хүрэлцээгүй, сургалт, нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах заал, танхим, байрны боломжгүйгээс конторын барилгыг сунган өргөтгөл хийхээр кадастрын зураг төсөвт шаардагдах төсвийг 2007 оны төсвийн тодотголоор, барилгын өргөтгөлд шаардагдах төсвийг 2008 оны төсөвт тусгасантай холбогдуулан конторын барилгын өргөтгөл хийх газрын зөвшөөрөл олгох асуудлыг шийдвэрлүүлэхээр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид хүсэлт тавиад байна.

“Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 351 дүгээр тогтоолын дагуу яамны төрийн албан хаагчдын албан тушаалын сарын цалин, нэмэгдлийн хэмжээг Төрийн нарийн бичгийн даргын 2008 оны 2 дугаар тушаалаар шинэчлэн тогтоож, 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдүүлэв.

Яамны аппаратын албан хаагчдын ар гэрийн гачигдалтай байдал, тавьсан хүсэлтийг харгалзан 12 ажилтанд ажлын чөлөө олгож, Хөдөлмөрийн дотоод журмын дагуу төрийн албан хаагч өвчний улмаас удаан хугацаагаар эмчлүүлсэн, ар гэрт нь гачигдал тохиолдсон 9 ажилтанд 1.3 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлсэн байна.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд тус яамнаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудыг 2 удаа хүлээн авч, хүндэтгэл үзүүлж, гарын бэлэг өгсөн. 2008 онд амьдралын гачигдалтай байдлыг харгалзан 10 ахмадад 990.0 мянган төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлэх арга хэмжээ авав.

Газар, хэлтсийн удирдлага, ажилтнуудын саналыг авсны үндсэн дээр аппаратын ажилтнуудын 2008 оны ээлжийн амралтын хуваарийг гаргаж, Төрийн нарийн бичгийн даргын 2008 оны 49 дүгээр тушаалаар баталж, ээлжийн амралтыг биеэр эдлүүлэхэд анхаарч ажиллав.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны шагналын журмыг шинэчлэн боловсруулж, НХХ-ийн сайдын 2008 оны 122 дугаар тушаалаар батлав. Шинэ журмаар шагналын материалыг сайдын зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлж байх, “Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн тэргүүний ажилтан” цол, тэмдгээр 15-аас доошгүй жил ажилласан байх, баяр ёслол болон улс төрийн арга хэмжээний үеэр хавтгайруулан олгохгүй байх зэрэг заалтуудыг шинээр тусгав.

Төрийн одон медальд шагнуулахаар салбарын болон бусад байгууллагаас ирүүлсэн 36 хүний тодорхойлолт холбогдох материалыг судалж, дүгнэлт гаргав. Төрийн одон, медалиар шагнуулахаар өргөн мэдүүлсэн хүмүүсээс 2008 онд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтэн Х.Чулуунцэцэг “Алтангадас” нар одонгоор, Хөдөлмөрийн бодлого, зохицуулалтын газрын дарга Т.Энхтуяа, Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн Б.Алтанцэцэг, операторч Б.Оюунбилэг, Сэргээн засалтын үндэсний төвийн сургалтын албаны дарга Л.Даваасүрэн нар “Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар, Хөдөлмөрийн бодлого зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн Ц.Батнасан Засгийн газрын хүндэт өргөмжлөлөөр тус тус шагнагдсан байна.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын ажилтны өдөр болон бусад төрийн болон төрийн бус байгууллагын ой, тэмдэглэлт өдрийг тохиолдуулан нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт үр бүтээлтэй ажиллаж хөдөлмөрийн амжилт гаргасан 107 хүнийг “Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн тэргүүний ажилтан” цол, тэмдгээр, 58 хүнийг яамны “Хүндэт жуух” бичгээр шагнаж урамшуулах асуудлыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын тушаалаар шийдвэрлэв.

Цаг хугацааны нөөц ашиглалт, гадаад дотоод томилолтын талаар:

Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрийг сурталчлах, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын хэмжээнд шинээр гарсан хууль тогтоомж, журам дүрмийг таниулах, иргэд хөдөлмөрчдийн санал бодлыг судлах, тэдэнд тайлбар, хариулт өгөх, салбарын байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ үнэлгээ хийх ажлаар хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан ажилтнууд орон нутагт ажиллаж, сумдын ажил байдалтай танилцан, иргэд хөдөлмөрчидтэй уулзаж, төрөөс явуулж буй хөдөлмөр, нийгмийн халамж, даатгал, тэтгэвэр, тэтгэмжийн нэмэгдэл, болон холбогдох хууль тогтоомжийн шинэчлэлттэй холбогдсон асуултад хариулт өгч, салбарын хуулиудыг сурталчлан, заавар зөвлөгөө өгч ажиллав.

Тайлант хугацаанд нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын чиглэлээй хууль тогтоомжийг сурталчлах, бодлогын удирдамжаар хангах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор давхардсан тоогоор 44 ажилтан 16 аймагт 163 хоног албан томилолтоор ажилласан байна.

“Нийгмийн хамгаалал, салбарын хөгжлийн хөтөлбөр” төслийн 2008 оны төлөвлөгөө, олон улсын байгууллагын урилга, яамны зардлаар давхардсан тоогоор 55 ажилтан Швейцари, ХБНГУ, БНСУ, Япон, Тайланд, БНХАУ зэрэг 19 оронд 3-45 хоногийн хурал, зөвлөгөөн, сургалт семинар, танилцах аялалд 40 удаа оролцож, мэдлэг чадвар, ажлын туршлагаа дээшлүүлсний зэрэгцээ өөрсдийн хамрагдсан сургалт семинар, танилцсан туршлагын талаар “Мэдээллийн цаг”-аар нийт ажилтнуудад танилцуулж, мэдээлэл хийж хэвшив.

ДӨРӨВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ, ҮР ДҮНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ, МЭДЭЭЛЛИЙГ ТАЙЛАГНАХ ЧИГЛЭЛЭЭР АВСАН АРГА ХЭМЖЭЭ, ҮР ДҮН

4.1. Бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх зорилтын хүрээнд:

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар, Сэргээн засалтын үндэсний төвийн 2007 оны үйл ажиллагааны үр дүн, сайдтай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийн үнэлгээ өгч, дүнг НХХ-ийн сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэв. Хуралдаанаас агентлагуудын 2007 оны үйл ажиллагааг “ХАНГАЛТТАЙ” гэж үнэлсэн бөгөөд СЗҮТөв 94.3 хувь буюу 4.7 оноо, ХХҮГазар 94.3 хувь буюу 4.7 оноо, УНДЕГазар 88.1 хувь буюу 4.4 онооны биелэлттэй гарлаа. Агентлаг, харьяа байгууллагуудад холбогдох үүрэг даалгавар, зөвлөмжийг өгөв

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын Төсвийн ерөнхийлөн захирагчийн НХХЯ-ны Ерөнхий менежер Төрийн нарийн бичгийн даргатай 2007 онд байгуулсан Үр дүнгийн гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, хийн үнэлгээ өгч 2008 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн СЗХ-аар хэлэлцүүлэн биелэлтийг 90.0 хувь буюу “Маш сайн” гэж үнэлэв.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын Төсвийн ерөнхийлөн захирагчаас Төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэхээр 2007 онд зарим ТББ-уудтай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээний биелэлтэд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2006 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 75 дугаар тушаалаар батлагдсан журмыг баримтлан хяналт-шинжилгээ хийж үнэлгээ өглөө. Тухайлбал, Монголын ахмадын холбоо 94 хувийн биелэлттэй (4.7 оноо), Монголын Чөлөөт ахмадын холбоо 90 хувийн биелэлттэй (4.5 оноо), Хэрэглэгчдийн Эрх Ашгийг Хамгаалах Нийгэмлэг 88 хувийн биелэлттэй (4.4 оноо), Хүчирхийлэлийн эсрэг үндэсний төв 97.5 хувийн биелэлттэй (4.8 оноо), Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрхийн үндэсний төв 76.6 хувийн биелэлттэй (3.8 оноо), Эх дэлхий эмэгтэйчүүд хөдөлгөөн 95 хувийн биелэлттэй (4.7 оноо), Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо 85 хувийн биелэлттэй (4.3 оноо), Монголын өрх толгойлсон

эмэгтэйчүүдийн “Заюу тайж” нийгэмлэг 5 хувийн биелэлттэй 0.25 оноотой байв. Монголын Эрэгтэйчүүдийн холбооны үйл ажиллагааг үнэлэх боломжгүй гэж үзэв.

Төсвийн ерөнхийлөн захирагчтай Монголын ахмадын холбоо, Монголын чөлөөт ахмадын холбоо, Хэрэглэгчдийн Эрх Ашгийг Хамгаалах Нийгэмлэг, Хүчирхийлэлийн эсрэг үндэсний төв, Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрхийн үндэсний төв, Эх дэлхий эмэгтэйчүүд хөдөлгөөн, Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооны ерөнхий менежерийн 2007 онд байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээг хангалттай, Монголын өрх толгойлсон эмэгтэйчүүдийн “Заюу тайж” нийгэмлэг, Монголын Эрэгтэйчүүдийн холбооны ерөнхий менежерийн 2007 онд байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээг хангалтгүй гэж тус тус дүгнэв.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын Төсвийн ерөнхийлөн захирагч 2007 онд өөрийн эрхлэх ажлын хүрээнд 21 аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн нийтлэг гэрээнд 5 ангийн 29-31 бүтээгдэхүүн тусгагджээ. Эдгээр гэрээний биелэлтэд Засгийн газрын 2006 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан “Яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх” журмын дагуу хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өглөө. Төсвийн ерөнхийлөн захирагчтай 2007 онд байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээгээ 19 аймгийн Засаг дарга 90 хувиас дээш хувиар биелүүлж (4,540-4,884 оноо), 3 аймгийн Засаг дарга 86.8-89,4 хувиар (4.346-4,468 оноо) биелүүлжүү. Ийнхүү Нийгмийн хамгаалал, хөдөлмөр, хүн амын хөгжлийн асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчтай 2007 онд байгуулсан үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ бүх аймаг, нийслэлийн Засаг дарга нар зохих түвшинд амжилттай биелүүлсэн байна. Төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2007 онд байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн холбогдох зөвлөмжийг хүргүүлэв.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд Засгийн газрын 2006 оны 3 дугаар сарын 22-ний өдрийн 51 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхэлсэн ажлын хүрээнд шууд хамаарах нийт 28 зорилтын хэрэгжилтийн явц дунджаар 3 дугаар улирлын байдлаар 94 хувийн биелэлттэй, (4.7 оноотой) байв. Хөтөлбөрийн хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар гаргаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхээр бэлтгээд байна. Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд хүн амын хөгжил, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний санал боловсруулж, тусгуулав.

Монгол Өлсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлд хэрэгжүүлэхээр тусгагдсан 20 арга хэмжээний биелэлтийг гаргаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. 2008 оны III улирлын байдлаар эдгээр арга хэмжээний биелэлт 81.0 хувьтай байна. Үүнээс 100 хувийн биелэлттэй 10, 90 хувийн биелэлттэй 1, 70 хувийн биелэлттэй 5, 50 хувийн биелэлттэй 3, 30 хувийн биелэлттэй 1 арга хэмжээ байв. Үндсэн чиглэлийн биелэлтийг жилийн эцсийн байдлаар гаргаж, Сангийн яаманд хүргүүлэв.

Австрали Улсын “Чадавхи бэхжүүлэх, жижиг үйл ажиллагааг дэмжих” төслийн хүрээнд НХХЯ-ны гүйцэтгэлийн хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чадавхийг бэхжүүлэх

үйл ажиллагааны 2 дахь үе шатны сургалт 2008 оны 2 дугаар сарын 25-наас 3 дугаар сарын 7-ны хооронд хийгдлээ. Тус төслийн хүрээнд ажилласан Олон улсын зөвлөх нь НХХЯ-ны МСҮГ-ын ажилтнуудын хийсэн ХШҮ-ний үр дүнд дүн шинжилгээ хийж, 20 ажилтанд зориулсан сургалт зохион байгуулж, дүн шинжилгээнд үндэслэн МСҮГ-ын ажилтнуудын ХШҮ-ний чадавхийг бэхжүүлэх хэтийн хэрэгцээг тооцоолж холбогдох зөвлөмжүүдийг гаргалаа. Түүнчлэн төслийн хүрээнд Австрали улсын нийслэл Канбера, Өмнөд Австралийн муж улсын нийслэл Аделейд хотод хийсэн танилцах аялалд НХХЯ-ны МСҮГ-ын дарга Н.Аюуш, тус газрын мэргэжилтэн С.Наранцацрал, С.Орхон, ХАХНХБЗГ-ын мэргэжилтэн Ю.Отгонбилэг нар оролцлоо. Танилцах аялалын хүрээнд тус хотуудын нийгмийн хамгааллын тогтолцоо, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж туршлага судалсан байна.

Иргэдийн өргөдөл, гомдол, санал хүсэлт шийдвэрлэлтэд 2007 оны сүүлийн хагас жил, 2008 оны хагас, бүтэн жилийн байдлаар хяналт, шинжилгээ хийж, үнэлгээ өглөө. Тухайлбал, НХХЯ-нд 2008 оны 01 дүгээр сарын 02-ноос 2008 оны 06 дугаар сарын 30-ны хооронд иргэдээс нийт 464 өргөдөл хүлээн авсан байна. Яаманд ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийн 98.4 хувьд хариултыг бүрэн өгсөн, 6 өргөдлийн хариу болон шийдвэрлэлт 70 хувьтай, 1 өргөдлийн шийдвэрлэлт 50 хувьтай, 1 өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэгдэх хугацаа нь болоогүй шийдвэрлэгдэх шатандаа, дунджаар 99.5 хувийн биелэлттэй, (4.9 оноотой) байв.

2008 оны сүүлийн хагас жилд хүлээн авсан өргөдөл, гомдлыг урьдчилсан байдлаар гаргавал нийт 274 өргөдөл ирсэн ба 99.2 хувьд хариултыг бүрэн өгсөн, 2 өргөдлийн хариу болон шийдвэрлэлт 70 хувьтай, дунджаар 99.7 хувийн биелэлттэй, 5 оноотой байна. 2008 онд гадаадад хөдөлмөр эрхлэхдээ хүссэн өргөдөл мөн оны эхний хагас жилийнхээс 4 дахин багасан, харин орон сууц болон гэр хүссэн өргөдлөөд өгүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газраас баталсан Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 2008 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр СЗХ-аар хэлэлцүүлэв. 2008 оны хувьд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 90.0 хувь, “Жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 100 хувь, Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 85 хувь, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах хөтөлбөр” 90.0 хувь, “ХБИ-ийг дэмжих үндэсний хөтөлбөр” 100 хувь, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих үндэсний хөтөлбөр” 100 хувь, “Хүн худалдах ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах” Үндэсний хөтөлбөр 90 хувь, “Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих Үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилт 65,7 хувьтай байна. Хөтөлбөрүүдийн биелэлтийг ЗГХЭГ-аас Засгийн газрын хуралдаанд танилцуулж, холбогдох үүрэг даалгаврыг өгүүлсэн болно.

Сэлэнгэ, Дархан-Уул аймаг, Нийслэлийн Сонгинохайрхан, Хан-уул дүүргүүдэд ажиллаж, нийгмийн хамгаалал, хөдөлмөр, хүн амын хөгжлийн талаар явуулж буй бодлого, үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулав.

Хүн ам, хөгжлийн асуудлаарх бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд хяналт үнэлгээ хийх ажлыг Монгол Улс дахь НҮБХАСангийн Суурин төлөөлөгчийн газрын дэмжлэгтэйгээр НХХЯ-ны Мэдээлэл, судалгаа, үнэлгээний газар бусад

ажилтнуудын оролцоотойгоор хийж гүйцэтгэв. Тус хяналт шинжилгээний ажлын зорилго нь Хүн ам, хөгжлийн асуудал гэх мэт салбар дундын бодлогын хэрэгжилтийг зохицуулах болон үр дүнд суурилсан менежментийн чадавхийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршиж байв.

Хүүхдийн хөдөлмөрийн хяналт шинжилгээний шалгуур үзүүлэлтийг бий болгох чиглэлээр ажлын хэсэг байгуулан ажиллаж, хүүхдийн хөдөлмөрийн мониторингийн үзүүлэлтүүдийн хүрээг боловсруулав. Мөн уг үзүүлэлтүүдийг тооцоход ашиглах мэдээллийн эх сурвалжуудад дүн шинжилгээ хийж, шинэчлэх, боловсронгуй болгох хэрэгцээг тодорхойлов. Хүүхдийн хөдөлмөрийн хяналт шинжилгээний шалгуур үзүүлэлтүүдийн талаар санал авах болон уг үзүүлэлтүүдийг тооцоход ашиглах захиргааны мэдээллийн эх үүсвэрийг тодруулах зорилгоор яамдуудаас санал авч, нэгтгэв. Түүнчлэн хүн амын хөгжил, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс хэрэгжүүлж буй бодлогын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх явцдаа хүүхдийн хөдөлмөрийн талаар орон нутагт хийгдэж буй үйл ажиллагаатай танилцаж, зарим шинэ мэдээллийг цуглуулав. Хүүхдийн хөдөлмөрийн мониторингийн үзүүлэлтүүдийг боловсруулахдаа ОУХБ-ын АПЕИК хөтөлбөрөөс санхүүжилттэйгээр хэрэгжиж буй “Хүүхдийн хөдөлмөрийн мониторингийн чадавхийг бэхжүүлэх”, “Орон нутагт хүүхдийн хөдөлмөрийн мониторингийн үзүүлэлтийг боловсруулах” төслүүд, НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр Үндэсний статистикийн хорооны хэрэгжүүлж буй “Хүүхдийн хөгжил, хамгааллын үзүүлэлтүүдийг боловсруулах нь” төслүүдтэй хамтран ажиллав.

4.2. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын мэдээллийн сүлжээг хөгжүүлэх, сан бүрдүүлэх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах зорилтын хүрээнд:

“Эх орны хишиг сангийн тухай” хууль тогтоомжийг боловсруулах ажлын хэсгийг хариуцан ажиллаж, хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, 2008 онд Монгол Улсын иргэдэд хишиг хүртээх мөнгөний хэмжээг тогтоох тухай УИХ-ын тогтоолын төслийг боловсруулан холбогдох тооцоо, судалгааг гаргаж яамдын саналыг тусган Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлэж, уг хууль болон тогтоолын төслийг УИХ-д өргөн барьсан болно.

Улс төрийн намуудын УИХ-ын сонгуульд өрсөлдсөн мөрийн хөтөлбөр болон Шинэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан стратегийн болон томоохон орд газруудаас олох орлогоос иргэдэд хувь хүртээхтэй холбоотой асуудлыг боловсруулах, хувь хүртээх арга хэлбэрийн оновчтой хувилбарыг сонгох ажил хийгдэж байна. Энэ асуудлаар Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын тушаалаар байгуулсан ажлын хэсгийн нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэж санал, дүгнэлт боловсруулах ажлыг зохион байгуулж, ажлын явцын талаар Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн ээлжит бус хуралдаанд танилцуулав. Уг хуралдаанаас өгсөн үүргийн дагуу асуудлыг дахин боловсруулж, Засгийн газарт танилцуулахаар бэлтгэв.

Нийгмийн халамжийн сан болон Монгол Өлсыг хөгжүүлэх сангаас олгож буй мөнгөн тэтгэмжүүдийн өрхийн аж байдалд үзүүлж буй нөлөөг судлах зорилготойгоор санал асуулгын хуудас боловсруулж, 2008 оны 10 сарын 27-нд зохион байгуулсан НХХЯ-ны нээлттэй өдрөөр туршилтын журмаар 130-аад хүнээс судалгаа авав. Туршилтаар боловсруулсан санал асуулгын хуудсыг ашиглах боломжтой нь

нотлогдсон учир түүврийн хэмжээг тодорхойлж, хамруулах аймаг, дүүргийг сонгон санал асуулгыг авах зааврын хамт хүргүүлэв. Түүвэрт 7 аймаг, тэдгээрийн зарим сумд болон УБ хотын 2 дүүргийг хамруулахаар сонгосон бөгөөд сонгогдсон бүх аймаг, дүүрэг судалгаа авч дуусаад байна. Судалгаанд 1342 хүн хамрагдлаа. Санал асуулгын дүнг нэгтгэн, судалгааны эцсийн тайлан боловсруулж дуусаад байна.

Монгол Улсын “Бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох” ажлын хэсэгт ажиллаж “Монгол Олсад бүртгэлийн нэгдсэн тогтолцоо бий болгох Үндэсний хөтөлбөр”-ийн төслийг боловсруулах, төслийг хэлэлцэж зөвшилцөх үйл ажиллагаанд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг төлөөлөн оролцов. Энэхүү хөтөлбөр Засгийн газрын 2008 оны 78 дугаар тогтоолоор батлагдан хэрэгжиж эхлээд байна.

“Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны ил тод, нээлттэй байдлыг дэмжих нь” төслийн санал боловсруулж, НҮБХХ-т хүргүүлэв. Төслийн зорилго нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны аливаа шийдвэр гаргах болон бусад үйл ажиллагааг ил тод, хариуцлагатай байх зарчим, чадавхийг хөгжүүлж, иргэд мэдээлэл чөлөөтэй авч, санал өгөх дэд бүтцийг бий болгон, НХХЯ-ны үйл ажиллагаанд иргэд, хэрэглэгчдийн хяналт тавих боломжийг бүрдүүлэхэд чиглэнэ. Төслийн үйл ажиллагаа нь дөрвөн зорилтын хүрээнд хэрэгжиж, НХХЯ-ны үйл ажиллагаа, шийдвэр гаргах үйл явц, үзүүлэх төрийн үйлчилгээнд иргэд, хэрэглэгчдийн оролцоо, хяналт тавих боломж сайжирснаар “Төрийн захиргааны ил тод, нээлттэй загвар байгууллага” болох юм.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын 2007 оны үйл ажиллагааны үр дүн, шинээр гарсан болон шинэчлэгдсэн хууль, эрх зүйн актуудыг эмхэтгэн товхимол болгон бэлтгэж 500 хувь хэвлүүлэн яамны ажилтнууд, аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар, сумдын нийгмийн ажилтнуудад хүргүүлэв.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт 2000 оноос хойш гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж дууссан болон одоо хэрэгжиж буй нийт 9 төслийн үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг гаргаж ЗГХЭГ, Сангийн яаманд тус тус хүргүүлэв.

АХБ-ны “НХСХХ” төслийн хүрээнд нийгмийн хамгааллын салбарын удирдлагын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилтын хүрээнд нэгдсэн мэдээллийн сангийн бүтцийг тодорхойлох ажлын хэсгийг байгуулаад ажиллаж байна. Удирдлагын мэдээллийн тогтолцоо бүрдүүлэхтэй холбогдуулан салбарын мэдээллийн технологийн ажилтнуудын мэргэжлийн чадавхийг бэхжүүлэх чиглэлээр “Жава програмчлалын хэл ашиглан вэб хэрэгсэл хөгжүүлэх нь” сургалтыг БНЭУ-д зохион байгуулж, яам болон харъяа агентлагийн мэдээллийн технологийн асуудал хариуцсан 8 ажилтныг хамруулав. Систем администорын сургалтыг 2008 оны 12 дугаар сарын 15-аас зохион байгуулж эхлээд байна.

Яамны вэб хуудсанд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт шинээр батлагдсан хууль тогтоомж болон мэдээ, мэдээллийг цаг тухай бүрт нь шинэчлэн оруулав. Мөн вэб сайтыг зочны буланд ирүүлсэн санал, хүсэлтэнд тухай бүрт нь хариу өгч ажиллав.

Яамны компьютер техник хэрэгсэл болон компьютерийн дотоод сүлжээнд гарсан гэмтлийг тухай бүрт нь засаж, хэвийн ажиллагааг хангаж ажиллав. Ажилчдын

техник хэрэгслийг шинэчлэх ажлын хүрээнд шинээр 15 компьютер 11 принтерийг авч, нийлүүлжээ.

ТАВ. ТӨСӨВ, ХӨРӨНГИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГА, ҮР ДҮН:

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын 2008 оны төсөв нь Төрөөс нийгмийн хамгааллын талаар баримталж буй бодлого, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан нийгмийн салбарт тавигдсан зорилтыг хэрэгжүүлэх, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2008 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд чиглэгдсэн бөгөөд хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогыг хэрэгжүүлэх замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажлын байр бий болгох, ядуурал, ажилгүйдлийг бууруулах, хүн ам, нийгмийн хөгжлийн оновчтой бодлого хэрэгжүүлэх үндсэн дээр хүний хөгжил, хүн амын өсөлтийг хангах нийгмийн тэгш орчин бүрдүүлэх, хүн амын орлогыг нэмэгдүүлж, ядууралд өртөх эрсдлээс урьдчилан сэргийлэх, нийгмийн даатгал, халамжийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн үр ашгийг дээшлүүлэх зэрэг Монгол Улсын эдийн засаг нийгмийн хөгжилд түлхэц болохуйц олон арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үзэж байна.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд салбарын тусгай сангуудын хөрөнгө, даатгал, халамж, хөдөлмөр эрхлэлт болон ахмадын асуудал эрхэлсэн төв, орон нутгийн байгууллагуудын үйл ажиллагааны зардал, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт хэрэгжиж буй Үндэсний хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэх зардал, салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, их засварын зардлууд багтдаг бөгөөд 2008 онд “Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хууль”-иар 343,8 тэрбум төгрөг, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуулиар 104,6 тэрбум төгрөг, Нийгмийн даатгалын тухай хуулиар сангийн орлого 299,3 тэрбум, сангийн зарлага 428,3 тэрбум буюу нийт зарлага 876,7 тэрбум төгрөгөөр, орлого 316,1 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөн байна.

2008 оны батлагдсан төсвийн нийт урсгал зардлыг дараах хуваарилалтаар зарцууллаа:

- 48,8 хувь буюу 428,3 тэрбум төгрөгийг нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн зардалд,
- 17,3 хувь буюу 151,6 тэрбум төгрөгийг халамжийн сангаас нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлт үйлчилгээ, өрх гэр, хүн амын орлого нэмэгдүүлэх, амьжиргааг дээшлүүлэх зорилгоор хүүхэд, эх, гэр бүлд олгох мөнгөн тусламжийн зардал,
- 1,9 хувь буюу 16,4 тэрбум төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах арга хэмжээнд
- 11,9 хувь буюу 104,6 тэрбум төгрөг Монгол улсыг хөгжүүлэх сангаас хүүхэд бүрт улирал тутам олгох 25.0 мянган төгрөгийн санхүүжилт,
- үлдсэн 20,0 хувь буюу 175,8 тэрбум төгрөгийг төсөвт байгууллагуудын үйл ажиллагаа болон төвлөрсөн арга хэмжээ, хөрөнгө оруулалтын зардалд зориулсан байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль, ТБУСТХ, Монгол Улсын 2007 оны Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль, тогтоомжид нийцүүлэн төсвийн зарлага, санхүүжилтийн гүйцэтгэлийн тайланг аймаг, нийслэлийн харъяа төсөвт байгууллагуудаас авч нэгтгэн хуульд заасан хугацаанд Сангийн яам болон Үндэсний аудитийн газарт хүргүүлэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

болон Нийгмийн халамжийн сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Нөхөн олговрын сангийн зарцуулалтад Үндэсний аудитийн газраар үнэлгээ хийлгүүлэн ажлын зөвлөмж гаргуулан өгсөн зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гаргаж ажиллаа. Сайдын багцын 2007 оны санхүүгийн үйл ажиллагааны нэгдсэн тайланд Үндэсний Аудитын Газраас өгсөн шаардлага зөвлөмжийн дагуу ажлын гүйцэтгэлийн тайлан бичиж хүргүүлэв.

2008 оны жилийн эцсийн байдлаар Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын төсвийн гүйцэтгэл 838,1 тэрбум төгрөг буюу төсөвлөгдсөн урсгал зардлын 95,5 хувийн гүйцэтгэл гарч 38,6 тэрбум төгрөгийн хэмнэлттэй байна. Гэвч энэ нь хөдөө орон нутагт алслагдмал газар нутагтай сумдын айл өрхийн хүн ам нь ондоо багтаж тэтгэмжийн мөнгөө аваагүйтэй холбоотой, өр үүсгэж байна.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны төвлөрсөн арга хэмжээ, үндэсний хөтөлбөр болон төслийн зардалд 2008 оны төсвийн тухай хуулиар 310,4 сая төгрөг батлагдсанаас Үндэсний хөтөлбөрт арга хэмжээний зардалд 248,4 сая төгрөг, төвлөрсөн арга хэмжээний зардалд 62.0 сая төгрөг төлөвлөгдсөн байна. Гүйцэтгэлээр 298,6 сая төгрөгийн хөрөнгө зарцуулж, төсөл, хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээг санхүүжүүлснээс гадна Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэх заалтын дагуу Монголын ахмадын холбоо, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд, Монголын хараагүйчүүдийн үндсэний холбоо зэрэг байгууллагуудтай гэрээ байгуулан зарим арга хэмжээг санхүүжүүлж ажиллав.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2639,0 сая төгрөгийн хөрөнгө тусгагдснаас 2008 оны гүйцэтгэлээр 2079,0 сая төгрөг зарцуулж, 78,8 хувийн гүйцэтгэлтэй бөгөөд 21,2 хувь буюу 560,0 сая төгрөгөөр тасарч байгаа нь Дархан-Уул аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний конторын барилгын төсөвт өртөг нь хүрэлцээгүйгээс, Хан-Уул дүүргийн ХХҮХ-ийн конторын барилга нь газрын асуудал шийдэгдээгүйгээс, яамны барилгын өргөтгөлийн төсөвт өртөг хүрэлцээгүй зэрэг шалтгаанаас буцааж татагдсан байна.

Орон гэргүй иргэдийг гэржүүлэхээр Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын багцад батлагдсан 750,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэгч болох Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалт үйлдвэрлэлтэй гэрээг байгуулан 500 гэр бэлтгүүлж 337,5 сая төгрөгийн санхүүжилт олгосон бол “Богд өргөө” ХХК тендерт шалгаран 610 гэр нийлүүлэхээр 412,5 сая төгрөгийн санхүүжилт олгож, хот хөдөөгийн айл өрхийг гэр оронтой болгох нийгмийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд чухал хувь нэмэр оруулсан байна.

Монгол Улсын 2008 оны Төсвийн тухай хуульд тусгагдсан Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын багцад батлагдсан улсын төсвийн хөрөнгөөр 2008 онд хэрэгжүүлэх Сонгинохайрхан дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн барилгын их засварт 268,8 сая, тохижилт тоног төхөөрөмжинд зориулан 95,0 сая, Хан-Уул дүүргийн Хараагүйчүүдийн сургалт үйлдвэрлэлийн төвийн их засварт 265,0 сая, мөн дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн барилга угсралтын ажилд 180,0 сая, БЗД-ийн ХХҮХ-ийн тохижилт тоног төхөөрөмжинд 25,0 сая, Баянхонгор аймгийн ХХҮХ-ийн тохижилт тоног төхөөрөмжинд 25,0 сая, яамны тоног төхөөрөмжинд 40,0 сая төгрөгийн тендер шалгаруулан хөрөнгө оруулалт хийж 942,8 сая төгрөгийн ажил гүйцэтгэлээ.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт улсын төсвийн хөрөнгөөр 2008 онд хэрэгжүүлж буй зарим төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн хугацаанаас өмнө, шуурхай гүйцэтгэгдэж байгаагаас шалтгаалан тусгагдсан хөрөнгийн санхүүжилтийн хуваарьт зарим өөрчлөлтийг хийх шаардлагатай болсныг Сангийн яам, холбогдох газруудад уламжлан шийдвэрлүүлж Монгол Олсын 2008 оны төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулах зарим арга хэмжээний тухай Сангийн сайдын 2008 оны 147 дугаар тушаалаар дуваарьт өөрчлөлт оруулан гүйцэтгэгдсэн гэрээтэй хөрөнгө оруулалтын ажлуудыг санхүүжүүлж ажилласан байна.

ЗУРГАА. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН:

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт гадаад орон, олон улсын байгууллагатай хэрэгжүүлэх хамтын ажиллагааг яамны болоого, стратегитай уялдуулан хөгжүүлэх, өргөжүүлэх, гадаад харилцааны үр өгөөжийг дээшлүүлэхэд анхаарч ажиллалаа.

Хоёр талт болон олон хамтын ажиллагааны талаар:

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Д.Дэмбэрэл БНЧУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Иржи Неквасилийг өөрийнх нь хүсэлтээр хүлээн авч уулзсан уулзалтыг зохион байгуулж, тэмдэглэл хөтлөв. Талууд цаашид БНЧУ-д хөдөлмөр эрхлэх зорилгоор ажлын виз мэдүүлж буй Монгол иргэдийг зохион байгуулалтад оруулж, шаардлагатай зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх асуудлаар хамтран ажиллахаар тохиролцов. Уулзалт ярианы тэмдэглэлийн хувийг ГХЯ болон Прага дахь ЭСЯ-нд хүргүүлэв. Энэхүү уулзалтын үр дүнд Чех улсад ажиллаж, амьдарч байгаа монгол иргэдийн даатгалын асуудлыг зохицуулсан хэлэлцээрийг боловсруулж, хоёр Засгийн газрын хооронд байгуулах асуудал, Иргэд харилцан хөдөлмөр эрхлэх тухай хэлэлцээрийг хэрэгжүүлэх, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдыг Чехэд айлчлуулах зэрэг асуудлыг урагшлуулах талаар хоёр тал ажиллахаар тохиров.

Дээрх уулзалтын мөрөөр гадаадад ажиллах хүч гаргах асуудлаар БНЧУ-ын ЭСЯ-ны консул Х.Давид, БНПУ-ын ЭСЯ-ны консул Л.Ванат нартай уулзах тус яамны Хөдөлмөрийн бодлого, зохицуулалтын газрын даргын уулзалтыг зохион байгуулж, энэ чиглэлээр цаашид хамтран ажиллахаар тохиролцов. Энэ хүрээнд Монголоос ажиллах хүч авах асуудлаар БНУУ болон БНЧУ-аас ирүүлсэн тодорхой саналуудыг судлан хариу өгч, “Гадаадад ажиллах хүч илгээх төв”-тэй холбоо тогтоолгов.

Монгол, Чехийн Засгийн газар хоорондын комиссын ээлжит хуралдааныг энэ оны 4 дүгээр улиралд Улаанбаатар хотноо хийхээр төлөвлөж байгаатай холбогдуулан Иргэд харилцан хөдөлмөр эрхлэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг тохиролцох, Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах тухай саналыг Гадаад хэргийн яаманд хүргүүлэв.

ХБНГУ-ын Парламентын Төрийн нарийн бичгийн дарга Франц Теннес тэргүүтэй ХБНГУ-ын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төлөөлөгчид 2008 оны 5 дугаар сарын 14-нд Монгол Улсад айлчлав. Төлөөлөгчдийг НХХ-ийн дэд сайд С.Чинзориг хүлээн авч уулзан, хамтын ажиллагааны асуудлаар ярилцлаа. Дээрх уулзалт, ярилцлагын мөрөөр НХХ-ийн сайдыг 2009 онд ХБНГУ-д айлчлуулах, залуучууд

солилцооны хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх гэрээг шинэчлэн байгуулах, яам, агентлаг, хөдөлмөрийн биржийн ажилтнуудыг сургалтанд хамруулж чадавхийг нь бэхжүүлэх, Сэргээн засалтын үндэсний төвд хэрэглэж байгаа герман тоног төхөөрөмжийг ажиллуулах мэргэжилтэн бэлтгэхэд туслалцаа авах зэрэг санал тавьж, тоног төхөөрөмжийн дэлгэрэнгүй жагсаалтыг Берлинд суугаа ЭСЯ-аар дамжуулан хүргүүлэв.

Монгол-Казахстаны Засгийн газар хоорондын комиссын хамтарсан 5 дугаар хуралдааныг зохион байгуулах асуудалд оны эхнээс анхаарч бэлтгэл ажлыг хангаж ажиллав. Хуралдаан 2008 оны 4 дүгээр сарын 24-25-нд Казахстаны нийслэл Астана хотод болж, хуралдаанд монголын хэсгийн дарга Д.Дэмбэрэл тэргүүтэй төлөөлөгчид оролцов. Хуралдааны протоколд Хөдөлмөрийн яамд хоорондын хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах, 1993 оны хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулах асуудалд анхаарах тухай тусгасан байна.

Бүгд Найрамдах Казахстан Улсын Хөдөлмөрийн яамтай хамтын ажиллагааны Санамж бичиг байгуулах талаар ажиллаж, төсөл боловсруулан Казахстаны талд 3 дугаар сард гардуулсан бөгөөд Казахстаны Ерөнхийлөгч Н.Назарбаевын Монголд хийсэн төрийн айлчлалын үеэр хоёр улсын Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд нар гарын үсэг зурж байгуулав. Хоёр яамны хооронд хамтын ажиллагааны Санамж бичиг байгуулсан нь Казахстан Улстай ойртон нягтарч ажиллахад чухал алхам болов. Казахстан Улстай 1993 онд байгуулсан Нийгэм хангамжийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг манай тал санаачилж сүүлийн хэдэн жил ярьж ирсэн бөгөөд Казахстаны тал энэ асуудлаар байгуулах протоколын төслийг боловсруулж, 2 дугаар сард ирүүлсэнтэй танилцаж, яамны санал хүргүүлэв.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди Казахстан, Кыргызстан, Финланд улсуудтай хамтран ажиллах Засгийн газар хоорондын комиссын монголын хэсгийн даргаар томилогдсонтой холбогдуулан холбогдох төлөөлөгчидтэй уулзалт зохион байгуулав. Монгол, Кыргызийн ЗГХК-ын ээлжит хуралдааныг 2008 оны 12 дугаар сарын 5-10-ны үеэр Улаанбаатар хотод хийхээр урьдчилан товлож, Кыргызийн талтай ярилцав. Кыргызийн тал энэ хугацаанд хуралдаанууд хийж амжихгүй бөгөөд ирэх оны 3 дугаар сард Монгол улсад хийх Ерөнхий сайдынхаа айлчлалтай нэгтгэж хийхийг санал болгосныг манай тал хүлээн авч урьдчилсан байдлаар тохироа.

ОХУ-тай байгуулсан Санамж бичгийн дагуу Иргэд харилцан хөдөлмөр эрхлэх тухай хэлэлцээрийн оросын талын төсөлд хариу санал бэлтгэж 3 дугаар сард дипломат шугамаар хүргүүлэв. Энэхүү хэлэлцээрийн асуудлыг олон жилийн турш ярилцсан боловч манай талын идэвх, санаачлага дутаж цаг хугацаа их алдсаныг тэмдэглэх нь зүйтэй. Оросын тал манай талын саналын хариу болгож, энэ 11 дүгээр сард дээрх хэлэлцээрийн хариу төслийг ирүүлсэн бөгөөд хэлэлцээрийн төслийг орос хэлнээс монгол хэлнээ орчуулж, яамны газар хэлтсүүдээс санал авад байна. ОХУ-д их, дээд сургууль төгсөж, мэргэжил эзэмшсэн боловч Монголд ажил, хөдөлмөр эрхлэх бололцоогүй байгаа хүн олон байдаг бөгөөд дээрх хэлэлцээр байгуулагдвал эдгээр хүмүүс ОХУ-д мэргэжлээрээ хөдөлмөр эрхлэх бололцоо нээгдэх тул манай тал хэлэлцээрт ач холбогдол өгч, ойрын үед хэлэлцээрийг байгуулах нь зүйтэй юм.

Бүгд Найрамдах Буриад улсын Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Хамаганова Н.Н тэргүүтэй төлөөлөгчдийг Монгол Улсад айлчлуулах ажлыг зохион байгуулж, хоёр яам хооронд хамтран ажиллах тухай протоколд гарын үсэг зурав.

Хамтын ажиллагааны протоколд талууд байнгын холбоотой байж, туршлага солилцох замаар хүн амын нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах, ахмад настны болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн халамж дэмжлэг үзүүлэх, талуудын эмчилгээ сувилгааны газруудад иргэдийг эмчилж сувилах зэрэг асуудлыг тусгав. Санамж бичигт тохирсон ёсоор хоёр тал улирал тутам ахмадуудыг солилцож байгаа болно. Цаашид хөрш зэргэлдээ Буриад улстай бусад салбарт хамтран ажиллах талаар манай тал судлах, санал боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Унгарын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын газрын дарга Карой Пириши 2007 оны 11 дүгээр сард Монголд хийсэн айлчлалынхаа хариу болгож, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Д.Баярсайханыг Унгарт айлчлахыг урьж урилга ирүүлэв. Д.Баярсайхан тэргүүтэй 4 хүний бүрэлдэхүүнтэй тус газрын төлөөлөгчид 2 дугаар сард Унгарт айлчилж, цаашдын хамтын ажиллагааны арга хэмжээний талаар ярилцаж тохирлоо.

Будапешт хотноо 2007 оны 11 дүгээр сарын 26-30-нд болсон Монгол-Унгарын Засгийн газар хоорондын комиссын 2 дугаар хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, тус комиссын монголын хэсгийн дарга, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн Дэд сайд С.Чинзориг батлав. Энэхүү төлөвлөгөөг ГХЯ-аар дамжуулан бусад яам, газруудад хүргүүлж, төлөвлөгөөний дагуу зарим ажлыг эхлүүлэв. Төлөвлөгөөний хүрээнд Монгол Улсын Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Унгарын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Моника Лампертийг Монгол улсад айлчлахыг албан ёсоор урьсан боловч Унгарын тал ажлын боломжоос шалтгаалан айлчлалыг хойшлуулах санал тавьсан байна.

НХХ-ийн сайд Д.Дэмбэрэлээс БНСУ-ын Хөдөлмөрийн сайд Ли, Ёнг Хид сайдын албан тушаалд томилогдсонд нь баяр хүргэж, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэхийг зөвшөөрөх тогтолцооны дагуу БНСУ-д ажилчид илгээх тухай Монгол Улсын Нийгмийн бамгаалал бөдөлмөрийн яам, БНСУ-ын Хөдөлмөрийн яам хооронд байгуулсан Харилцан ойлголцлын Санамж бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар хамтран ажиллах эрмэлзэлтэй байгаагаа илэрхийлсэн захидлыг орчуулж, хүргүүлэв.

Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр 2008 оны 10 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд БНСУ-д албан ёсны айлчлал хийсэн бөгөөд айлчлалын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди ажиллав. Айлчлалын үеэр НХХ-ийн сайд Т.Ганди солонгосын талтай БНСУ-д ажилчид илгээх тухай хөдөлмөрийн яам хоорондын хамтын ажиллагааны Санамж бичигт гарын үсэг зурав. Сөүл хотноо болсон “Гурван талт зөвшилцлийн асуудлаарх Азийн 2008 оны чуулга уулзалт”-д оролцож, үг хэлсэн байна.

БНСУ-д томилогдсон хөдөлмөрийн атташе нар үүрэгт ажилдаа орсон бөгөөд тэднийг НХХ-ийн сайд хүлээн авч уулзан хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны болон эрхэлж буй ажилдаа анхаарах зүйлийн талаар зохих мэдээлэл өгсөн байна.

Арабын Нэгдсэн Эмират Улстай 2007 оны 11 дүгээр сарын 25-нд Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын албан ёсны айлчлалын үеэр байгуулсан Ажиллах хүчний салбарт хамтран ажиллах тухай Засгийн газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичгийг хэрэгжүүлэх талаар анхаарч ажиллав. Санамж бичгийг хэрэгжүүлэхийн тулд түүнд заасны дагуу Хамтарсан хороог байгуулах талаар санал бэлтгэж ГХЯ-нд хүргүүлэв.

Монгол-Египетийн Засгийн газар хоорондын комиссын анхдугаар хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх мэдээллийг бэлтгэж, ГХЯ-нд хүргүүлэв. Мөн түүнчлэн 4 дүгээр сарын 18, 19-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо болсон Монгол-Египетийн улс төрийн зөвлөлдөх уулзалтын үеэр Монголын хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын мэргэжилтэн, ажилтнуудын чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн уг арга хэмжээг цаашид үргэлжлүүлж, салбарын хэмжээнд тулгамдаж буй асуудлуудаар жил бүр сургалт зохион байгуулж манай мэргэжилтнүүдийг хамруулах асуудлыг тавих саналыг хүргүүлэв

Монгол Улсын Ерөнхийлөгчийн АНУ-д хийсэн айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу АНУ-ын Аляскийн байнгын санд Засгийн газрын төлөөлөгчдийг айлчлуулж, туршлага судлуулах ажлыг зохион байгуулав. Үүнд санхүүжилтийн асуудлыг Дэлхийн банкинд хандан шийдвэрлүүлсний зэрэгцээ уг асуудлаар НХХ-ийн дэд сайд С.Чинзориг Дэлхийн банкны суурин төлөөлөгчтэй уулзалт хийж, тодорхой асуудлаар ярилцсан байна.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайд С.Чинзориг Сингапурын Элчин сайд ноён Ча Тай Кеонг болон түүний орлогч Тадэүз Хү нарыг хүлээн авч уулзсан уулзалтыг зохион байгуулж, орчуулгаар хангав. Дэд сайд С.Чинзориг Монгол улсын хөдөлмөр, нийгмийн хамгааллын тогтолцоо, төрөөс явуулж байгаа бодлого, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тулгамдсан асуудлуудын талаар танилцуулж, Сингапурын холбогдох яамтай холбоо тогтоох, хамтын ажиллагаа хөгжүүлэх, Сингапурын нийгмийн хамгааллын хуримтлалын сангийн хөрөнгө оруулалтын менежмент хийдэг арга туршлагаас суралцах, салбарын ажилтнуудын чадавхийг дээшлүүлэх чиглэлээр дэмжлэг авах саналыг Элчин сайдад тавсан бөгөөд Элчин сайд Ча Тай Кеонг энэ талаар санаачлага гаргаж, дэмжиж ажиллахаа илэрхийлэв.

Туркийн Элчин сайд А.Асым Акар өөрийн хүсэлтээр Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Гандитай уулзаж, шинэ албан тушаалд томилогдсонд нь баяр хүргээд, Станбул хотноо 2008 оны 11 дүгээр сард зохион байгуулагдах Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлаарх бүсийн олон улсын 5 дугаар бага хуралд оролцохыг урьсан байна. Уг бага хуралд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн Дэд сайд болон Хөдөлмөрийн бодлого, зохицуулалтын газрын дарга нарыг оролцуулах бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулав.

Япон Улсын Засгийн газрын хөгжлийн албан ёсны тусламжийн хүрээнд хөгжлийн судалгаа, 2009 оны хамтын ажиллагаа, 2010 оны буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжүүлэхээр тавих “Нийгмийн даатгал-Таны ирээдүйн баталгаа” төслийн саналыг тус яамнаас боловсруулж, Сангийн яаманд хүргүүлэв.

БНХАУ-ын мэргэжилтэй ажилчдыг Монгол Улсад хөдөлмөр эрхлүүлэх тухай хэлэлцээр байгуулах асуудлаар НХХЯ-наас авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх мэдээллийг бэлтгэж, холбогдох газар хүргүүлэв.

НХХ-ийн Дэд сайд С.Чинзоригоос холбогдох газруудад хандаж, хүсэлт тавьсны дагуу Швейцарийн Холбооны Улсад тус яамны төлөөлөгчид явж ажиллах асуудлыг зохион байгуулав. Нийгмийн даатгалын салбарын 4 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид Швейцарийн нийгмийн даатгалын тогтолцоо, арга ажиллагаатай

танилцах аялалыг 3 дугаар сарын 27-ноос 4 дүгээр сарын 2-нд Швейцар улсад зохион байгуулав.

Олон улсын байгууллагатай хамтран ажиллах талаар:

Швейцарийн Женев хотноо 2008 оны 5 дугаар сарын 28-наас 6 дугаар сарын 13-нд хуралдсан Олон улсын хөдөлмөрийн бага хурлын 96 дугаар чуулганд Монгол Улсын Засгийн газар, МҮЭ-үүдийн холбоо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны төлөөлөгчдийг оролцох ажлыг зохион байгуулав. Тус чуулганаар ОУХБ-ын Удирдах зөвлөл, Ерөнхий захирлын илтгэлүүд, түүний дотор Ерөнхий захирлын “эвлэлдэн нэгдэх эрх чөлөө ба хамтын гэрээний” сэдвээр бэлтгэсэн илтгэл, ОУХБ-ын хөтөлбөр, төсөв, ОУХБ-ын конвенциуд, зөвлөмжүүдийн хэрэгжилтийн байдал зэргийг хэлэлцэв.

Чуулганд оролцсон манай улсын гурван талт төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Засгийн газраас НХХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга О.Байгалмаа, Монгол Улсаас НҮБ-ын Женев дэх салбар болон бусад олон улсын байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч, Элчин сайд Д.Болдбаатар, НХХЯ-ны Хөдөлмөрийн бодлого зохицуулалтын газрын дарга, мөн яамны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга, Женевт суугаа БТГ-ын зөвлөх, ажил олгогч эздийн байгууллагаас МАОЭНХ-ны Гүйцэтгэх захирал, Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийн орлогч захирал, үйлдвэрчний эвлэлийн байгууллагаас Улаанбаатар хотын Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга нар оролцлоо.

Санхүү, Хөдөлмөрийн стандартын хэрэгжилт, Хөдөөгийн хөдөлмөр эрхлэлт, Ур чадвар, ОУХБ-ын чадавхийг бэхжүүлэх гэсэн асуудлаар тус тусдаа хороо байгуулагдан хуралдсан бөгөөд манай төлөөлөгчид голчлон хөдөөгийн хөдөлмөр эрхлэлт болон ур чадварын асуудлаархи хорооны хуралд анхаарч оролцов. Чуулганы үеэр улс орнуудын төлөөлөгчид цалин хөлс бага, ур чадвар доогуур, хөдөлмөрийн үр өгөөж бага байхад эдийн засгийн өсөлтийг хангах, ядуурлыг бууруулах болон зохистой хөдөлмөрийн тухай ярихад ч бэрхшээлтэй байгаа тухай дурьдаж байв. Ур чадварыг хөгжүүлэхэд зориулан хөрөнгө оруулалт хийх нь нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх асуудал бөгөөд бүтээмжийг дээшлүүлэх, өсөлтийг хангах, ажлын байр нэмэгдүүлэх улмаар эдийн засгийг хөгжүүлэхэд чухал хөшүүрэг бий болгох юм

ОУХБ-ын 29, 87, 98, 100, 105, 111, 122, 123, 138, 144, 182 дугаар Конвенциудын хэрэгжилтийн тухай тайлан илтгэлүүдийг холбогдох бодлогын газруудаас авч нэгтгэн монгол хэлнээс англи хэлэнд орчуулж, ОУХБ-д хүргүүлэв. Ингэснээр манай улсын илтгэлүүдийн 2006 оноос хойшхи өр дарагдаж байгаа бөгөөд цаашид цаг тухайд нь илтгэлээ бэлтгэн өгч байх бололцоотой боллоо.

ОУХБ-тай хамтран 2006 онд Зохистой хөдөлмөрийг дэмжих орны хөтөлбөрийн 2 жилийн хэрэгжилтийн байдалд үнэлгээ хийх ОУХБ-ын ажлын баг 10 хоног Монголд ажиллав. ОУХБ-ын Бээжин дэх төвийн захирал хатагтай Констанс Томас, Бангкок дахь Бүсийн төвийн бүсийн хөтөлбөрийн шинжээч ноён Октавианто Пасарибу (Oktavianto Pasaribu), Норвеги дахь Скэнтийм пүүсийн ахлах мэргэжилтэн ноён Карстейн Хаабег нарын ажлын баг яамны холбогдох дарга, ажилтнуудтай уулзаж, хөтөлбөрийн 2 жилийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, урьдчилсан дүнг танилцуулав. Ажлын багийнхан манай талаас цагаач ажилчдын хууль эрх зүйн орчин, гурван талт тогтолцоог сайжруулах, хөдөлмөр, нийгмийн бодлого боловсруулах үйл явцад гурван

талт оролцоог дээшлүүлэх, цалин хөлсний бодлогыг сайжруулах, аль болох мэргэжилтнүүдийг татан оролцуулах, хандивлагчид болон хөгжлийн түншүүдийн хоорондын уялдаа холбоо, зохицуулалтыг сайжруулах шаардлагатай байгаа талаар дүгнэлт хийсэн болно.

Швейцар Улсын Женев хотноо болсон НҮБ-ын Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хорооны ээлжит хуралдаанаар Монгол Улсын Засгийн газрын 5, 6, 7 дугаар тайлан илтгэлийг хэлэлцүүлсэнтэй холбогдуулан хорооноос гаргасан санал, зөвлөмжийг урьдчилсан байдлаар хүлээн авч, төлөөлөгчдийн илтгэх хуудсыг Засгийн газарт танилцуулав.

Монгол Улсын Ерөнхий сайдын Европын Холбоонд хийх ажлын айлчлалын үед хэлэлцэх асуудал болон Монгол Улс-Европын холбооны хооронд хамтран ажиллах дунд хугацааны хөтөлбөрийн төсөлд тусгуулах саналыг боловсруулж, ГХЯ-нд хүргүүлэв. Үүнд Европын Холбооны улсуудад иргэдийн харилцан хөдөлмөр эрхлэхийг зөвшөөрөх, иргэдийг нийгмийн хамгааллын тогтолцоонд хамруулах, нийгмийн даатгал, шимтгэлийн асуудлыг харилцан ашигтайгаар шийдвэрлэх, тэтгэврийн тогтолцоог боловсронгуй болгох, тэтгэврийн сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалтад ашиглах эрх зүйн орчин бүрдүүлэх, чадавхи бэхжүүлэх талаар хамтран ажиллах, салбарын боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, хөдөлмөрийн төв бирж байгуулахад дэмжлэг авах, ядуурлыг бууруулах, хөдөөгийн хөгжлийн асуудлаар хамтран ажиллах, дэмжлэг тусалцаа авах зэрэг санал тавив.

Тогтвортой хөгжил, сайн засаглалыг урамшуулах тусгай хөнгөлөлт (GSP+)-ийг 2009-2011 онд үргэлжлүүлэх хүсэлтийг Европын комисст тавьж байгаатай холбогдуулан Олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенциудын хэрэгжилтийн талаарх манай улсаас хамгийн сүүлд өгсөн илтгэлүүдийн хувийг Үйлдвэр, худалдааны яаманд англи хэлээр орчуулан хүргүүлэв. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хэрэгжилтийн тухай 7 дугаар тайлан илтгэл (39 хуудас), Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн талаархи 4 дүгээр тайлан илтгэл (119 хуудас), Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийн талаархи 3 дугаар тайлан илтгэл, ОУХБ-ын 29, 87, 98, 100, 111, 182 дугаар илтгэл, нийтдээ 274 хуудас илтгэл хүргүүлэв. Эдгээр илтгэлийг ҮХЯ-наас Европын комисст гардуулж, материал бүрдүүлснээр манай улс Тогтвортой хөгжил, сайн засаглалыг урамшуулах тусгай хөнгөлөлт (GSP+)-ийг 2009-2011 онд үргэлжлүүлэх эрхтэй болов. Ингэснээр манай бизнесийн салбарынхан Европын холбооны худалдааны болон тарифийн хөнгөлөлтийг эдэлж байна.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди Азийн хөгжлийн банкны төлөөлөгч Адриан Рутенберг, Азийн хөгжлийн банкны Эрүүл мэндийн мэргэжилтэн Клауд Бодарт, Дэлхийн банкны суурин төлөөлөгч Аршад Сайед, АНУ-ын Элчин сайд Марк Минтон, ОУХБ-ын Бээжин дэх товчооны захирал Констанс Томас, Тайванийн төлөөлөгч Эдмунд Ценг нарыг хүлээн авч уулзсан болон НХХ-ийн дэд сайд С.Чинзориг Оманы Элчин сайд Абдулла Салех Аль Сааде, Саудын Арабын Элчин сайд Яахиа Бин Абду Аль Карим Аль Зайд нарыг хүлээн авч уулзсан уулзалтыг зохион байгуулж, орчуулгаар ханган, уулзалт ярианы тэмдэглэл хөтлөв.

Индонезийн Бали арал дээр 2008 оны 10 дугаар сарын 13-15-нд болсон Ази, Европын уулзалт (ASEM)-ын Хөдөлмөрийн сайд нарын 2 дугаар бага хуралд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд оролцов. Ази, Европын 46 улсыг эгнээндээ

нэгтгэсэн энэ уулзалтын гишүүнээр манай улс 2006 онд элссэн байна. Сайдын бага хуралд оролцсон үр дүнгийн тухай илтгэх хуудсыг Засгийн газарт танилцуулав.

Олон улсын цагаачлалын байгууллагын Чех улс дахь салбар БНЧУ-д ажиллаж, амьдарч байгаа монгол иргэдийн асуудлаар судалгаа хийсэн бөгөөд тус байгууллагын төлөөлөгчдийн Монголд хийсэн айлчлалыг зохион байгуулав. Тэдний мэдээлж байгаагаар 6000 орчим монгол иргэн Чехэд хууль ёсоор хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ба 12000 гаруй иргэн хууль бусаар оршин сууж байгаа тул эдгээр иргэдийн талаар тодорхой арга хэмжээ авахыг яаманд хүсэлт болгов.

НХХЯ, ОУХБ, Японы Засгийн газар хамтран “Үндэсний ур чадварын стратеги” сэдэвт уулзалт-семинарыг Улаанбаатар хотноо 3 дугаар сарын 4-5-нд зохион байгуулав. Уулзалт-семинарын мөрөөр Монголын үндэсний ур чадварын стратеги болон түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг англи хэлнээ орчуулж, ОУХБ-д хүргүүлэв. ОУХБ-ын дэмжлэгтэйгээр 5 сарын 11-18-ны өдрүүдэд Сингапур, Малайз улсуудад зохион байгуулсан “Ур чадварын хөгжил, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний туршлага судлах танилцах аялал”-д НХХЯ, ХХҮГ болон Нийслэлийн хөдөлмөрийн биржийн 7 төлөөлөгч оролцож, туршлага судлав.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн 2005-2010 оны үндэсний хөтөлбөрийн явц, хэрэгжилтийн байдлыг хэлэлцэх гурван талт бага хурлын үр дүнг дүгнэж, цаашид авах арга хэмжээний тухай, ОУХБ-ын Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенцийн хэрэгжилтийн тайлан, “Цалингийн судалгааны төсөл”-ийн саналыг тус тус орчуулж, ОУХБ-ын Бээжин дэх товчоонд хүргүүлэв.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Суурин төлөөлөгч Пратиба Мехтаг Монголд ажиллах хугацаа нь дууссантай холбогдуулан Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Д.Дэмбэрэл хүлээн авч уулзан салбарын тэргүүний ажилтан цол тэмдэг гардуулах арга хэмжээ болон Ядуурлын судалгаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих-II төслийн баримт бичигт гарын үсэг зурах үйл ажиллагааг зохион байгуулж, орчуулгаар хангав.

ДОЛОО. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР АВСАН АРГА ХЭМЖЭЭ, ҮР ДҮН

7.1.Нээлттэй байдал, мэдээлэл сурталчилгааны талаар:

“Нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулах тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 97 дугаар зарлиг, Засгийн газрын 2007 оны 190 дүгээр тогтоолоор баталсан журмыг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулж, салбарын хэмжээнд төлөвлөгөө гарган ажиллав. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам энэ жилийн нээлттэй хаалганы өдрийг “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт иргэдээс санал авах өдөр” уриан дор өргөн хүрээнд олон нийтийг хамруулах хэлбэрээр зохион байгууллаа.

Нээлттэй хаалганы өдөрлөгийн үеэр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүд ажил олгогч байгууллагуудаас 3789 байрны захиалга хүлээн авч, нийт 1462 ажилгүй иргэдийг ажлын байранд зуучлах үйлчилгээг үзүүлснээс нийслэлд 567 хүн хамрагдлаа. Шинээр 371 ажлын байр бий болж, жижиг зээлд 261 хүн хамрагдахаар хүсэлт гаргасныг шийдвэрлэв. Говь-Алтай, Сүхбаатар, Төв, Баянзүрх, Сонгино-

хайрхан дүүрэгт нийтийг хамарсан ажилд 142 хүнийг бүртгэн эрхийн бичиг олгож, хөдөлмөр эрхлээгүй 814 иргэнийг мэргэжлийн сургалтад хамруулахаар бүртгэв. Энэ өдөр халамжийн үйлчилгээний чиглэлээр тэтгэвэр тэтгэмжинд 4898 хүн хамрагдсан байна.

Түүнчлэн сайн дурын даатгал, тэтгэвэр тогтоолт, нэрийн данс, хөдөлмөрийн чадвар түр алдсаны болон жирэмсэн амаржсаны тэтгэмж, иргэний эрүүл мэндийн даатгал, ажилгүйдлийн тэтгэмж, БНСУ-д гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн шимтгэлийн буцаан олголт зэрэг нийгмийн даатгалын хууль эрх зүйтэй холбоотой олон төрлийн асуудалд нийгмийн даатгалын байцаагч, мэргэжилтнүүд арга зүйн зөвлөгөө өгч, 10318 иргэнийг хамруулав. Тухайлбал, тэтгэвэр тогтоолт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоох асуудлаар 1618 хүнд зөвлөгөө өгч, 539 иргэнийг шинээр сайн дурын даатгалд хамруулан, 203 иргэнд эрүүл мэндийн даатгалын гэрчилгээ олгов. Нийт 126 иргэний хөдөлмөрийн дэвтрийн баталгаажуулалтын асуудлаар үзлэг хийж, 202 иргэнд нэрийн дансны, 217 иргэнд тэтгэмжийн даатгалын, 130 хүнд гадаадад ажиллаж буй иргэдийн нийгмийн даатгалын асуудлаар зөвлөгөө өгсөн байна.

Ийнхүү “Нээлттэй хаалганы өдөр”-т НХХЯам, Улсын нийгмийн даатгалын болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дүүргүүдийн хэлтсийн нийт ажилтнууд оролцож, иргэдэд мэдээлэл хүргэх, санал бодлыг нь сонсох, төрийн үйлчилгээ үзүүлэх, холбогдох хууль тогтоомж, гарын авлага түгээх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр үйл ажиллагаагаа сурталчилах зэрэг олон хэлбэрийн ажлыг зохион байгуулсанаас гадна аймаг, дүүргийн нийгмийн даатгалын болон хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга нарын ажлын тайланг хоёр дахь жилдээ иргэдэд тавиулж, үнэлэлт, дүгнэлт өгүүлэв.

2008 онд Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийгмийн хамгааллын салбарт дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх чиглэлээр авч буй арга хэмжээ, үйл ажиллагааг олон нийтэд хүргэх зорилт тавин ажиллаа. Үүний хүрээнд төвийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй харилцаа холбоогоо өргөжүүлж, 3 телевиз, 8 сонин хэвлэл болон Монголын Үндэсний олон нийтийн радиотой хамтран ажиллах гэрээг байгуулан графикийн дагуу сурталчилгааны ажлуудыг хийсэн байна. Тухайлбал,

- Нийгмийн халамжийн тухай багц хуулинд орсон нэмэлт өөрчлөлт, Нийгмийн даатгалын тухай багц хуулинд орсон нэмэлт өөрчлөлт, төрийн албан хаагчийн цалин, тэтгэврийг 20 хувиар нэмсэн, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 108.000 болгон нэмэгдүүлсэн, гадаадаас манай улсад ажиллах иргэдийн квот, зэрэг нийгмийн хамгааллын салбарын бодлого чиглэл, түүний хэрэгжилтийн талаар телевизийн мэдээ, тодруулга ярилцлага 56, сонины нийтлэл ярилцлага 40 гаруйг нийтлүүлж олон нийтэд хүргэлээ.
- Таны үгийг сонсоё (МҮОНТ), Засгийн газрын 100 хоногийн хүрээнд юу амжуулав (MN-25), Өнөөгийн Монголын гэр бүлийн хөгжлийн чиг хандлага (TV-9), Нийгмийн хамгааллын талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ түүний үр дүн (TV-5), Цаг үе-Бид Хөдөлмөр эрхлэлт (МҮОНТ), Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт (МҮОНТ) зэрэг сэдвээр нээлттэй хэлэлцүүлэг, шууд нэвтрүүлэг, ярилцлагыг 12 удаа хийлгэж, сайд, дэд сайд, ТНБД болон холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулсан байна.

- МҮОНР хамтран “Хүн төвтэй нийгмийн хамгаалал” 15 минутын нэвтрүүлгийг долоо хоног бүрийн Лхагва гаригийн 15.20 цагаас нийт 51 нэвтрүүлэг бэлтгэн цацуулжээ. Мөн тус радиогийн долоо хоног бүрийн Пүрэв гаригт “Нийгмийн цаг” теле сэтгүүл шууд нэвтрүүлэгт нийгмийн хамгаалал, даатгал, гадаад хөдөлмөр эрхлэлт, тэтгэвэр, тэтгэмж зэрэг асуудлаар иргэдийн сонирхсон асуултанд хариулт өгсөн 6 удаагийн нэвтрүүлгийг явуулав.
- Нийгмийн хамгааллын салбарын ажилтны өдөрт зориулж Зууны мэдээ, Өнөөдөр, Өдрийн сонин зэрэг өдөр тутмын сонин хэвлэлд тус салбарын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, цаашдын бодлого зорилтын талаар сонины 1 нүүр, “Нээлттэй хаалга”-ны өдрийг зохион байгуулахад иргэд хөдөлмөрчдийг өргөнөөр оролцуулах, тэдний санал бодлыг сонсох, үйлчлэх зорилгоор Зууны мэдээ, Зууны шуудан, Өнөөдөр сонингуудад 1/2 хэмжээтэй сурталчилгааны нүүр бэлтгэн нийтлүүлэв.
- Ажлын байрны аттестатчилал түүний явц, үр дүн, “Уул уурхайн салбарт албан бусаар хөдөлмөр эрхэлж буй иргэдийн үзлэгийн дүн, тэдгээрт үзүүлж буй нийгмийн үйлчилгээ” зэрэг асуудлаар хэвлэлийн бага хурлыг 4 удаа зохион байгууллаа.
- Хүн амын хөгжил, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр зохион байгуулагдсан “Өнөөгийн Монголын гэр бүлийн хөгжлийн чиг хандлага” онол практикийн бага хурал, Ахмад настны Жендерийн мэдрэмжтэй бодлого Үндэсний семинар, Эрүүл мэндийн даатгалын шинэчлэлийн талаар салбарын тулгамдаж буй асуудлууд семинар, Насанд хүрээгүй хүн ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтын үндэсний хэлэлцүүлэг, Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах чиглэлээр төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудтай хийсэн уулзалт, Хараа хяналтгүй, орон гэргүй, тэнэмэл, орон гэргүй хүүхдүүдийн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээ зэрэг сургалт, семинарын үйл ажиллагааг цаг тухайд нь хамтран ажилладаг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр сурталчилсан байна.

Нийгмийн хамгааллын салбарын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, цаашдын арга хэмжээний талаар иргэд, олон нийтэд мэдээлэл өгөхөд хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчдийн оролцоог хангах зорилгоор “Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбар-Хэвлэл мэдээллийн оролцоо” сэдэвт уулзалтыг 2008 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулав. Уулзалтад телевиз радио, сонины 46 сэтгүүлч, зураглаач нар оролцов. Уулзалтын үеэр “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр дэвшүүлсэн зорилт, түүнийг хэрэгжүүлэхэд хэвлэл мэдээллийн оролцоо, хамтын ажиллагаа” сэдвээр Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди мэдээлэл хийж, мөн “Хүн амын болон нийгмийн хамгааллын талаарх бодлого, түүний хэрэгжилт ба цаашдын зорилт”, “Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн салбарын өнөөгийн байдал”, “Нийгмийн даатгалын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” сэдвээр газрын дарга нар мэдээлэл өгч, харилцан санал бодлоо солилцсон нь салбарын ил тод байдлыг хангахад зохих үр дүнтэй ажил боллоо.

Дээрх уулзалтанд оролцсон сэтгүүлчдэд нийгмийн даатгал, нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр иргэдэд ямар үйлчилгээг иргэдэд хэрхэн хүргэдэг талаарх зөвлөмж, ХАБЭА-н тухай хууль зэрэг гарын авлага, материалаг түгээв. Мөн уг арга хэмжээнд НХХЯ-ны харьяа газар, агентлагийн удирдлагууд оролцож сэтгүүлчдэд холбогдох мэдээллийг өгч, цаашид хамтран ажиллах талаар санал

бодлоо солилцсон нь үр дүнтэй арга хэмжээ боллоо. Тухайлбал, Яам нээлттэй болох зорилтын хүрээнд мэдээллийг эх үүсвэрээс нь чөлөөтэй авах боломжоор хангах, мэдээлийн эргэх холбоог хангаж иргэдийн санал бодлыг солилцох, яамны бодлого, үйл ажиллагааг олон нийтэд хүргэж сурталчлах, олон нийтийн дунд зөв ойлголт бий болгох, иргэдийн дунд эргэлзээтэй байгаа асуудлаар сурвалжлага хийх, хэлэлцүүлэг явуулах, салбарын ололт амжилт, алдаа дутагдлын талаар мэдээлэх зэрэг асуудлаар талууд цаашид хамтран ажиллахаар боллоо.

Тайлант хугацаанд сурталчилгааны ажлын нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, иргэд олон нийтэд мэдээллийг хүргэхэд ММ агентлаг, TV9, ТМ, MN-25, UBS, Зууны мэдээ, Өнөөдөр, Өдрийн сонин, МОНЦАМЭ, Монголын радио зэрэг зарим хэвлэл мэдээллийн байгууллагууд гол үүрэгтэй оролцлоо.

7.2. Албан бичиг шийдвэрлэлтийн талаар:

Яамны албан хэрэг хөтлөлтийн ажлыг тусгай программын дагуу явууллаа. Удирдах дээд болон бусад байгууллагуудаас 2008 онд 12 дугаар сарын 22-ны байдлаар нийт 4789 бичиг ирснээс 1404 бичигт карт нээж, 837 бичгийг шууд шилжүүлсэн, 2548 бичиг нь яамнаас явуулсан бичгийн хариу байна. Хяналтын карт нээсэн 1353 бичгийн хариуг шийдсэн буюу 96.3 хувийн биелэлттэй байна.

Тайлант хугацаанд яамнаас 2417 албан бичгийн бүрдлийг хангаж, холбогдох газруудад хүргүүлсэн байна. Яамны 2007 оны харилцсан албан бичгийг цэгцлэн архивт шилжүүлэв.

Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын албанаас 2008 онд явуулах хяналт шалгалтын батлагдсан хуваарь, удирдамжийн дагуу Үндэсний архивын газраас зохион байгуулсан шалгалтад хамрагдаж, ирүүлсэн дүгнэлтийн мөрөөр арга хэмжээ авч ажиллаж байна.

7.3. Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдал:

Тайлант хугацаанд яаманд УИХ, ЗГХЭГ, төв, орон нутгийн иргэдээс 2008 онд нийт 824 өргөдөл, гомдлыг бичгээр хүлээн авч, хяналтын карт нээн хуулийн хугацаанд хариу өгч ажиллав. Иргэдээс ирүүлсэн 824 өргөдөл, хүсэлтийн 54.6 хувь буюу 450 өргөдөлд яам албан бичгээр хариу өгч, 44.5 хувь 367 өргөдлийг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагад шилжүүлсэн, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 99,2 хувьтай байна.

Тайлангийн хугацаанд яаманд Ерөнхийлөгчийн Тамгын газраас 14, Улсын Их Хурал болон Улсын Их Хурлын гишүүдээс 89, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 50, Төрийн албаны зөвлөлөөс 2, Хүний эрхийн үндэсний комисс 1, бүгд 156 өргөдлийг тус яаманд уламжлан ирүүлснээс холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж, дүнг улирал бүр гаргаж, холбогдох газруудад хүргүүлж ажиллав.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын иргэдтэй хийх уулзалтыг 15 удаа зохион байгуулж, тэмдэглэл хөтлөн, сайдаар баталгаажуулан, архивын нэгжид бэлтгэв. Сайд Д.Дэмбэрэл 78 иргэн, сайд Т.Ганди 5 удаагийн уулзалтаар 72 иргэдийг хүлээн авч уулзан санал, хүсэлтийг сонссон байна. Ахмад дайчдад ойрын хугацаанд орон сууц олгох, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах, хүүхдээ гадаадад

ажиллах, оюутны сургалтын төлбөрт дэмжлэг хүссэн, гэр болон орон сууц олгуулах, ажилтай болгох, эмчилгээний зардал хүссэн зэрэг 80 гаруй хүсэлтийг шийдвэрлэсэн байна.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаманд 2008 онд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд Мэдээлэл, судалгаа, үнэлгээний газраар анализ-шинжилгээ хийлгүүлж, дүнг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулав.

----- оОо -----